

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-51
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	52-144
	1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	54-121
	2.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар/	121-144

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы
2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газар, Улсын онцгой комиссоос улс орон даяар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан, С.Одонтуяа, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Х.Болорчулуун, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат, Төсвийн байнгын хорооны дарга Б.Жавхлан, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Н.Алтанхуяг, С.Ганбаатар, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр нар Төрийн ордны “Их хуралдай” танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан чуулганы нэгдсэн хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 74 гишүүнээс 44 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Өнөрболор, У.Хүрэлсүх, Ш.Раднаасэд;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Н.Учрал;

Тасалсан: Д.Бат-Эрдэнэ;

Хоцорсон: Ц.Анандбазар -30 минут, Э.Бат-Амгалан -30 минут, Г.Мөнхцэцэг -30 минут, Б.Бейсен-55 минут, С.Бямбацогт-50 минут, Д.Ганбат-30 минут, Х.Ганхуяг-40 минут, Ж.Мөнхбат-56 минут, С.Одонтуяа-1 цаг 20 минут, Ц.Сэргэлэн -35 минут, Ч.Хүрэлбаатар-1 цаг, Д.Цогтбаатар-20 минут, Л.Энх-Амгалан-40 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн бичгээр ирүүлсэн горимын саналыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Нийгмийн бодлогын байнгын хороонд, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв.

Мөн Коронавируст халдварын цар тахлын үед эдийн засгийн хүндрэлийг даван туулах, цаашид сэргээх бодлого, арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан, зохион байгуулалтын арга хэмжээг авч, 2021 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах асуудлыг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэх нь зүйтэй гэж үзэв.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар "Их хуралдай" танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга

Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 68.Ажлын хэсгийн гаргасан,Төслийн 94 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 94.2 дахь хэсэг нэмэх:

“94.2.Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 94.1-д зааснаас гадна хэрэг, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой судалгаа хийх чиг үүрэг бүхий гурав хүртэлх судлаач туслахтай байх бөгөөд судлаач туслах нь хууль зүйн магистраас дээш зэрэгтэй, харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	9
Бүгд:	53

83.0 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 100 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“100 дугаар зүйл.Шүүхийн сахилгын хороо

100.1.Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороо /цаашид “Сахилгын хороо” гэх/ ажиллах бөгөөд улсын хэмжээнд нэг байна.

100.2.Сахилгын хороо орон тооны есөн гишүүнээс бүрдэнэ.

100.3.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

100.4.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилох бөгөөд эдгээр гишүүн шүүгчээр ажиллаж байгаагүй иргэн байна.

100.5.Нийт шүүгчийн чуулган энэ хуулийн 79.12, 79.13, 79.14, 79.15, 79.16, 79.17, 79.18-д заасан журмаар Сахилгын хорооны шүүгч гишүүнийг нийтээрээ, чөлөөтэй, шууд, тэгш сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, олонхын саналаар сонгоно. Улсын Их Хурал энэ хуулийн 79.1, 79.2, 79.3, 79.4, 79.5, 79.6, 79.7, 79.8, 79.9, 79.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.

100.6.Сахилгын хорооны шүүгч гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах болон үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай дэгийг Нийт шүүгчийн чуулган батална.

100.7.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах журмыг Байнгын хороо энэ хуульд нийцүүлэн батална.

100.8.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн гишүүн, шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан иргэн орохыг хориглоно.

100.9.Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх бөгөөд зөвхөн нэг удаа сонгогдож, томилогдоно. Сахилгын хорооны гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

100.10.Сахилгын хорооны шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

100.11.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Сахилгын хорооны даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

100.12.Сахилгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэргийг дангаар болон хамтын зарчмаар хянан хэлэлцэж, илээр санал хурааж, шийдвэрээ олонхын саналаар гаргана.

100.13.Сахилгын хорооны дарга, гишүүн нь хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шударга байх, төвийг сахих, хууль дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, гишүүний нэр хүндээ эрхэмлэх зарчмыг баримтална.

100.14.Сахилгын хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан

байна.

100.15.Сахилгын хорооны гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

100.16.Сахилгын хорооны дарга, гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа этгээд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар өгөх, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

100.17.Сахилгын хороо ажлын албатай байх бөгөөд бүтэц, орон тоо, үйл ажиллагааг зохицуулах дүрэмтэй байна.

100.18.Сахилгын хороо бие даасан төсөвтэй байх бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана.

100.19.Сахилгын хороо хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна.

100.20.Сахилгын хорооны шийдвэр хууль ёсны, үндэслэл бүхий байх бөгөөд захирамж, тогтоол, магадлал хэлбэртэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ш.Адьяшаа, Ц.Туваан, Ж.Ганбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	42
Татгалзсан:	13
Бүгд:	55

76.4 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 101 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“101 дүгээр зүйл.Сахилгын хорооны зөвлөгөөн

101.1.Сахилгын хорооны нийт гишүүнээс бүрдсэн Сахилгын хорооны зөвлөгөөн ажиллана.

101.2.Сахилгын хорооны зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

101.2.1.Сахилгын хорооны хөдөлмөрийн дотоод журмыг хуульд нийцүүлэн батлах;

101.2.2.гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн, Сахилгын хорооны хуралдаан болон хянан үзэх хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/ даргалагчийн дарааллыг тогтоох;

101.2.3.Сахилгын хорооны гишүүнийг мэргэшүүлэх сургалтыг төлөвлөх, зохион байгуулах;

101.2.4.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо сонгох;

101.2.5.сахилгын хэрэг, өргөдөл, мэдээлэл, гомдол хүлээн авах, хуваарилах болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх гишүүн, бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг энэ хуулийн 19.3, 19.4-д заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн батлах;

101.2.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай журмыг энэ хуульд нийцүүлэн батлах;

101.2.7.Сахилгын хорооны зөвлөгөөний дэгийг тогтоох;

101.2.8.Сахилгын хорооны гишүүн гурван сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх бол чөлөө олгох;

101.2.9.Сахилгын хорооны ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;

101.2.10.энэ хуулийн 40.4, 51.8-д заасан саналыг хянан үзэж, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, энэ хуулийн 40.5-д заасны дагуу шүүгчийн бүрэн эрхийг сэргээх;

101.2.11.Сахилгын хорооны ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг батлах;

101.2.12.энэ хуулийн 85.8, 120.2-т заасан журам, энэ хуулийн 100.17-д заасан дүрмийг батлах;

101.2.13.Сахилгын хорооны ажлын албаны хагас, бүтэн жилийн ажлын тайланг сонсох;

101.2.14.энэ хуулийн 85.4-т заасны дагуу Ерөнхий зөвлөлийн гишүүнд сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх, сахилгын хэрэг үүсгэсэн тохиолдолд хараат бус шинжээч томилох;

101.2.15.энэ хуулийн 102.2.6-д заасан мэдээлэлтэй танилцах;

101.2.16.энэ хуульд заасан бусад.

101.3.Сахилгын хорооны зөвлөгөөн нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг Сахилгын хорооны дарга, эсхүл гишүүдийн гуравны нэгийн саналаар хуралдуулна.

101.4.Сахилгын хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 101.2-т заасан асуудлыг зөвлөгөөнд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 12

Бүгд: 58

79.3 хувийн саналаар дэмжигдлээ.

71.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 102 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“102 дугаар зүйл.Сахилгын хорооны гишүүн, даргын бүрэн эрх

102.1.Сахилгын хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана:

102.1.1.хуралдааныг даргалах;

102.1.2.хуралдааныг товлон зарлах, хуралдуулах, сахилгын хэргийн оролцогчийг тогтоох;

102.1.3.хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг ажлын албатай хамтран зохион байгуулах;

102.1.4.бүрэлдэхүүнтэйгээр сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцэл хянан шийдвэрлэхэд оролцох;

102.1.5.бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцлийн талаар саналаа бие даан гаргах, тусгай саналтай бол бичгээр гаргаж, сахилгын хэрэгт хавсаргах;

102.1.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан дэг, журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хуралдааны дэг зөрчсөн сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээдэд хуульд заасан арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах;

102.1.7.Сахилгын хорооны даргад нэрээ дэвшүүлэх, хуульд зааснаар Сахилгын хорооны даргыг орлох;

102.1.8.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;

102.1.9.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.2.Сахилгын хорооны дарга энэ хуулийн 102.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, захирамж гаргана:

102.2.1.Сахилгын хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

102.2.2.Сахилгын хорооны зөвлөгөөнийг товлон зарлах, бэлтгэлийг хангах, хуралдуулах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

102.2.3.энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуралдааны даргалагч болон бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах;

102.2.4.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд ажлын албаар дамжуулан хариу өгөх ажлыг зохион байгуулах;

102.2.5.Сахилгын хорооны гишүүнд энэ хуулийн 101.2.8-д зааснаас богино хугацааны чөлөө олгох эсэхийг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх, хөдөлмөрийн дотоод журамд заасан

чөлөөг дангаар олгох;

102.2.6.өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр дүн, сахилгын хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Сахилгын хорооны зөвлөгөөнд мэдээлэл хийх;

102.2.7.төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсвийн төсөл боловсруулж, хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

102.2.8.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг нэгтгэж Сахилгын хорооны зөвлөгөөнд танилцуулах;

102.2.9.сахилгын хэргийн оролцогчоос гаргасан гишүүнийг татгалзан гаргах тухай хүсэлтийг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх;

102.2.10.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.3.Сахилгын хорооны даргыг түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн даргыг сонгох хүртэл Сахилгын хорооны хамгийн ахмад настай гишүүн орлоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн:	46
Татгалзсан:	17
Бүгд:	63

73.0 хувийн саналаар дэмжигдлээ.

72.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 103 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 103, 104 дүгээр зүйл болгох:

“103 дугаар зүйл.Сахилгын хорооны дарга, гишүүний үүрэг, хориглох зүйл

103.1.Энэ хуулийн 100.13-т зааснаас гадна Сахилгын хорооны дарга, гишүүн дараах үүрэгтэй:

103.1.1.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан чиг үүргээ хараат бусаар гүйцэтгэж, бусад гишүүний хараат бус байдалд хүндэтгэлтэй хандах;

103.1.2.албаны чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх;

103.1.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавих хориглолт, хязгаарлалтыг дагаж мөрдөх;

103.1.4.энэ хуульд заасан бусад үүрэг.

103.2.Сахилгын хорооны дарга, гишүүнд дараах зүйлийг хориглоно:

103.2.1.илтгэгч гишүүнээр сонгогдсоноос бусад тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах, санаачилга гаргах, зөвшөөрөх;

103.2.2.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах, албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор ашиглах;

103.2.3.өөрийн, гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдыг төлөөлөх;

103.2.4.сахилгын хэргийн оролцогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, шан харамж, зээл, эд хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл авах;

103.2.5.хараат бус, төвийг сахих байдалд харшлах улс төрийн үйл ажиллагаанд оролцох;

103.2.6.өөрийн, эсхүл бусдын ашиг сонирхлыг хангах зорилгоор албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, зохисгүй байдал гаргах;

103.2.7.энэ хуулийн 52, 53.1, 54, 55, 84.2.1-д заасан хориглосон, хязгаарласан, үүрэгжүүлсэн зохицуулалтыг зөрчих;

103.2.8.энэ хуульд заасан бусад.

103.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Сахилгын хорооны дарга, гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй:

103.3.1.өргөдөл, мэдээллийг өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд гаргасан;

103.3.2.сахилгын хэргийн оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садан, эсхүл түүнтэй хувийн харилцаатай;

103.3.3.ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон;

103.3.4.тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал.

103.4.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад Сахилгын хорооны гишүүний өөрийн, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр Сахилгын хорооны нэгээс илүү тооны гишүүнийг татгалзан гаргахыг хориглоно. Хуралдааны бүрэлдэхүүн хүрэлцэхээр байгаа бол энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр

нэгээс илүү тооны Сахилгын хорооны гишүүнийг татгалзан гарах асуудлыг шийдвэрлэж болно.

103.5.Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:

103.5.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон;

103.5.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулсан;

103.5.3.гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

103.5.4.энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн.

103.6.Сахилгын хэрэгт шалгагдаж байгаа Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ.

103.7.Сахилгын хорооны гишүүнийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан, эсхүл санал өгсөн шийдвэрийн агуулгад үндэслэн огцруулах, бусад сахилгын шийтгэл оногдуулахыг хориглоно.

104 дүгээр зүйл.Сахилгын хорооны гишүүнийг огцруулах, сахилгын бусад шийтгэл оногдуулах

104.1.Энэ хуулийн 103.5-д заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Ерөнхий зөвлөлд гаргана.

104.2.Ерөнхий зөвлөл Сахилгын хорооны гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх бөгөөд сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах шинжээч томилно.

104.3.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

104.4.Шинжээч энэ хуулийн 103.5-д заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Ерөнхий зөвлөл уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Сахилгын хорооны гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

104.4.1.Сахилгын хорооны шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар нууц санал хураалтаар шийдвэрлэх;

104.4.2.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг

Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.

104.5.Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан зөрчилд хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Сахилгын хороо оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд шалгагдаж байгаа гишүүнийг оролцуулахгүй. Зөрчлийн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн Ерөнхий зөвлөл батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, С.Чинзориг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	21
Бүгд:	66

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

73.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 104 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“104 дүгээр зүйл.Сахилгын хорооны ажлын алба

104.1.Сахилгын хорооны ажлын албаны дарга хууль зүйн дээд боловсролтой, Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

104.2.Ажлын алба Сахилгын хорооны дарга, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

104.3.Ажлын албаны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 104.3.1.ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;
- 104.3.2.ажлын албаны ажилтанг томилж, чөлөөлөх;
- 104.3.3.төсвийг захиран зарцуулах;
- 104.3.4.ажлын тайланг Сахилгын хороонд тайлагнах;
- 104.3.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

104.4.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

104.4.1.Сахилгын хороонд харьяалагдах өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч бүртгэх;

104.4.2.өргөдөл, мэдээлэл гаргагчид сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэл өгөх;

104.4.3.Сахилгын хорооны болон ажлын албаны дарга, гишүүний

өгсөн үүрэг, даалгаврыг зохих журмын дагуу шуурхай гүйцэтгэх;

104.4.4.захирамж, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, магадлал, тогтоол бэлтгэхэд Сахилгын хорооны гишүүнд туслах;

104.4.5.Сахилгын хорооны гишүүнийг шаардлагатай хууль тогтоомж, мэдээллээр хангах;

104.4.6.Сахилгын хорооны дарга, гишүүнд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

104.4.7.хуралдааны бэлтгэлийг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;

104.4.8.энэ хуульд заасны дагуу захирамж, тогтоол, магадлал, албан бичиг, бусад баримт бичгийг холбогдох этгээдэд хүргэх;

104.4.9.Сахилгын хорооноос гаргасан шийдвэрийн талаар бүртгэл хөтөлж, тайлан гаргах;

104.4.10.сахилгын хэрэг, Сахилгын хорооны шийдвэр, албан бичиг, бусад баримт бичгийг хадгалах, хамгаалах, зохих журмын дагуу архивлах;

104.4.11.хуульд заасан бусад чиг үүрэг.

104.5.Ажлын албаны дарга, ажилтан ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөхөөс гадна энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасан зохицуулалт нэгэн адил хамаарна.

104.6.Энэ хуулийн 104.5-д заасан үүргээ ажлын албаны ажилтан зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг ажлын албаны даргад, ажлын албаны дарга зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хорооны зөвлөгөөнд гаргана.

104.7.Энэ хуулийн 104.6-д заасныг зөрчсөн ажлын албаны дарга, ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 19

Бүгд: 67

71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

74.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 105 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“105 дугаар зүйл.Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл

105.1.Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хуулийн 57.1-

д заасан сахилгын зөрчлийн тухай өргөдөл, мэдээлэл /цаашид “өргөдөл, мэдээлэл” гэх/-ийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, Сахилгын хорооны хуралдаанаар хянан шийдвэрлэх, гомдол, эсэргүүцэл гаргах, гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэнэ.

105.2.Сахилгын хороо шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль дээдлэх, шударга, ил тод, хараат бус байх, өргөдөл, мэдээллийг заавал хянан шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоно.

105.3.Энэ хуулийн 108.2-т заасны дагуу сахилгын хэрэг үүсгэсэн бол өргөдөл, мэдээллээсээ татгалзсан эсэхээс үл хамааран сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.

105.4.Сахилгын хорооны хуралдаан зарлахаас өмнө өргөдөл, мэдээлэлд дурдагдаагүй шүүгчийн сахилгын зөрчлийн шинжтэй үйл баримт сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад илэрсэн бол түүнд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.

105.5.Сахилгын зөрчилд холбогдох шүүгч /цаашид “холбогдох шүүгч” гэх/, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сахилгын хэргийн оролцогч гэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	41
Татгалзсан:	26
Бүгд:	67

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

75.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 106 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“106 дугаар зүйл.Сахилгын хэргийн оролцогчийн эрх, үүрэг

106.1.Сахилгын хэргийн оролцогч сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрхтэй:

106.1.1.өргөдөл, мэдээлэл, сахилгын хэргийн баримттай танилцах, тэмдэглэл хийх, хуулбарлан авах, амаар болон бичгээр тайлбар гаргах, нотлох баримт гаргаж өгөх;

106.1.2.хуралдаанд биечлэн болон цахимаар оролцох, тайлбар гаргах, хуралдааныг хойшлуулах талаар хүсэлтийг нэг удаа бичгээр болон цахимаар гаргах;

106.1.3.Сахилгын хорооны гишүүн, хуралдааны бүрэлдэхүүнийг энэ хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргах;

106.1.4.Сахилгын хорооны гишүүний гаргасан захирамж, Сахилгын хорооны магадлалыг эс зөвшөөрвөл энэ хуульд заасны дагуу гомдол гаргах.

106.2.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах үүрэгтэй:

106.2.1.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэгийг сахих;

106.2.2.Сахилгын хорооны дуудсанаар хүрэлцэн ирэх;

106.2.3.үнэн зөв тайлбар өгөх;

106.2.4.Сахилгын хорооны шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх.

106.3.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд хуралдааны явцад дууны, дуу-дүрсний бичлэг хийх, утсаар ярихыг хориглоно. Энэ хориглолт энэ хуульд заасны дагуу хуралдааны тэмдэглэл хөтлөх зорилгоор дууны, дуу-дүрсний бичлэг хийхэд хамаарахгүй.

106.4.Согтуурсан, мансуурсан этгээдийг хуралдаанд оруулахыг хориглоно.

106.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэг зөрчсөн этгээдэд хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг хуралдаан даргалагч хуралдааны танхимаас гаргаж, энэ тухай хуралдааны тэмдэглэлд бичиж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 23

Бүгд: 67

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

76.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 107 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“107 дугаар зүйл.Өргөдөл, мэдээлэл гаргах, хүлээн авах, хуваарилах

107.1.Сахилгын зөрчил гарсан гэж үзсэн хүн, албан тушаалтан, хуулийн этгээд холбогдох шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд өргөдөл, мэдээлэл гаргана.

107.2.Өргөдөл, мэдээллийг итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргасан бол төлөөлөх эрх олгосон баримт бичиг болон итгэмжлэлийг хавсаргана.

107.3.Сахилгын хороо өргөдөл, мэдээллийг хүлээн авч, хавсаргасан баримт, хуудасны тоог бүртгэх дэвтэрт бичиж, гарын үсэг зуруулан, баримт үйлдэх ба хуудасны тоо, огноо, цаг, минутыг тэмдэглэн баталгаажуулна.

107.4.Өргөдөл, мэдээллийг хүлээн авсан даруй энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-нд хуваарилна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 18

Бүгд: 67
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

77.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 108 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“108 дугаар зүйл.Сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, гомдол хянан шийдвэрлэх

108.1.Илтгэгч гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана:

108.1.1.энэ хуулийн 57 дугаар зүйлд заасан зөрчилд хамаарахгүй бол;

108.1.2.өргөдөл, мэдээлэлд заасан үйл баримт, шүүгчийн үйл ажиллагааны талаар, эсхүл уг өргөдөл, мэдээллийн дагуу сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон Сахилгын хорооны гишүүний захирамж, Сахилгын хорооны магадлал, тогтоол, хянан үзэх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр байгаа;

108.1.3.өргөдөл, мэдээлэл гаргасан этгээд тодорхойгүй.

108.2.Илтгэгч гишүүн энэ хуулийн 108.1-д зааснаас бусад тохиолдолд өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэх тухай захирамж гаргана.

108.3.Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг гаргаснаас хойш даруй өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ. Уг захирамжийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл гаргагч Сахилгын хороонд гомдол гаргаж болно. Энэ хугацааны дотор гомдол гаргаагүй бол захирамж хүчин төгөлдөр болно.

108.4.Илтгэгч гишүүний энэ хуулийн 108.2, 109.11-д зааснаас бусад захирамжид гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон хоёр гишүүний бүрэлдэхүүн /цаашид “гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн” гэх/-тэйгээр хэлэлцэж шийдвэрлэнэ. Уг бүрэлдэхүүнд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

108.5.Илтгэгч гишүүн нь шүүгч гишүүн бол гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн нь шүүгч биш байна. Илтгэгч гишүүн нь шүүгч биш бол бүрэлдэхүүний нэг нь шүүгч, нөгөө нь шүүгч биш гишүүн байна.

108.6.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 108.5-д заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүнийг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

108.7.Гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн дараах тогтоолын аль нэгийг гаргана:

108.7.1.захирамжийг хэвээр үлдээх, эсхүл захирамжийн үндэслэлийг өөрчлөн захирамжийг хэвээр үлдээх;

108.7.2.сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг хүчингүй болгож, сахилгын хэрэг үүсгэх.

108.8.Энэ хуулийн 108.7-д заасан тогтоолыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн санал нэгтгэйгээр гаргана. Санал нэгдээгүй бол захирамжийг хэвээр үлдээнэ.

108.9.Энэ хуулийн 108.8-д заасан тогтоол нь эцсийн шийдвэр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 20

Бүгд: 67

70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

78.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 109 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“109 дүгээр зүйл.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

109.1.Сахилгын хэргийг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор, сахилгын хэргийг дахин шалгуулахаар буцааснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ хугацааг шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

109.2.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг үүсгэсний дараа доор дурдсан шалгах ажиллагаа явуулна:

109.2.1.сахилгын хэрэг үүсгэсэн захирамж, тогтоол гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор уг захирамж, тогтоолыг өргөдөл, мэдээллийн хуулбарын хамт холбогдох шүүгчид гардуулж, эсхүл энэ хуулийн 115.6, 115.7-д заасан журмаар хүргүүлж, энэ тухай баримтжуулах;

109.2.2.сахилгын хэргийн оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухайгаа баримтжуулах;

109.2.3.сахилгын хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

109.2.4.сахилгын хэргийн оролцогчийг дуудан ирүүлэх;

109.2.5.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;

109.2.6.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хугацааг энэ хуульд заасны дагуу сунгах;

109.2.7.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасны дагуу түдгэлзүүлэх, сэргээх;

109.2.8.энэ хуульд заасан бусад ажиллагаа.

109.3.Холбогдох шүүгч энэ хуулийн 108.2-т заасан сахилгын хэрэг үүсгэсэн тухай захирамж, тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээллийн талаар бичгээр хариу тайлбар, нотлох баримт, нотлох баримт гаргах хүсэлт гаргаж болно.

109.4.Нэг шүүгчид холбогдуулан гаргасан хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, эсхүл хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан нэг агуулга бүхий өргөдөл, мэдээлэлтэй хэд хэдэн сахилгын хэргийг нэгтгэн шалгаж, хянан шийдвэрлэж болно. Нэгтгэн гаргасан, эсхүл хэд хэдэн өргөдөл, мэдээлэл гаргасан болон хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан өргөдөл, мэдээллийн шаардлагатай нэг болон хэд хэдэн хэргийг тусгаарлаж болно.

109.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шаардсан нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээд илтгэгч гишүүнд гаргаж өгөх үүрэгтэй.

109.6.Илтгэгч гишүүн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1-д заасан үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ. Түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

109.7.Энэ хуулийн 109.6-д зааснаас бусад үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

109.8.Сахилгын хэрэг шалгах ажиллагаа сахилгын хэргийн оролцогчоос бусад этгээдэд хаалттай байна.

109.9.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ хуулийн 108.1, 108.2, 109.11-д зааснаас бусад асуудлаар гаргасан захирамжийг Сахилгын хорооны гишүүн ажлын гурван өдрийн дотор бичгээр гаргаж, сахилгын хэргийн оролцогчид даруй хүргүүлэх бөгөөд сахилгын хэргийн оролцогч уг захирамжийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор Сахилгын хороонд гомдол гаргах эрхтэй. Энэхүү захирамж илт үндэслэлгүй бол түүнийг гаргасан Сахилгын хорооны гишүүн хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.

109.10.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл өргөдөл, мэдээлэл гаргагч энэ хуульд заасны дагуу илтгэгч гишүүний захирамжид гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт илтгэгч гишүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг илтгэгч гишүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, захирамж гаргана.

109.11.Сахилгын хэрэг үүсгэх тухай захирамж, тогтоол гаргаснаас хойш илтгэгч гишүүн 30 хоногийн дотор дараах дүгнэлт, саналын аль нэгийг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргана:

109.11.1.сахилгын зөрчил гаргасныг нотлох дүгнэлт;
109.11.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал.

109.12.Илтгэгч гишүүн энэ хуулийн 109.11-д заасан хугацааг зайлшгүй шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 19
Бүгд: 67
71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

79.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Арван зургадугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 110, 111 дүгээр зүйл нэмэх:

“110 дугаар зүйл.Нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа

110.1.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй.

110.2.Сахилгын хороо сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах эрхтэй бөгөөд холбогдох этгээд гаргаж өгөх үүрэгтэй.

110.3.Холбогдох шүүгч хариу тайлбарын үндэслэлийн талаар нотлох баримтаа гаргаж өгөх ба гаргаж өгөх боломжгүй, түүнчлэн мэдэгдээгүй нотлох баримтын эх сурвалжийг заах үүрэгтэй.

110.4.Сахилгын хэргийн оролцогч өргөдөл, мэдээлэлтэй холбоотой нотлох баримттай хуралдаан товлороос өмнө танилцах эрхтэй.

110.5.Сахилгын хэргийн оролцогч, өргөдөл, мэдээлэл гаргагч, илтгэгч гишүүн хуурамч, хуульд заасан арга хэрэгслээр олж аваагүй нотлох баримт гаргахыг хориглоно. Энэ хэсэгт заасныг зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

110.6.Сахилгын хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.

110.7.Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл Сахилгын хорооны санаачилгаар эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно.

110.8.Нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор, тухайн сахилгын хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв талаас нь үнэлнэ.

110.9.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, эсхүл Сахилгын хорооны шийдвэрээр нэгэнт тогтоогдсон болон нийтэд илэрхий үйл баримт сахилгын хэрэг

хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.

110.10.Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хууль бус аргаар олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд Сахилгын хорооны шийдвэрийн үндэслэл болохгүй.

110.11.Сахилгын хэргийн оролцогчийн гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн, сахилгын хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэсэн байна.

110.12.Энэ хуулийн 110.11-д заасан этгээд өөрийн тайлбарт холбогдох өөрт байгаа болон гаргах боломжтой нотлох баримтыг өгнө.

110.13.Гэрчээр дуудагдсан этгээд Сахилгын хороонд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй.

110.14.Гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, эсхүл зориуд худал мэдүүлэг өгсөн бол хуульд заасан хариуцлага оногдуулна.

110.15.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

110.16.Дараах хүнийг гэрчээр дуудах болон мэдүүлэг авч болохгүй:

110.16.1.үүргээ гүйцэтгэх замаар хэргийн нөхцөл байдлыг мэдэх болсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч;

110.16.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.

111 дүгээр зүйл.Бичмэл нотлох баримт

111.1.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.

111.2.Бичмэл нотлох баримтыг Сахилгын хороонд эх хувиар нь, хэрэв тухайн баримтын эх хувийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Сахилгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн баримтын эх хувийг шаардан авах эрхтэй.

111.3.Төрийн байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 23

Бүгд: 67

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

80.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 112, 113 дугаар зүйл нэмэх:

“112 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт

112.1.Тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд илтгэгч гишүүн өөрийн санаачилгаар, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр шинжээч томилж болно.

112.2.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

113 дугаар зүйл.Тэмдэглэл

113.1.Сахилгын хорооны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх тохиолдолд хуралдааны тэмдэглэл үйлдэнэ.

113.2.Хуралдааны тэмдэглэлийг ажлын алба хөтөлж, хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа гишүүн албажуулна.

113.3.Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, эхэлсэн, дууссан цаг, ажиллагаанд оролцсон болон байлцсан хүн нэг бүрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ.

113.4.Тэмдэглэлийг уг ажиллагаа явуулахад оролцсон болон байлцсан хүнд танилцуулах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг тайлбарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 14

Бүгд: 67

79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

81.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 110 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 114 дүгээр зүйл болгох:

“114 дүгээр зүйл.Сахилгын хорооны хуралдаанд бэлтгэх ажиллагаа

114.1.Илтгэгч гишүүн нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гаргаснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 115.1-д заасан хуралдааныг товлон зарлаж, хуралдуулна.

114.2.Хуралдаан болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг сахилгын хэргийн оролцогчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

114.3.Ажлын алба Сахилгын хорооны хуралдааны товыг бүрэлдэхүүний гишүүдэд мэдэгдэж, хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 109.11-д заасан захирамжийг холбогдох баримтын хамт хүргүүлнэ.

114.4.Сахилгын хэргийн оролцогчид Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг мэдэгдэж, энэ тухай баримт

үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Сахилгын хэргийн оролцогч Сахилгын хорооны хуралдааны товыг лавлах үүрэгтэй.

114.5.Сахилгын хорооны хуралдаанд сахилгын хэргийн оролцогч оролцож болно. Сахилгын хэргийн оролцогч хуралдаан болохоос өмнө хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирэх боломжгүй тухай хүсэлтээ бичгээр болон цахимаар ирүүлсэн бол хуралдааныг хойшлуулж болох бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх хугацаа сахилгын хэрэг үүсгэснээс хойш 90 хоногоос хэтрэхгүй.

114.6.Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг өргөдөл, мэдээлэл гаргагчид мэдэгдэж энэ тухай баримт үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Өргөдөл, мэдээлэл гаргагч нь гэрчээр дуудагдсанаас бусад тохиолдолд хуралдаанд ажиглагчаар оролцож болно.

114.7.Бүрэлдэхүүнд орсон гишүүнийг энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр татгалзан гаргах тухай сахилгын хэргийн оролцогчоос хүсэлт гаргавал тухайн гишүүнийг байлцуулахгүйгээр бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ. Бүрэлдэхүүний санал тэнцсэн тохиолдолд тухайн гишүүнийг татгалзан гаргаж, хуралдааныг хойшлуулах тухай тогтоол гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 22
Бүгд: 67
67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

82.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 111 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 115 дугаар зүйл болгох:

“115 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдаан

115.1.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүн орно.

115.2.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүний хоёр нь шүүгч биш гишүүн, нэг нь шүүгч гишүүн байх бөгөөд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

115.3.Сахилгын хорооны хуралдааныг энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу бүрэлдэхүүний аль нэг гишүүн даргална.

115.4.Сахилгын хорооны хуралдааныг доор дурдсан дарааллаар явуулна:

115.4.1.даргалагч хуралдааныг нээж, хянан шийдвэрлэх гэж байгаа сахилгын хэргийн талаар танилцуулах;

115.4.2.хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй оролцогчид хуралдааны товыг урьдчилан мэдэгдсэн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг хуралдаан даргалагчид танилцуулах;

115.4.3.сахилгын хэргийн оролцогчтой танилцаж, төлөөлөх бүрэн эрхийг шалгаж, эрх, үүргийг тайлбарлах;

115.4.4.даргалагч бүрэлдэхүүнийг танилцуулан, татгалзан гаргах эрхийг сахилгын хэргийн оролцогчид тайлбарлан өгөх;

115.4.5.сахилгын хэргийн оролцогчийн зүгээс шинээр нотлох баримт гаргаж өгөх эсэхийг асуух;

115.4.6.сахилгын хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;

115.4.7.илтгэгч гишүүн гомдол, хүсэлт, сахилгын зөрчил гарсныг нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг танилцуулах;

115.4.8.сахилгын хэргийн оролцогчийн тайлбарыг сонсох;

115.4.9.гэрчийн мэдүүлэг сонсох, нотлох баримтыг шинжлэн судлах;

115.4.10.хуралдаанд оролцогч болон илтгэгч гишүүнээс асуулт асууж, хариулт авах;

115.4.11.сахилгын хэргийн оролцогч болон илтгэгч гишүүнээс нэмэлт тайлбарыг сонссоны дараа хуралдаан завсарлаж, бүрэлдэхүүн шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох.

115.5.Зөвлөлдөх үед гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Сахилгын хорооны гишүүн санал өгөхөөс татгалзах, түдгэлзэх эрхгүй бөгөөд нэрийн эхний үсгийн цагаан толгойн дарааллаар саналаа хэлнэ. Зөвлөлдөх тасалгаанд гаргасан гишүүний санал нууц байна.

115.6.Сахилгын хорооны хуралдааныг нээлттэй явуулна. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл гишүүний санаачилгаар хуралдааныг бүрэн, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болно.

115.7.Сахилгын хорооны хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны ажилтан хөтөлж, хуралдаан даргалагч болон ажилтан ажлын долоон өдрийн дотор тэмдэглэлд гарын үсэг зурж, албажуулна.

115.8.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 115.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд нэгээс илүүгүй гишүүнийг оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 16

Бүгд: 67

76.1 хувийн саналаар дэмжигдлээ.

83.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 112 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 116 дугаар зүйл болгох:

“116 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдааны шийдвэр

116.1.Сахилгын хорооны хуралдаанаар сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

116.1.1.нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

116.1.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хүлээн авч, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

116.1.3.нотлох дүгнэлтийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээн авч, шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах;

116.1.4.шүүгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

116.1.5.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, эсхүл нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд буцаах.

116.2.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 116.1.1, 116.1.2, 116.1.3-т заасны дагуу сахилгын хэргийг шийдвэрлэж, магадлал гаргана.

116.3.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 116.1.4, 116.1.5-д заасан болон хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлаар тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.

116.4.Тогтоол, магадлал уншиж сонсгосноор хүчинтэй болох бөгөөд даргалагч, гишүүд гарын үсэг зурж, тамга дарж албажуулна. Бүрэлдэхүүнд орсон гишүүд тогтоол, магадлалд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

116.5.Сахилгын хорооны хуралдаанаас гаргах тогтоол, магадлал нь дараах агуулга бүхий удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байна:

116.5.1.удиртгал хэсэгт тогтоол, магадлалыг хэзээ, хаана гаргасан, бүрэлдэхүүнд орсон гишүүдийг нэрлэн заах;

116.5.2.тодорхойлох хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, түүний үндэслэл болон сахилгын хэргийн оролцогчийн тайлбарын агуулгыг тусгах;

116.5.3.үндэслэх хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналын талаар хууль зүйн үндэслэл, нотлогдсон байдлын талаар заах;

116.5.4.тогтоох хэсэгт сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд үндэслэсэн хуулийн холбогдох заалт, шийтгэлийн төрөл, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хэрхэн шийдвэрлэсэн болон гомдол гаргах талаар тодорхой тусгах;

116.5.5.тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байх.

116.6.Сахилгын хорооны тогтоол, магадлалыг гаргаснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

116.7.Энэ хуулийн 116.6-д заасны дагуу хүргүүлснээр магадлалыг гардан авсанд тооцох бөгөөд энэ нь гомдол гаргах хугацааг тоолох үндэслэл болно.

116.8.Энэ хуулийн 116.7-д заасны дагуу Сахилгын хорооны магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч гомдол, илтгэгч гишүүн эсэргүүцэл Сахилгын хороонд гаргаж болно.

116.9.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 116.8-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт магадлал гаргасан бүрэлдэхүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг уг бүрэлдэхүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 14

Бүгд: 67

79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

84.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 112 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 117 дугаар зүйл болгох:

“117 дугаар зүйл.Сахилгын хорооны хянан үзэх хуралдаан

117.1.Энэ хуулийн 116.8-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

117.1.1.сахилгын хэргийн оролцогчийн, эсхүл илтгэгч гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

117.1.2.магадлалын огноо, дугаар;

117.1.3.магадлалыг эс зөвшөөрсөн үндэслэл;

117.1.4.гомдол, эсэргүүцлийн шаардлага.

117.2.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх бөгөөд уг бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

117.2.1.бүрэлдэхүүний хоёр нь шүүгч гишүүн, нэг нь шүүгч биш гишүүн байх;

117.2.2.Сахилгын хорооны тухайн магадлал гаргасан бүрэлдэхүүнийг оролцуулахгүй;

117.2.3.илтгэгч гишүүнийг оролцуулахгүй.

117.3.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 117.2.1, 117.2.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол Сахилгын хорооны бусад гишүүнээс энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар хянан үзэх хуралдааны бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

117.4.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлд Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй.

117.5.Энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу томилогдсон хуралдаан даргалагч Сахилгын хорооны магадлалд гомдол, эсэргүүцэл гарсан талаар илтгэгч гишүүн, сахилгын хэргийн оролцогчид мэдэгдэж, танилцах боломжоор хангана.

117.6.Сахилгын хэргийн оролцогч гомдлоосоо татгалзсан бол гомдол гаргаагүйд тооцно.

117.7.Илтгэгч гишүүн эсэргүүцлээсээ татгалзах эрхгүй.

117.8.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор Сахилгын хорооны хянан үзэх хуралдаанаар шийдвэрлэж, дараах агуулга бүхий хяналтын тогтоолыг бүрэлдэхүүний гишүүдийн олонхын саналаар гаргана:

117.8.1.гомдол, эсэргүүцлийг хангахгүй орхиж, магадлалыг хэвээр үлдээх;

117.8.2.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалд өөрчлөлт оруулах;

117.8.3.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалыг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах;

117.8.4.гомдол, эсэргүүцлийн зарим хэсгийг хангаж, магадлалын зарим хэсгийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах.

117.9.Хянан үзэх хуралдааны товыг мэдэгдэж, хуралдаанд оролцох эрхийг хангана. Хуралдааны товыг мэдэгдсэн боловч хуралдаанд ирээгүй нь гомдлыг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

117.10.Хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцэл, магадлалын агуулгыг танилцуулсны дараа сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч гишүүний тайлбарыг сонсоно.

117.11.Бүрэлдэхүүн сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч

гишүүний тайлбарыг сонссоны дараа асуулт тавих, нэмэлт тайлбарыг сонсож, хуралдаан завсарлан зөвлөлдөх тасалгаанд орж, хяналтын тогтоол гаргана.

117.12.Хяналтын тогтоол нь уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хуулийн 118.1-д заасны дагуу гомдол гаргаснаас бусад тохиолдолд эцсийн шийдвэр байна.

117.13.Хяналтын тогтоолд магадлал, гомдол, эсэргүүцлийн агуулга, тогтоолын үндэслэл, гаргасан шийдвэрийг бичнэ.

117.14.Хяналтын тогтоолыг уншиж сонсгосноос хойш 14 хоногийн дотор тогтоолын агуулгыг бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Тогтоолыг сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчид энэ хуулийн 116.6, 116.7-д зааснаар хүргүүлнэ.

117.15.Энэ хуулийн 114 дүгээр зүйл, 115.3, 115.4, 115.5, 115.6, 115.7, 116.4, 116.5-д заасан журам хянан үзэх хуралдаанд нэгэн адил хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 18
Бүгд: 67
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

85.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 118 дугаар зүйл нэмэх:

“118 дугаар зүйл.Хяналтын тогтоолд гомдол гаргах

118.1.Хяналтын тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 119.1-д заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болно.

118.2.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

118.2.1.холбогдох шүүгч болон илтгэгч гишүүний нэр, албан тушаал, оршин суугаа газрын хаяг, утас, цахим шуудангийн хаяг;

118.2.2.Сахилгын хорооны хяналтын тогтоолын огноо, дугаар;

118.2.3.Сахилгын хорооны хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэл.

118.3.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцэлд дараах баримт бичгийг хавсаргана:

118.3.1.хяналтын тогтоолын эх хувь, эсхүл түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

118.3.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэлийг нотлох баримт;

118.3.3.итгэмжлэл.

118.4.Хяналтын тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцлийг хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн хүлээн авч, сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч шүүгчид танилцуулан тайлбар гаргуулан сахилгын хэрэгт хавсаргана.

118.5.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

118.6.Хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн нь энэ хуулийн 118.1, 118.2, 118.3-д заасан шаардлагад нийцээгүй гомдол, эсэргүүцлийг буцаах тухай захирамж гаргаж, энэ талаар хариу мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 23
Бүгд: 67
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

86.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 119 дүгээр зүйл нэмэх:

“119 дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан

119.1.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг зөвхөн дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

119.1.1.Сахилгын хорооны хянан үзэх хуралдааны товыг энэ хуулийн 116.3, 116.4, 116.6-д заасны дагуу мэдэгдээгүйн улмаас хуралдаанд зохих ёсоор оролцож чадаагүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон;

119.1.2.Энэ хуулийн 106.1-д заасан эрхийг эдлүүлээгүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон.

119.2.Хяналтын тогтоолд сахилгын хэргийн оролцогчоос гомдол, илтгэгч гишүүнээс эсэргүүцэл гаргасан тохиолдолд тухайн тогтоолын биелэлт түдгэлзэнэ.

119.3.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

119.4.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан

энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

119.5.Энэ хуулийн 119.4-т заасан бүрэлдэхүүнийг энэ хуулийн 19.2.5-д заасан журмын дагуу томилох бөгөөд тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс тогтоосон дарааллаар томилсон шүүгч даргална.

119.6.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны товыг хэргийн оролцогч, илтгэгч гишүүнд долоогоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж баримтыг сахилгын хэрэгт хавсаргана. Уг мэдэгдлийг хүлээн авсан этгээд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

119.7.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 119.1-д заасан үндэслэл байгаа эсэхийг гомдол, эсэргүүцлийн шаардлага болон татгалзлын үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх замаар тогтооно.

119.8.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийг хянан хэлэлцэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

119.8.1.хяналтын тогтоолыг хэвээр үлдээх;

119.8.2.хяналтын тогтоолыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгох;

119.8.3.сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаан, эсхүл хянан үзэх хуралдаанд буцаах.

119.9.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

119.10.Энэ хуулийн 119.9-д заасан тогтоолд доор дурдсан зүйлийг тусгана:

119.10.1.маргаж байгаа хяналтын тогтоолын тухай мэдээлэл, түүнийг гаргасан газар;

119.10.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийн агуулга;

119.10.3.шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл;

119.10.4.хяналтын тогтоолыг хэвээр үлдээсэн, эсхүл бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 119.8.3-т заасны дагуу буцаасан тухай заалт.

119.11.Энэ хуулийн 119.9-т заасны дагуу гарсан Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоол гармагц хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд эцсийн шийдвэр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 20
Бүгд: 68
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

87.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 113 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 120 дугаар зүйл болгох:

“120 дугаар зүйл.Шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл, тайлан болон шийдвэрийн ил тод байдал

120.1.Ажлын алба шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл хөтөлж, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг гаргана.

120.2.Энэ хуулийн 120.1-д заасан бүртгэл, тайланд хамаарах мэдээлэл хөтлөх журамтай байх бөгөөд тайланг цахим хуудаст байршуулна.

120.3.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.

120.4.Сахилгын хорооны магадлал, хяналтын тогтоол, Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоолыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21 хоногийн дотор цахим хуудаст байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 17
Бүгд: 68
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

88.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 114 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“114.1.Энэ хуулийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 16
Бүгд: 68
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “хуулиар” гэсний өмнө “тухайлсан” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шүүгчдийн зөвлөгөөнийг” гэсний дараа “/цаашид /“Зөвлөгөөн” гэх/ гэж, 26 дугаар зүйлийн “Нийт шүүгчдийн” гэсний өмнө “Улсын дээд шүүхийн” гэж

тус тус, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “түдгэлзүүлэх” гэсний өмнө “шүүгчийн бүрэн эрхийг” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.9 дэх заалтын “дарга” гэсний дараа “/цаашид “Гүйцэтгэх нарийн бичгийн дарга” гэх/” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	13
Бүгд:	68

80.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “шүүгчдийн зөвлөл” гэснийг “нийт шүүгчийн чуулган” гэж тохиолдол бүрд өөрчлөх, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “түүний” гэснийг “шүүгчийг” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “байгуулагдсан” гэснийг “байгуулсан” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “холбогдох” гэснийг “тухайлсан” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “мэдээлж байна” гэснийг “мэдээлнэ” гэж, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “шийдвэрлэгдсэн” гэснийг “шийдвэрлэсэн” гэж, 15.5 дахь хэсгийн “харгалзах” гэснийг “харгалзан үзэх” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “шаардан гаргуулах” гэснийг “гаргуулан авах” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “бичих” гэснийг “боловсруулах” гэж, “тогтооно” гэснийг “батална” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэснийг “сайн дураараа” гэж, Долдугаар бүлгийн гарчиг, 34 дүгээр зүйлийн гарчгийн, 37.2 дахь хэсгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 39 дүгээр зүйлийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 43 дугаар зүйлийн 43.7 дахь хэсгийн “хууль зүйн” гэснийг “хуулийн” гэж, 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын “бие махбодь гэмтсэн буюу эрүүл мэндэд нь хохирол учирснаас нас барсан” гэснийг “эрүүл мэндэд нь хохирол учирснаас амь насаа алдсан” гэж, 49.5 дахь хэсгийн “нас барвал” гэснийг “амь насаа алдвал” гэж, 51 дүгээр 51.3 дахь хэсгийн “буруутайд тооцогдсон” гэснийг “буруутай” гэж, “ямар нэгэн” гэснийг “аливаа” гэж, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “хойших” гэснийг “хойш” гэж, 73 дугаар зүйлийн 73.1.17 дахь заалтын “иргэдийн” гэснийг “хүн, хуулийн этгээдээс” гэж, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалтын “орчин үеийн” гэснийг “дэвшилтэт” гэж, 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтын “байрлуулах” гэснийг “байршуулах” гэж, 77.2.3 дахь заалтын “хуудсыг” гэснийг “хуудасны мэдээллийг” гэж, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “байх бөгөөд” гэснийг “байна.” гэж, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийн “хуралдаанаас тогтоол гаргана” гэснийг “хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна” гэж, 85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “104.1.1-104.1.5-д” гэснийг “106.1.1-106.1.4-т” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	49
Татгалзсан:	19
Бүгд:	68

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасанТөслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “бүх” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “холбогдох” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “заавал” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “/цаашид “Нийт шүүгчдийн хуралдаан” гэх/” гэснийг, 26.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг, 26.4 дэх хэсгийн “хэлэлцсэн” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.2.2 дахь заалтын “бие махбодь гэмтсэн буюу” гэснийг, 49.2.3 дахь заалтын “бие махбодь,” гэснийг, 49.4 дэх хэсгийн “гэмтсэн болон” гэснийг, 70 дугаар

зүйлийн 70.1 дэх хэсгийн “/цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 12
Бүгд: 67
82.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 18
Бүгд: 68
73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.2 дахь хэсэг нэмэх:

“4.2.Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хянан хэлэлцэхгүй.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх саналыг хойшлуулж, хуульд нийцүүлж, гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.9.Нийт шүүгчийн дийлэнх олонх оролцсоноор чуулганыг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг чуулганд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 20
Бүгд: 68
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “доошгүй” гэснийг “дээшгүй” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 17
Бүгд: 68

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	23
Бүгд:	68

66.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.6.5.4 дэх заалт нэмэх:

“25.6.5.4.Улсын дээд шүүх нь авлига, албан тушаалын, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хүн, амьтан, байгаль орчны эсрэг гэмт хэргийг хяналтын журмаар шийдвэрлэх,” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	49
Татгалзсан:	19
Бүгд:	68

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар нарын гаргасан, Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.6.5.4 дэх заалт нэмэх:

“25.6.5.4.хуулийн нэгдмэл хэрэглээг тогтооход зарчмын ач холбогдолтой бол.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	18
Бүгд:	68

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.1.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 24
Бүгд: 68
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.2.6 дахь заалт нэмэх:

“37.2.6.Улсын Их Хурал 90 хоногийн дотор танилцах сонсгол зохион байгуулсны дараа Ерөнхий зөвлөлийн дарга шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид албан бичгээр танилцуулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 20
Бүгд: 68
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.6.Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн тухайн шүүхийн Ерөнхий шүүгч гурван жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Танхимын тэргүүнийг нэг удаа улируулан томилж болно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар протоколд тэмдэглүүлэн үг хэлж, саналаа татаж авав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.4 дэх хэсэг нэмэх:

“43.4.Шүүгчид Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуульд зааснаас бусад цол, одон, тэмдэг, шагнал олгохыг хориглоно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 23
Бүгд: 68
66.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.6.Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 65 нас байна. Улсын дээд шүүхийн шүүгч бүх насаараа томилогдох бөгөөд өөрөө хүссэн тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, С.Чинзориг, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 28
Бүгд: 68
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12 дахь саналыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж татаж авав.

13.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 73 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 73.1.27 дахь заалт нэмэх:

“73.1.27.шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг орон сууцаар хангах хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх,” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 19
Бүгд: 68
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан, Төслийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“78.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, анхан болон давж заалдах шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг тухайн шатны шүүхийн шүүгчдээс сонгоно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 19
Бүгд: 68
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан, Төслийн 79 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 79.11 дэх хэсэг нэмэх:

“79.11.Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлийн дарга ахална.” гэсэн

Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 19
Бүгд: 68
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан, Төслийн 100 дугаар зүйлийн 100.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“100.5.Улсын Их Хурал Сахилгын хорооны шүүгч биш гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Төрийн албаны зөвлөлийн дарга ахална.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал хэлэв.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 16
Бүгд: 67
76.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 14
Бүгд: 67
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар:1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

1.1.анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

1.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

2/40.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 6 дахь хэсэг:

“3.Хяналтын шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргана.

5.Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.

6.Гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч, өмгөөлөгч, прокурор оролцохгүй.”

3/40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх нь анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэхийг хянана.”

4/40.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх бөгөөд шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тогтоосон журмын дагуу томилно.”

5/40.8 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцлийг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3.Хяналтын шатны шүүхийн тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Хяналтын шатны шүүхийн тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, гомдол, эсэргүүцэл болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

4.Хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд уг тогтоолд гомдол гаргахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 19
Бүгд: 67
71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “22.1.3” гэснийг “22.3” гэж өөрчилж, “3.4 дүгээр” гэсний өмнө “2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Тэргүүний шийдвэрээр” гэснийг “шийдвэрээр” гэж, “Ерөнхий шүүгчийн” гэснийг “шүүгчдийн зөвлөгөөний” гэж,” гэж нэмж, “40.10 дугаар зүйлийн 3, 4 дахь хэсгийн “хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн” гэснийг “нийт шүүгчдийн” гэж, 40.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бичгээр” гэснийг “ажлын албаны даргаар дамжуулан бичгээр” гэснийг “40.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн нь” гэснийг “Танхимын зөвлөгөөнөөс” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 17
Бүгд: 67
74.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.10, 40.11, 40.12 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 20
Бүгд: 67
70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/122 дугаар зүйлийн 122.3 дахь хэсэг:

“122.3.Хяналтын журмаар гомдол гаргасан бол хэргийг хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарах, эсхүл хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэ хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар урьд нь авсан шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ хүчинтэй хэвээр байна.”

2/173 дугаар зүйлийн 173.5, 173.6, 173.7, 173.8 дахь хэсэг:

“173.5.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.

173.6.Энэ хуулийн 173.5-д заасны дагуу гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаана.

173.7.Энэ хуулийн 173.5, 173.6-д заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.”

173.8.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохгүй.”

3/176 дугаар зүйлийн 176.4, 176.5 дахь хэсэг:

176.4.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

176.5.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 17

Бүгд: 67

74.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар

өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “бичмэл ба” гэсний дараа “цахим баримт,” гэж, 110 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 110.3 дахь хэсэг, 110.4 дэх хэсгийн “Бичмэл” гэсний дараа, мөн зүйлийн 110.1, 110.3 дахь хэсгийн “бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, 120 дугаар зүйлийн 120.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “,эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гаргасан бол” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 19

Бүгд: 67

71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.”

1/51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг:

“51.1.Анхан шат, хяналтын шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогч оролцож байгаа бол давж заалдах шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ.”

2/172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсэг:

“172.2.Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана:

172.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

172.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

172.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг:

“173.4.Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуулийн 167.5, 173.3-т

заасныг хангаагүй бол анхан шатны шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.”

4/174 дүгээр зүйлийн 174.1 дэх хэсэг:

“174.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/176 дугаар зүйлийн 176.1, 176.3 дахь хэсэг:

“176.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 114.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

176.3.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 20
Бүгд: 67
70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх “хуваарилна” гэснийг “хуваарилах бөгөөд уг журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байна” гэж, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн “шийдвэр, магадлалыг” гэснийг “шийдвэрийг” гэж, 172 дугаар зүйлийн 172.3 дахь хэсгийн “тооцож, улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох тухай шүүгч захирамж гаргана.” гэснийг “тооцно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.” гэж, 176 дугаар зүйлийн 176.4 дэх хэсгийн дугаарыг “176.6” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 19
Бүгд: 67
71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан 13 цаг 29 минутаас хуралдааныг даргалав.

Т.Аюурсайхан: 5.Ажлын хэсгийн гаргасан,Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийн “буюу хяналтын” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн, 122 дугаар зүйлийн 122.2 дахь хэсгийн “болон хяналтын” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 22
Бүгд: 67
67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан,Төслийн 5 дугаар зүйлийн “79.2 дахь хэсгийг” гэснийг “79.2 дахь хэсэг, 176², 177¹, 178¹ дүгээр зүйлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 17
Бүгд: 67
74.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “зүйл,” гэснийг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3, 4 дэх заалт болгох:

2/123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэг:

“123.2.Дараах үндэслэлээр Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргана:

123.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

123.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

123.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/124 дүгээр зүйлийн 124.3, 124.4, 124.5 дахь хэсэг:

“124.3.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.

124.4.Энэ хуулийн 124.3-т заасны дагуу гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаана.

124.5.Энэ хуулийн 124.3, 124.4-т заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.”

4/125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэг:

“125.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэг:

“127.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 105.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	22
Бүгд:	66

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий дараах хэсэг нэмсүгэй:

1/124 дүгээр зүйлийн 124.6 дахь хэсэг:

“124.6.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохгүй.”

2/127 дугаар зүйлийн 127.4, 127.5, 127.6 дахь хэсэг:

“127.4.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

127.5.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

127.6.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 18
Бүгд: 66
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан,Төслийн 2 дугаар зүйлийн “75 дугаар” гэсний өмнө “16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Ерөнхий шүүгч” гэснийг “Шүүгчдийн зөвлөгөөн” гэж,” “даргалагч” гэсний өмнө “шүүх хуралдаан” гэж,” тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 21
Бүгд: 66
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “, эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарсан” гэж нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 16
Бүгд: 66
75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “гэснийг” гэсний дараа “, 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 16
Бүгд: 66
75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 128, 129 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болгосугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 17
Бүгд: 66
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “орон тооны” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийн “байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэснийг “байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 15
Бүгд: 66
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэсний өмнө “нэмэлт,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 17
Бүгд: 66
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн ““мөн 25-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан даатгуулагч” гэсний дараа “, эсхүл 25-аас доошгүй жил Монгол Улсын шүүхийн шүүгчээр ажилласан шүүгч” гэсний дараа “мөн зүйлд “Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 17
Бүгд: 66
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсгийн “түдгэлзэнэ” гэснийг “түдгэлзэж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 15
Бүгд: 66
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Зөрчлийн тухай хууль нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хүлээхээргүй” гэснийг “хүлээлгэхээргүй” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 17
Бүгд: 66
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 16
Бүгд: 66
75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав.Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх саналын томьёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “орон тооны” гэснийг хасаж, “ТӨ-VA-ийн тусгай албан тушаалд “Монголбанкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,”” гэснийг “ТӨ-VIA-ийн тусгай албан тушаалд “Монголбанкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,”” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 17
Бүгд: 66
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав нэг.Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх саналын томьёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хавсралтыг хасах:

“1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын нэг дэх заалт, мөн тогтоолын хавсралтын гарчгийн “Үндэсний статистикийн хороо,” гэсний дараа “Шүүхийн сахилгын хороо,” гэж, мөн хавсралтын “Үндэсний статистикийн хороо” гэсэн хэсгийн дараа “Шүүхийн сахилгын хороо” гэсэн 13 дахь хэсэг, түүнд “Тэргүүн түшмэл” гэсэн ангиллын “АА-1” гэсэн зэрэглэлд “Ажлын албаны дарга” гэж, “Эрхэлсэн түшмэл” гэсэн ангиллын “АА-4” гэсэн зэрэглэлд “Хэлтсийн дарга” гэж, “АА-5” гэсэн зэрэглэлд “Ахлах референт” гэж, “Ахлах түшмэл” гэсэн ангиллын “АА-6” гэсэн зэрэглэлд “Референт” гэж, “АА-7” гэсэн зэрэглэлд “Ахлах шинжээч” гэж, “АА-8” гэсэн зэрэглэлд “Шинжээч” гэж, “Дэс түшмэл” гэсэн ангиллын “АА-9” гэсэн зэрэглэлд “Ахлах мэргэжилтэн” гэж, “АА-10” гэсэн зэрэглэлд “Мэргэжилтэн” гэж, “АА-11” гэсэн зэрэглэлд “Ахлах зохион байгуулагч” гэж тус тус хамааруулан нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 18
Бүгд: 66
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван хоёр.Монгол Улсын шүүхийн тухай тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 20.9-д заасан ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор зохион байгуулж Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 14
Бүгд: 66
78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хороо, Шүүхийн мэргэшлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 17
Бүгд: 66
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Улсын Их Хурал Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 18
Бүгд: 66
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг батлахаас өмнө Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлсэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 37.2 дахь хэсгийн зохицуулалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 15
Бүгд: 66
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэлийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар өгч санал хураалтыг хойшлуулав.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“12 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 49.7 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 14
Бүгд: 66
78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 13, 14 дүгээр зүйл нэмэх:

“13 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагуу байгуулагдах Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны 2021 оны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 16
Бүгд: 66
75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 49 минутаас хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: 8.Ажлын хэсгийн гаргасан, “14 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 75.2 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 18
Бүгд: 66
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“12 дугаар зүйл.2013 онд Шүүх байгуулах тухай хууль баталсантай холбогдуулан шүүгчээс чөлөөлөөд дахин томилоогүй шүүгч нарыг Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид дахин өргөн барьж шийдвэрлүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 19
Бүгд: 66
71.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар санал хураалгасан саналуудын зарим зүйл, хэсэг, заалтуудыг хуульд нийцүүлэх, гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 45 минут үргэлжилж, 74 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 89.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 52 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 16 минутад эхлэв.

Чөлөөтэй: С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Х.Нямбаатар, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Ч.Хүрэлбаатар, У.Хүрэлсүх, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Н.Учрал;

Тасалсан: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, Э.Бат-Амгалан, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Г.Дамдинням, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн Б.Энх-Амгалан, Т.Энхтүвшин.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх С.Янжинсүрэн, Боловсрол, шинжлэх ухааны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбаатар, мөн яамны Бага, дунд боловсролын газрын дарга Т.Ням-Очир, Санхүү, эдийн засгийн газрын дарга С.Нансалмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга А.Халиунаа нар цахимаар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Б.Эрдэнэбилэгт, Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх О.Цолмон, референт Д.Хосбаяр нар байлцав.

Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар Бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар “Их хуралдай” танхимаас мэдээлэл хийв.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат “Их хуралдай” танхимаас үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Б.Пүрэвдорж, С.Одонтуяа, Д.Ганбат нарын “Их хуралдай” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, О.Цогтгэрэл, Н.Ганибал нарын цахимаар тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар “Их хуралдай” танхимаас, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн цахимаар хариулж, тайлбар

хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар Бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 15 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн хэлтсийн референт Б.Туул, шинжээч М.Номиндулам, Э.Сувд-Эрдэнэ нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, мөн хэлтсийн ахлах референт Ч.Тунгалаа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 08 минут үргэлжилж, 74 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 66.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ЦЭНДСҮРЭН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Онцгой нөхцөлд хэрэглэх хуралдааны дэгд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүд цахим хуралдааны программыг ашиглан ирцээ бүрдүүлж, нэгдсэн хуралдаанд цахимаар оролцож байна.

Ирц 44 гишүүн чуулганд бүртгүүлж, 59.5 хувьтай байна. Ингээд ирц бүрдсэн учраас Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Индэрт ганцаараа байгаа учраас маскаа авчихъя.

Өнөөдөр өргөн баригдсан хуулиудын талаар танилцуулъя. Өргөн баригдсан хуулиудын жагсаалт.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газраас сая өргөн мэдүүллээ. Энэ хуулиудыг холбогдох Эдийн засгийн болон Нийгмийн бодлогын байнгын хороодод харьяалуулсан болно.

Хуралдаан эхлэхийн өмнө Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулан албан бичгээр үг хэлэх хүсэлтээ ирүүлсэн байна.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлгийг явуулж байгаа.

Үдээс хойших хуралдаанаар Засгийн газрын мэдээллийн цагт, Бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл сонсоно.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т Улсын Их Хурлын гишүүн энэ хуулийн 9.5-т заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх,

асуудал нэмэх горимын санал гаргах бол нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж манай худам монгол бичгээр хүсэлтээ бичиж ирүүлсэн байна. 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 12.40 цагт ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танаа.

Миний бие Бөхчулууны Пүрэвдорж 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллын талаар үг хэлэх тул зөвшөөрөл олгоно уу. Хүсэлт бичсэн Бөхчулууны Пүрэвдорж.

Уран бичлэгийн хэлбэрээр их сайхан бичсэн байна гэдгийг тэмдэглэе. Ингээд Пүрэвдорж гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Гишүүдийнхээ өнөөдрийн мэндийг айлтгая. Манай дарга ч бас худам монгол бичгээрээ сайхан унших юмаа. Тэгэхээр би 3-4 хуулийн төслийг өргөн барьсан байгаа. Ялангуяа Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалыг нөхөн төлөх энэ хууль 12 сарын 31-нээр дуусгавар болсон. Үүнийг нэг жилээр сунгах хуулийн төслийг өргөн барьсан. Та бас Коронавирусын тогтоолтой хамтатгаад Засгийн газраас 1 дүгээр улиралд багтаагаад үүнийг оруулж ирэх ийм үүрэг, чиглэлийг өгсөн байгаа.

Тэгэхээр малчид жилдээ хоёр удаа нэлээн мөнгөтэй болдог. Өөрөөр хэлбэл махаа борлуулаад нэг мөнгөтэй болдог, ноолуурын үеэр бас мөнгөтэй болдог. Энэ хүмүүс энэ жил цагаан сар хийхгүй жаахан мөнгө төргөгтэй болчихсон байх үед энэ нийгмийн даатгалаа нөхөн төлөх ийм боломж гарч байна. Тийм учраас заавал Засгийн газрыг 1 дүгээр улиралд өргөн барихыг хүлээхгүйгээр энэ миний хуулийн төслийг хэлэлцээд явчихбал маш хурдан. Энэ чинь 2-3-хан заалтад өөрчлөлт оруулаад, анхны хэлэлцүүлгээр явчих боломжтой. 1 сар дотроо багтаагаад энд өөрчлөлт оруулбал энэ малчин, хувиараа хөдөлмөр эрхэлж буй хүмүүст маш их ашигтай. Энэ хуулийн төсөл хэрэгжээд явбал олон хүмүүсийн тэтгэвэр авах боломж бүрдэнэ.

Энэ хуулийн ач холбогдлыг зарим малчид мэдэхгүй байх шиг байна. Тэгэхээр 10 жилийн тэтгэврийн нөхөн төлбөрийг ойролцоогоор 5 сая төгрөг төлөөд, жилийн дотор дунджаар 500 мянган төгрөгний тэтгэвэр авлаа гэхэд, буцаагаад жилийн дотор тэр мөнгөө тэтгэврээрээ авчих ийм боломжтой хуулийг МАН 2017 онд санаачилсан. Тийм учраас энэ хуулийг нэг жилээр нөхөн явуулах нь маш үр дүнтэй байгаа. Яагаад гэвэл малчид өнгөрсөн жил 5-6 аймаг дээр ган

болж, энэ өвөлжилтдөө бэлтгээд юун тэтгэврийн нөхөн төлбөр төлөх тийм асуудал, хамгийн гол малаа яаж өнтэй оруулах вэ? Өвс тэжээлээ яаж авах вэ гээд маш их зардлууд гаргаж байгаа.

Дээрээс нь хувиараа хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн хувьд нэг заалт нь маш хүнд байгаа. Өөрөөр хэлбэл 1990-ээд оны үед аж ахуйн нэгжийн татвар төлж байсан дэвтрийг заавал шаардаж байгаа. Энэ үед том компаниуд хүртэл татвар дээрээ хүртэл асуудалтай байсан энэ үед хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс татварынхаа дэвтрийг.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн үгээ дуусгая.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хувиараа хөдөлмөр эрхэлж байсан хүмүүс 1990-ээд онд юун тэр татварын дэвтэр мантай байсан үе. Тэгэхээр энэ дэвтрийг шаардах нь энэ хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг энэ хуулийн хамралтад оруулахад маш том саад болж байгаа. Тийм учраас 3-4 асуудлыг шийдвэрлээд энэ хуулийг энэ сардаа багтаагаад анхны хэлэлцүүлгээр маш яаралтай хэлэлцвэл малчин, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүст 2017 онд та бүхний баталсан тэр сайн хууль чинь маш үр дүнтэй болж хэрэгжиж очно.

Тийм учраас дараагийн 7 хоногийн хэлэлцэх асуудалд энэ хуулийг оруулах талаар Их Хурлын дарга анхаарч өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх хугацааг хойшлуулах тухай хуулийн төслийг оруулж ирэхийг Улсын Их Хурлаас чиглэл болгосон байгаа. Мөн үүнтэй уялдуулан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Цогт-Очирын Анандбазарын нарын гишүүн хууль санаачилж бас өргөн барьсан байгаа, Пүрэвдорж гишүүнтэй адилхан. Энэ хуулийг яаралтай хэлэлцэх нь зүйтэй. Үүнийг Тамгын газар анхааралтай аваарай.

Ингээд өнөөдөр өргөн баригдсан хуулиудыг танилцуулъя. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэнэ, өнөөдөр өглөө Засгийн газраас өргөн мэдүүллээ.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн, Хууль зүйн байнгын хороонд.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн барилаа. Энэ хуулийг Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэнэ.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн барилаа. Энэ хуулийг Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэнэ.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэнэ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

Мөн Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбоотой бөгөөд Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн. Энэ бол Коронавируст халдвар цар тахлын үед эдийн засгийн хүндрэлийг даван туулж, цаашид сэргээх арга хэмжээний тухай. Энэ дээр Эдийн засгийн болон Үйлдвэржилтийн байнгын хороод Коронавируст халдвар цар тахлын үед эдийн засгийн хүндрэлийг даван туулах, цаашид сэргээх бодлого, арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан, зохион байгуулалтын арга хэмжээг авч энэ оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах чиг үүрэгтэй Эдийн засгийн байнгын хороо, Үйлдвэржилтийн байнгын хороод оролцсон ийм ажлын хэсэг. Энэ бол гол чиглэл нь гарч байгаа. Энэ бол тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх бололцоотой төсөл, хөтөлбөрийг боловсруулах, үүнийгээ хэрэгжүүлэх ажлыг шуурхай хэлэлцэнэ. Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэнэ.

Ийм хуулийн төслүүд өргөн баригдсаныг мэдэгдье.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулаарай. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлэн явуулна.

68 дахь саналыг хураана. 137 санал хураалттай байгаа. 68, талдаа ороод өчигдөр зогссон.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар оролцож байна.

68 дугаар саналаар санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна. Санал хураалт явуулахын өмнө бүртгэлийн санал хураалт явуулна. Тест. MyParliament цахим системээр бүртгэлийн санал хураалт явуулъя.

20 гишүүн бүртгэлд орсонгүй, сая цахим системээр. Эд нарыг дуудаж шалгая, бүлэг, Булгантуяа, Сүхбаатар дарга нарыг дуудъя.

68 дугаар саналыг уншиж танилцуулна.

68.Төслийн 94 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 94.2 дахь хэсэг нэмэх:

“94.2.Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 94.1-д зааснаас гадна хэрэг, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой судалгаа хийх чиг үүрэг бүхий гурав хүртэлх судлаач туслахтай байх бөгөөд судлаач туслах нь хууль зүйн магистраас дээш зэрэгтэй, харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай байна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 53 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 83.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

69.Төслийн 100 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“100 дугаар зүйл.Шүүхийн сахилгын хороо

100.1.Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороо /цаашид “Сахилгын хороо” гэх/ ажиллах бөгөөд улсын хэмжээнд нэг байна.

100.2.Сахилгын хороо орон тооны есөн гишүүнээс бүрдэнэ.

100.3.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

100.4.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилох бөгөөд эдгээр гишүүн шүүгчээр ажиллаж байгаагүй иргэн байна.

100.5.Нийт шүүгчийн чуулган энэ хуулийн 79.12, 79.13, 79.14, 79.15, 79.16, 79.17, 79.18-д заасан журмаар Сахилгын хорооны шүүгч гишүүнийг нийтээрээ, чөлөөтэй, шууд, тэгш сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, олонхын саналаар сонгоно. Улсын Их Хурал энэ хуулийн 79.1, 79.2, 79.3, 79.4, 79.5, 79.6, 79.7, 79.8, 79.9, 79.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.

100.6.Сахилгын хорооны шүүгч гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах болон үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай дэгийг Нийт шүүгчийн чуулган батална.

100.7.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах журмыг Байнгын хороо энэ хуульд нийцүүлэн батална.

100.8.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн гишүүн, шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан иргэн орохыг хориглоно.

100.9.Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх бөгөөд зөвхөн нэг удаа сонгогдож, томилогдоно. Сахилгын хорооны гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

100.10.Сахилгын хорооны шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

100.11.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Сахилгын хорооны даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

100.12.Сахилгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэргийг дангаар болон хамтын зарчмаар хянан хэлэлцэж, илээр санал хурааж, шийдвэрээ олонхын саналаар гаргана.

100.13.Сахилгын хорооны дарга, гишүүн нь хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шударга байх, төвийг сахих, хууль дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, гишүүний нэр хүндээ эрхэмлэх зарчмыг баримтална.

100.14.Сахилгын хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна.

100.15.Сахилгын хорооны гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

100.16.Сахилгын хорооны дарга, гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа этгээд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар өгөх, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

100.17.Сахилгын хороо ажлын албатай байх бөгөөд бүтэц, орон тоо, үйл ажиллагааг зохицуулах дүрэмтэй байна.

100.18.Сахилгын хороо бие даасан төсөвтэй байх бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана.

100.19.Сахилгын хороо хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна.

100.20.Сахилгын хорооны шийдвэр хууль ёсны, үндэслэл бүхий байх бөгөөд захирамж, тогтоол, магадлал хэлбэртэй байна.”

Бат-Эрдэнэ гишүүн үг хэлэхээр санал ирүүлсэн байна. Адьшаа, Туваан, Ганбаатар гишүүд үг хэлнэ.

100.4 дээр нууц санал хураалтаар гэдгийг бүдэг хэлсэн байж магадгүй.

100.4.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилох бөгөөд эдгээр гишүүн шүүгчээр ажиллаж байгаагүй иргэн байна.

Ингээд энэ санал дэмжигдсэн тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд Сахилгын хорооны гишүүнийг томилох журмыг хуульчлах, дэгийн тухай хуульд оруулах ийм шаардлагатай болно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг бусад ер нь энэ Шүүхийн хуультай холбоотой Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлуудыг дэгээр зохицуулах шаардлагатай болсон шүү гэдэг чиглэлийг өгч байна.

Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Одоо Сахилгын хороо,Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгоно гэж байгаа юм. Энэ бол нэлээн нааштай дэвшил болж байгаа. Би бас

түрүүний санал хураалтын өмнө үг авъя гэж байсан юм. Би нэг зүйл асуух гээд байгаа нь одоо манай энэ хуулийнхны дунд гажиг гэдэг юм уу, гажуудал бий болчихоод байгаа юм. Тэр нь хуульчийн лиценз олгодог Хуульчдын холбоо гэсэн ганцхан байгууллага лиценз зөвшөөрлийг олгодог. Үүнтэй холбоотойгоор шүүх, прокурор, цаашилбал өмгөөлөгчөөр ажиллаж байгаа хүмүүс маань ний нуугүй хэлбэл бүгдээрээ нэг тал болчихсон. Ингээд шүүхийн хэрэг маргааныг шийдэхдээ энэ ард иргэдийн эрхийг ноцтой хохироодог, нэг үгээр хэлбэл хуйвалддаг гэж хэлж болохоор ийм гажуудал, гажиг тогтолцоо бий болчихсон. Тийм учраас үүнийг засаж залруулах чиглэлээр бид нар хичнээн нээлттэй сонсгол зохион байгуулаад, баруун хойд талын хар овоохой гэдэг шиг ингээд Их Хурал дайрч давшлуулж байгаа ч гэсэн үүний цаад уг үндсийг нь бид нар харж, энэ Шүүхийн тухай хууль хэлэлцэж байгаа энэ үедээ засаж залруулах чиглэлээр анхаарал тавих хэрэгтэй байна гэдэг ийм саналыг би хэлэх байна. Энэ талаар бололцоотой бол манай ажлын хэсгийн хүмүүсүүд тодорхой хариулт өгвөл үүнийг хэрхэн өөрчлөн харж, засаж залруулах чиглэлээр ямар зүйлт, заалт оруулсан бэ гэдгийг хэлж өгвөл их сайн байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Гаргасан саналаа дэмжих хэлбэрээр тайлбар утгатай үг хэлж болно. Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны хуульч биш гишүүдийг Улсын Их Хурал томилохоор энэ хуулийн төсөлд орсон байгаа. Хууль тогтоох байгууллага шүүх эрх мэдлийг өөрийнхөө мэдэлд авч байгаатай би ер нь санал нийлэхгүй байгааг удаа дараа илэрхийлсээр байгаа юм. Энэ хуулийн төсөлд байгаа хуульч биш, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг олонх, цөөнх мэргэжлийн холбоод, Ерөнхийлөгчийн институтын төлөөллийг оролцуулж, Улсын Их Хурлын гишүүн ахалж, энэ сонгон шалгаруулалтыг зохион байгуулна гэдэг энэ асуудлыг олонх, цөөнх, Ерөнхийлөгчийн институт, хуульчдын холбоодоос бүрдсэн ажлын хэсэг зохион байгуулахыг дэмжиж байгаа.

Гэхдээ Улсын Их Хурлын гишүүн ахалж үүнийг зохион байгуулна гэдгийг дэмжихгүй байгаа юм. Энэ дээр Төрийн албаны зөвлөл гэж Монгол Улсын Их Хурлын бүтцийн байгууллага байгаа. Монгол Улсын хэмжээнд төрийн албаны бүх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй энэ Төрийн албаны зөвлөл үүнийг ахалж явбал хаа хаанаа хуульд нийцсэн ийм ойлгоц болно гэсэн ийм саналыг би удаа дараа дэвшүүлж байгаа.

Тэгээд Төрийн албаны зөвлөлийн дарга, Төрийн албаны зөвлөл энэ сонгон шалгаруулалтыг ахлаад, зохион байгуулаад, сонгон шалгаруулалтаар гарч ирсэн тэр хуульч биш Сахилгын хорооны гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг харин Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж томилбол үнэхээр.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Тамгын газар Мэдээлэл технологийн хэлтэс энэ дэмжсэн, дэмжээгүй санал бол онцгой хуралдааны дэгийн үед 3 минутаар явна шүү дээ. Яагаад 2 минутаар тавиад байна.

Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Баярлалаа. Энэ Сахилгын хорооны гишүүд 9 байна, шүүгч

гишүүн байна, бусад гишүүн байна гээд. Тэгээд энд 9 хүнтэй энэ байгууллага нэлээн эрх мэдэл бүхий ийм байгууллага үүсэх юм байна л даа. Энэ юу вэ гэхээр, хариуцлага тооцох, бүр огцруулах хүртэл эрх мэдэлтэй. Тэгээд энэ шүүгчид чинь томилогддог газартай шүү дээ. Тэгээд үүнтэй нь ямар заалтаар уялдуулсан юм бэ? Одоо жишээ нь, Монгол Улсын Үндсэн хуульд байдаг заалтаар Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч нар томилогддог. Тэгээд тэр томилогдсон хүнийг нь Сахилгын хороогоор огцруулчихдаг. Энэ хоёр чинь уялдаа нь яаж хангагдаж байгаа юм. Тийм заалт нь эсхүл хойшоо орчихсон байгаа юм уу? Сахилгын хороогоор огцруулах шийдвэр гарчихсан шүүгчийг тэгнэ, ингэнэ гэсэн юм байгаа юм уу? Энэ хоёрын уялдаа яаж хангагдаж байгаа вэ? Энэ нь ерөөсөө харагдахгүй байгаа юм. Үүнийг ажлын хэсэг надад, одоо асуулт байхгүй юм чинь ажлын хэсгээс надад эндээ ингэж орсон, тэгж орсон гэдгийг хэлээд өгөөрэй.

Сахилгын хороо маань өөрөө ямар журмаар ажиллах юм, өөрөө хэлмэгдүүлэлт явуулах, нөлөөлөл явуулах байх гэдэг энэ асуудлуудыг нь, ямар ямар заалтуудаар хариуцлага тооцох юм гээд энэ асуудлуудыг нь маш тодорхой явуулахгүй бол манайхан нэг л байгууллага болоод ингээд явчхаараа мундаг эрх мэдэлтэй болоод яваад өгдөг. Тэгээд үүгээр чинь бүх шатны шүүгч нар орно гэж үзэж байгаа. Тэгээд яг ний нуугүй хэлэхэд шүүгч бус гишүүн нь олон байгаад байдаг. Тэгээд эд нар, тухайлбал Дээд шүүхийн шүүгч, давж заалдах заалтны шүүхэд нөлөөлж, хариуцлага тооцож, яг шударга ажиллана гэсэн баталгаа бас сайн харагдахгүй байгаа шүү. Үүнийг манайхан бас анхаарч үзээрэй.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би товчхон хоёр санал хэлье. Энэ Сахилгын хорооны гол чиг үүрэг нь гомдол шалгах чиг үүрэгтэй юм шиг байгаа юм. Би тэгж ойлгож байгаа юм. Тэгэхээр энэ гомдлыг шалгахдаа би бол нэлээн хариуцлагатай байгууллага гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ байгууллага маань нотлох баримт цуглуулах, шаардлагатай бол албадан гаргуулах гэдэг юм уу, тийм байдлууд нь жаахан бүдэг суусан юм уу гэж би өөрөө эсрэгээрээ харж байгаа юм. Тийм бэлгэдлийн чанартай байгууллага болоод явчих вий гэдэг дээр. Ер нь санаа бол их зөв. Ажлын хэсэг хууль тэр санааг их зөв гаргасан гэж би харсан. Тэгэхдээ тодорхой эрхүүдийг нь өгөхдөө хэт болгоомжилсон юм болов уу гэдгийг харсан шүү гэдэг санал хэлье.

Мөн Шүүхийн сахилгын хороо, Ерөнхий зөвлөл нэг дор байгуулагдах юм шиг байна. Тэгэхээр бүрэн эрх нь нэг дор дуусах магадлалтай юм шиг байна. Энэ дээр залгамж чанар нь нэг дор олон хүн томилогдоод, нэг дор бүрэн эрх нь дуусах талаас нь, би дутуу харсан байж магадгүй. Байнгын хорооны гишүүн биш, тэгээд ажлын хэсэгт ороогүй учраас зарим нарийн процедурыг хараагүй байж магадгүй гэсэн санал хэлж байна. Эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарна биз дээ гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Ер нь Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр, Үндсэн хуулийн 49.6-д хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон бусад сахилгын шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, ажиллах журмыг хуулиар тогтооно гэж заасан. Тэгэхээр энэ агуулгаар энэ бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, журам, мөн энэ Ганбаатар гишүүний хэлсэн

бүрэн эрхийн асуудал, тэр бүх юм нь хууль журмаар нарийвчлан тогтоогдох шаардлагууд гарна. Дараах заалтууд дээр гарна.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ингэж заачихсан учраас ингэж зааж байгаа юм. Сая Туваан, Бат-Эрдэнэ гишүүд асуусан. Энэ чинь ингэж байж шүүх өөрөө өөрийгөө цэвэршүүлж авч явдаг ийм механизмтай болж байгаа юм. Тэгээд шүүгч нар дотроосоо бүх нийтийн чуулганаас шүүгч гишүүд нь сонгогдож байгаа. Тэгээд бусад улсууд ч гэсэн парламентаасаа сая хүртэл Америкийн шүүгчийг сенат, конгрессоороо ороод нийтийн сонголт хийгээд томилогдож байгаа тэр зарчмуудтай нийцүүлж манай энэ Мөнхсайхан доктор олон улсын жишиг, туршлагыг ч гэсэн харгалзан үзсэн байх.

Мөн энд томилгооны сонголт хийж томилно гэж Шүүхий ерөнхий зөвлөлийн сахилгын хороон дээр гарсан шүү дээ. Түүнийг ажлын хэсэг дээр Адъяаа гишүүн анзаараагүй юм шиг байна. Тэгээд дараагийн заалтууд дээр тодорхой болох байх.

Санал хураалт.

Дашдондогийн Ганбат гишүүн 30 минут хоцорсон.

Санал хураалтад 55 гишүүн оролцож, 42 гишүүн дэмжиж, 76.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар, Цэндийн Сандаг-Очир гишүүдийн санал эсрэг гараад байна шүү. Өөрсдийнхөө саналын эсрэг, санал хураалтад оролцоно шүү.

70.Төслийн 101 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“101 дүгээр зүйл.Сахилгын хорооны зөвлөгөөн

101.1.Сахилгын хорооны нийт гишүүнээс бүрдсэн Сахилгын хорооны зөвлөгөөн ажиллана.

101.2.Сахилгын хорооны зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

101.2.1.Сахилгын хорооны хөдөлмөрийн дотоод журмыг хуульд нийцүүлэн батлах;

101.2.2.гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн, Сахилгын хорооны хуралдаан болон хянан үзэх хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/ даргалагчийн дарааллыг тогтоох;

101.2.3.Сахилгын хорооны гишүүнийг мэргэшүүлэх сургалтыг төлөвлөх, зохион байгуулах;

101.2.4.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо сонгох;

101.2.5.сахилгын хэрэг, өргөдөл, мэдээлэл, гомдол хүлээн авах, хуваарилах болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх гишүүн, бүрэлдэхүүнийг

сугалаагаар томилох нарийвчилсан журмыг энэ хуулийн 19.3, 19.4-д заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн батлах;

101.2.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай журмыг энэ хуульд нийцүүлэн батлах;

101.2.7.Сахилгын хорооны зөвлөгөөний дэгийг тогтоох;

101.2.8.Сахилгын хорооны гишүүн гурван сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх бол чөлөө олгох;

101.2.9.Сахилгын хорооны ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;

101.2.10.энэ хуулийн 40.4, 51.8-д заасан саналыг хянан үзэж, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, энэ хуулийн 40.5-д заасны дагуу шүүгчийн бүрэн эрхийг сэргээх;

101.2.11.Сахилгын хорооны ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг батлах;

101.2.12.энэ хуулийн 85.8, 120.2-т заасан журам, энэ хуулийн 100.17-д заасан дүрмийг батлах;

101.2.13.Сахилгын хорооны ажлын албаны хагас, бүтэн жилийн ажлын тайланг сонсох;

101.2.14.энэ хуулийн 85.4-т заасны дагуу Ерөнхий зөвлөлийн гишүүнд сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх, сахилгын хэрэг үүсгэсэн тохиолдолд хараат бус шинжээч томилох;

101.2.15.энэ хуулийн 102.2.6-д заасан мэдээлэлтэй танилцах;

101.2.16.энэ хуульд заасан бусад.

101.3.Сахилгын хорооны зөвлөгөөн нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг Сахилгын хорооны дарга, эсхүл гишүүдийн гуравны нэгийн саналаар хуралдуулна.

101.4.Сахилгын хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 101.2-т заасан асуудлыг зөвлөгөөнд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 58 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, 79.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

102, 103, 78, 79 дүгээр санал хураалтууд дээр Сахилгын хорооны гишүүний даргын бүрэн эрх орж байна.

71.Төслийн 102 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“102 дугаар зүйл.Сахилгын хорооны гишүүн, даргын бүрэн эрх

102.1.Сахилгын хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана:

102.1.1.хуралдааныг даргалах;

102.1.2.хуралдааныг товлон зарлах, хуралдуулах, сахилгын хэргийн оролцогчийг тогтоох;

102.1.3.хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг ажлын албатай хамтран зохион байгуулах;

102.1.4.бүрэлдэхүүнтэйгээр сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцэл хянан шийдвэрлэхэд оролцох;

102.1.5.бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцлийн талаар саналаа бие даан гаргах, тусгай саналтай бол бичгээр гаргаж, сахилгын хэрэгт хавсаргах;

102.1.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан дэг, журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хуралдааны дэг зөрчсөн сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээдэд хуульд заасан арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах;

102.1.7.Сахилгын хорооны даргад нэрээ дэвшүүлэх, хуульд зааснаар Сахилгын хорооны даргыг орлох;

102.1.8.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;

102.1.9.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.2.Сахилгын хорооны дарга энэ хуулийн 102.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, захирамж гаргана:

102.2.1.Сахилгын хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

102.2.2.Сахилгын хорооны зөвлөгөөнийг товлон зарлах, бэлтгэлийг хангах, хуралдуулах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

102.2.3.энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуралдааны даргалагч болон бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах;

102.2.4.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд ажлын албаар дамжуулан хариу өгөх ажлыг зохион байгуулах;

102.2.5.Сахилгын хорооны гишүүнд энэ хуулийн 101.2.8-д зааснаас богино хугацааны чөлөө олгох эсэхийг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх, хөдөлмөрийн дотоод журамд заасан

чөлөөг дангаар олгох;

102.2.6.өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр дүн, сахилгын хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Сахилгын хорооны зөвлөгөөнд мэдээлэл хийх;

102.2.7.төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсвийн төсөл боловсруулж, хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

102.2.8.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг нэгтгэж Сахилгын хорооны зөвлөгөөнд танилцуулах;

102.2.9.сахилгын хэргийн оролцогчоос гаргасан гишүүнийг татгалзан гаргах тухай хүсэлтийг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх;

102.2.10.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.3.Сахилгын хорооны даргыг түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн даргыг сонгох хүртэл Сахилгын хорооны хамгийн ахмад настай гишүүн орлоно.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Содномын Чинзориг гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: 102.1 дээр товчхон санал байна. 101.2.8 дээр Сахилгын хорооны зөвлөгөөнөөр Сахилгын хорооны гишүүнд 3 сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх бол чөлөө олгох гэж байгаа юм. 3 сараас дээш хугацааны чөлөөг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцэх юм гэж ойлгосон юм. Гэтэл 102.2.5 дээр 101.2.8-д зааснаас богино хугацааны чөлөөг бас Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцэнэ гээд байх юм. Урт хугацааны чөлөө олгосон ч Сахилгын хорооны зөвлөлөөр хэлэлцэх юм байна. Тэр 3 сараас дооших хугацааны чөлөө олгоход дахиад л Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцэх юм байна. Үүнийгээ жаахан ялгаж өгч болохгүй юм уу?

Тэр 101.2.8 дээр 3 сараас дээш хугацааны чөлөөг энэ Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцүүлдэг. Түүнээс дооших 101.2.8-д зааснаас богино хугацааны чөлөөг нь дарга нь дангаараа чөлөө олгодог байх ийм механизм хийж өгөхгүй бол жаахан хүндэвтэр болох юм биш үү. Урт хугацааны чөлөө олгосон ч Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцэнэ, богино хугацааны чөлөө олгосон ч заавал Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцэнэ гээд байх юм. Нэгэнт л ингэж ялгаж байгаа юм чинь тэр 101.2.8-д заасан богино хугацааны чөлөөг дарга нь дангаараа олгох ийм эрхийг нь олгоод явчихбал илүү хялбар, хөнгөн болох юм биш үү. Тэгээд урт, богино хугацааны чөлөө бүгдийг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцэх юм байна. Тэгэх юм бол заавал тэр101.2.8, 102.2.5 гэж ялгах шаардлагагүй юм шиг байх юм. Үүнийг ажлын хэсэг анхаарна биз дээ.

Г.Занданшатар: Энэ Хөдөлмөрийн дотоод журамд заасан чөлөөг дангаар олгох гэж үргэлжлүүлж байна. Таслал хүртэл салгахад чинь ингээд утга агуулгаа

өөрчлөгддөг учраас чөлөө олгоход Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх, Хөдөлмөрийн дотоод журамд заасан чөлөөг дангаар олгох гэж. Тэгэхээд үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр найруулгын хувьд нь салаа утгагүй болгох талаас нь анхаарах чиглэлийг өгье, дэмжигдсэн тохиолдолд.

Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, 73.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

72.Төслийн 103 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 103, 104 дүгээр зүйл болгох:

“103 дугаар зүйл.Сахилгын хорооны дарга, гишүүний үүрэг, хориглох зүйл

103.1.Энэ хуулийн 100.13-т зааснаас гадна Сахилгын хорооны дарга, гишүүн дараах үүрэгтэй:

103.1.1.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан чиг үүргээ хараат бусаар гүйцэтгэж, бусад гишүүний хараат бус байдалд хүндэтгэлтэй хандах;

103.1.2.албаны чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх;

103.1.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавих хориглолт, хязгаарлалтыг дагаж мөрдөх;

103.1.4.энэ хуульд заасан бусад үүрэг.

103.2.Сахилгын хорооны дарга, гишүүнд дараах зүйлийг хориглоно:

103.2.1.илтгэгч гишүүнээр сонгогдсоноос бусад тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах, санаачилга гаргах, зөвшөөрөх;

103.2.2.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах, албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор ашиглах;

103.2.3.өөрийн, гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдыг төлөөлөх;

103.2.4.сахилгын хэргийн оролцогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, шан харамж, зээл, эд хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл авах;

103.2.5.хараат бус, төвийг сахих байдалд харшлах улс төрийн үйл ажиллагаанд оролцох;

103.2.6.өөрийн, эсхүл бусдын ашиг сонирхлыг хангах зорилгоор албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, зохисгүй байдал гаргах;

103.2.7.энэ хуулийн 52, 53.1, 54, 55, 84.2.1-д заасан хориглосон, хязгаарласан, үүрэгжүүлсэн зохицуулалтыг зөрчих;

103.2.8.энэ хуульд заасан бусад.

103.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Сахилгын хорооны дарга, гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй:

103.3.1.өргөдөл, мэдээллийг өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд гаргасан;

103.3.2.сахилгын хэргийн оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садан, эсхүл түүнтэй хувийн харилцаатай;

103.3.3.ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон;

103.3.4.тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал.

103.4.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад Сахилгын хорооны гишүүний өөрийн, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр Сахилгын хорооны нэгээс илүү тооны гишүүнийг татгалзан гаргахыг хориглоно. Хуралдааны бүрэлдэхүүн хүрэлцэхээр байгаа бол энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр нэгээс илүү тооны Сахилгын хорооны гишүүнийг татгалзан гарах асуудлыг шийдвэрлэж болно.

103.5.Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:

103.5.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон;

103.5.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулсан;

103.5.3.гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

103.5.4.энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн.

103.6.Сахилгын хэрэгт шалгагдаж байгаа Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ.

103.7.Сахилгын хорооны гишүүнийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан, эсхүл санал өгсөн шийдвэрийн агуулгад үндэслэн огцруулах, бусад сахилгын

шийтгэл оногдуулахыг хориглоно.

104 дүгээр зүйл.Сахилгын хорооны гишүүнийг огцруулах, сахилгын бусад шийтгэл оногдуулах

104.1.Энэ хуулийн 103.5-д заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Ерөнхий зөвлөлд гаргана.

104.2.Ерөнхий зөвлөл Сахилгын хорооны гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх бөгөөд сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах шинжээч томилно.

104.3.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

104.4.Шинжээч энэ хуулийн 103.5-д заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Ерөнхий зөвлөл уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Сахилгын хорооны гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

104.4.1.Сахилгын хорооны шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар нууц санал хураалтаар шийдвэрлэх;

104.4.2.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.

104.5.Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан зөрчилд хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Сахилгын хороо оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд шалгагдаж байгаа гишүүнийг оролцуулахгүй. Зөрчлийн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн Ерөнхий зөвлөл батална.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Нямаагийн Энхболд, Содномын Чинзориг гишүүд.

Дашдондогийн Ганбат гишүүн хоцорсон учраас ингээд хоёр санал дээр үг хэлэх эрхгүй.

Н.Энхболд: Баярлалаа. Энэ Сахилгын хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах үүднээс нөгөө шүүгчидтэй адилхан нэг заалтууд явж байгаа шүү дээ. Хэрэв хэлэлцэх байгаа асуудлаар нь нөлөөлөх зорилгоор ямар нэгэн этгээд уулзсан, ярьсан, үүрэг даалгавар өгсөн, хүсэлт тавьсан, дарамт үзүүлсэн ийм

тохиолдолд гарвал түүнийг нь бичгээр илтгэж, Сахилгын хороонд мэдэгдэж байх тухай заалтыг хаа нэгтэй оруулах шаардлагатай санагдаж байна. Би энэ юман дотроос харсангүй. Үүнийг бас дараагийн шатны хэлэлцүүлэг дээр анхаарах боломж байгаа болов уу, байхгүй болов уу. Тэгж байж эд нар чинь шүүгчид байтугай, шүүгчдийн өөрийнх нь ашиг сонирхлын хараат бус байдлыг хангах талд ажиллаж байгаа улсууд чинь өөрсдийг нь бас тийм дарамтад оруулах аливаа үйлдлээс сэргийлсэн, хэрэв тийм юм гарсан бол түүнийгээ бас шүүгчдийн нэгэн адил мэдээлж байдаг ийм заалт энэ хуульд байх нь зүйтэй гэж санагдаад байна. Тэгж байж эд нарынхаа бие даасан хараат бусаар үйл ажиллагаа явуулах байдлыг нь хангахад томоохон хувь нэмэр, хамгаалалт болох ийм заалт болно гэж бодож байна. Үүнийг та бас бодоод, чиг өгдөг юм уу, ажлын хэсэгт анхааруулбал сайн байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Энхбаяр гишүүн ээ, тэр Нийтийн албанд хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн заалтыг түрүүн оруулчихсан байсан шүү дээ, хуулийг. Тэнд урьдчилан мэдэгдэх, бичгээр санал гаргах заалтууд байгаа шүү дээ. Түүнтэйгээ уялдуулах асуудлыг судалж үзнэ биз.

Одоо Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Дарга аа, энэ 103.6-г миний ойлгож байгаагаар Сахилгын хорооны дарга гишүүд нь өөрсдөө сахилгын хэрэгт шалгагдаж байгаа бол тэр 106.1.1, 106.1.4-т заасан эрхийг эдэлнэ гээд орж байгаа юм. Энэ заалт чинь өөрөө сахилгын хэрэгт шалгагдаж байгаа Сахилгын хорооны дарга, Сахилгын хорооны гишүүдийг яриад байгаа юм. Тэгээд тэр 106.1.1-106.1.4 чинь өөрөө сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхүүд нь байгаа юм. Тэгэхээр өөрөө Сахилгын хорооны дарга, гишүүд чинь сахилгын хэрэгт шалгагдаж байгаа атлаа сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох онцгой эрхүүдээ эдэлнэ гэж байгаа нь зөв үү, буруу юу. Энэ чинь өөрөө хэрэгт шалгагдаж байгаа хүн байж, бусдын сахилгын хэрэгт хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох эрхээ эдэлнэ гэдэг чинь ашиг сонирхлын зөрчил үүсэх үү, яах вэ гэж би жаахан эргэлзээд байгаа юм. Үүнийг ажлын хэсэг тодруулна биз дээ.

103.6 чинь Сахилгын хорооны дарга, гишүүдэд сахилгын шийтгэл шалгагдаж байгаа асуудал яригдаад байдаг. 106.1.1-106.1.4 чинь сахилгын хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд Сахилгын хорооны дарга, гишүүдийн эдлэх бүрэн эрхүүд нь байгаа юм. Өөрөө сахилгын хэрэгт шалгагдаж байгаа атлаа энэ бүрэн эрхийг хэрэгжүүлээд явах нь хир оновчтой байх вэ? Зарчим алдагдахгүй юу? Үүнийг жаахан эргэлзээд байна аа. Тэгээд ажлын хэсэг цаашдаа анхаарна биз дээ, энэ жаахан эргэлзээтэй юм байгаа.

Г.Занданшатар: Тэгэхээр нотлох баримт гаргаж өгөх, өмгөөлөгч тайлбар өгөх гээд нөгөө холбогдогчийн эрхтэй холбоотой асуудал. Тэгэхдээ ер нь өөрөө өөрийгөө хянах уу гэдэг асуудал.

С.Чинзориг: Өөрөө шалгагдаж байгаа атлаа бусдыг шалгах асуудлыг хэрэгжүүлнэ гээд байна шүү дээ.

Г.Занданшатар: Тэр чинь Үндсэн хуулиар олгогдсон эрх байгаа юм. Бүгдэд нь адилхан эрх оногдоно гэсэн үг. Тэгэхдээ гишүүнээсээ татгалзах гэсэн нэг заалт

байгаа юм. Тэр л асуудалтай.

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 68.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эцсийн хэлэлцүүлэг Нямаагийн Энхболд, Содномын Чинзориг гишүүдийн гаргасан саналыг үндэслээд Үндсэн хуулийн 54.1, 49.6 дахь заалтуудтайгаа уялдуулж, Үндсэн хуулийн зөрчилгүй байх талаас нь, энэ материал хууль, процессын хууль хоёр нийлж байгаа учраас түүнийгээ бас анхаарч, зохицуулалтаа хийх шаардлагатай гэсэн чиглэлийг өгье.

73.Төслийн 104 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“104 дүгээр зүйл.Сахилгын хорооны ажлын алба

104.1.Сахилгын хорооны ажлын албаны дарга хууль зүйн дээд боловсролтой, Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

104.2.Ажлын алба Сахилгын хорооны дарга, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

104.3.Ажлын албаны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

104.3.1.ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;

104.3.2.ажлын албаны ажилтанг томилж, чөлөөлөх;

104.3.3.төсвийг захиран зарцуулах;

104.3.4.ажлын тайланг Сахилгын хороонд тайлагнах;

104.3.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

104.4.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

104.4.1.Сахилгын хороонд харьяалагдах өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч бүртгэх;

104.4.2.өргөдөл, мэдээлэл гаргагчид сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэл өгөх;

104.4.3.Сахилгын хорооны болон ажлын албаны дарга, гишүүний өгсөн үүрэг, даалгаврыг зохих журмын дагуу шуурхай гүйцэтгэх;

104.4.4.захирамж, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, магадлал, тогтоол бэлтгэхэд Сахилгын хорооны гишүүнд туслэх;

104.4.5.Сахилгын хорооны гишүүнийг шаардлагатай хууль тогтоомж, мэдээллээр хангах;

104.4.6.Сахилгын хорооны дарга, гишүүнд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

104.4.7.хуралдааны бэлтгэлийг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;

104.4.8.энэ хуульд заасны дагуу захирамж, тогтоол, магадлал, албан бичиг, бусад баримт бичгийг холбогдох этгээдэд хүргэх;

104.4.9.Сахилгын хорооноос гаргасан шийдвэрийн талаар бүртгэл хөтөлж, тайлан гаргах;

104.4.10.сахилгын хэрэг, Сахилгын хорооны шийдвэр, албан бичиг, бусад баримт бичгийг хадгалах, хамгаалах, зохих журмын дагуу архивлах;

104.4.11.хуульд заасан бусад чиг үүрэг.

104.5.Ажлын албаны дарга, ажилтан ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөхөөс гадна энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасан зохицуулалт нэгэн адил хамаарна.

104.6.Энэ хуулийн 104.5-д заасан үүргээ ажлын албаны ажилтан зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг ажлын албаны даргад, ажлын албаны дарга зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хорооны зөвлөгөөнд гаргана.

104.7.Энэ хуулийн 104.6-д заасныг зөрчсөн ажлын албаны дарга, ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 71.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

74.Төслийн 105 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“105 дугаар зүйл.Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл

105.1.Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хуулийн 57.1-д заасан сахилгын зөрчлийн тухай өргөдөл, мэдээлэл /цаашид “өргөдөл, мэдээлэл” гэх/-ийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, Сахилгын хорооны хуралдаанаар хянан шийдвэрлэх, гомдол, эсэргүүцэл гаргах, гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэнэ.

105.2.Сахилгын хороо шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль дээдлэх, шударга, ил тод, хараат бус байх, өргөдөл, мэдээллийг заавал хянан шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоно.

105.3.Энэ хуулийн 108.2-т заасны дагуу сахилгын хэрэг үүсгэсэн бол

өргөдөл, мэдээллээсээ татгалзсан эсэхээс үл хамааран сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.

105.4.Сахилгын хорооны хуралдаан зарлахаас өмнө өргөдөл, мэдээлэлд дурдагдаагүй шүүгчийн сахилгын зөрчлийн шинжтэй үйл баримт сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад илэрсэн бол түүнд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.

105.5.Сахилгын зөрчилд холбогдох шүүгч /цаашид “холбогдох шүүгч” гэх/, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сахилгын хэргийн оролцогч гэнэ.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт.

Жамъянгийн Мөнхбат гишүүн 1 цаг хоцорсон.Тийм учраас танд үг хэлэх эрх 3 удаа өгөхгүй. Ганбат гишүүнтэй мөн адил.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 41 гишүүн дэмжиж, 61.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

75.Төслийн 106 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“106 дугаар зүйл.Сахилгын хэргийн оролцогчийн эрх, үүрэг

106.1.Сахилгын хэргийн оролцогч сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрхтэй:

106.1.1.өргөдөл, мэдээлэл, сахилгын хэргийн баримттай танилцах, тэмдэглэл хийх, хуулбарлан авах, амаар болон бичгээр тайлбар гаргах, нотлох баримт гаргаж өгөх;

106.1.2.хуралдаанд биечлэн болон цахимаар оролцох, тайлбар гаргах, хуралдааныг хойшлуулах талаар хүсэлтийг нэг удаа бичгээр болон цахимаар гаргах;

106.1.3.Сахилгын хорооны гишүүн, хуралдааны бүрэлдэхүүнийг энэ хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргах;

106.1.4.Сахилгын хорооны гишүүний гаргасан захирамж, Сахилгын хорооны магадлалыг эс зөвшөөрвөл энэ хуульд заасны дагуу гомдол гаргах.

106.2.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах үүрэгтэй:

106.2.1.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэгийг сахих;

106.2.2.Сахилгын хорооны дуудсанаар хүрэлцэн ирэх;

106.2.3.үнэн зөв тайлбар өгөх;

106.2.4.Сахилгын хорооны шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх.

106.3.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд хуралдааны явцад дууны, дуу-дүрсний бичлэг хийх, утсаар ярихыг хориглоно. Энэ хориглолт энэ хуульд заасны дагуу хуралдааны тэмдэглэл хөтлөх зорилгоор дууны, дуу-дүрсний бичлэг хийхэд хамаарахгүй.

106.4.Согтуурсан, мансуурсан этгээдийг хуралдаанд оруулахыг хориглоно.

106.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэг зөрчсөн этгээдэд хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг хуралдаан даргалагч хуралдааны танхимаас гаргаж, энэ тухай хуралдааны тэмдэглэлд бичиж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт.

Хууль зүйн байнгын хороо, Лүндээжанцан дарга, Үнэнбат, Энхбаяр гишүүн Ажлын хэсэг, түрүүн Содномын Чинзориг гишүүний гаргасан санал энэ 106-101-д зөвхөн эрх нь заагдчихаж байгаа юм. Тэгэхээр Сахилгын хорооны дарга, гишүүнд ерөөсөө 106 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ гэж заахгүй бол зөвхөн эрхийг нь заагаад, үүрэг нь жишээлбэл дарга нь согтуугаар орж ирээд ч юм уу, тайлбар өгөхгүй гээд үүргээ хэрэгжүүлэхгүй, зөвхөн эрх шаарддаг харилцаа болж болзошгүй учраас 106 дугаар зүйлд заасан эрх, үүргийг эдэлнэ гээд заахад л түрүүн Чинзориг гишүүдийн гаргаад байсан санал хэрэгжиж болохоор юм байна, үүнийг эцсийн хэлэлцүүлэгт анхаараарай.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 65.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

76.Төслийн 107 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“107 дугаар зүйл.Өргөдөл, мэдээлэл гаргах, хүлээн авах, хуваарилах

107.1.Сахилгын зөрчил гарсан гэж үзсэн хүн, албан тушаалтан, хуулийн этгээд холбогдох шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд өргөдөл, мэдээлэл гаргана.

107.2.Өргөдөл, мэдээллийг итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргасан бол төлөөлөх эрх олгосон баримт бичиг болон итгэмжлэлийг хавсаргана.

107.3.Сахилгын хороо өргөдөл, мэдээллийг хүлээн авч, хавсаргасан баримт, хуудасны тоог бүртгэх дэвтэрт бичиж, гарын үсэг зуруулан, баримт үйлдэх ба хуудасны тоо, огноо, цаг, минутыг тэмдэглэн баталгаажуулна.

107.4.Өргөдөл, мэдээллийг хүлээн авсан даруй энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-нд хуваарилна.”

Дашдондогийн Ганбат, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа.

Д.Ганбат: Өглөөний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Занданшатар дарга аа, та намайг Мөнхбат гишүүнтэй адилтгаж болохгүй. Та бид хоёр чинь нутаг усны улсууд, энэ хүнийг 3 удаа хойшлуулж байхад та намайг 2 л удаа

хойшлуулах ёстой шүү.

Түрүүн хэлэх гээд байсан юм бол энэ Сахилгын ерөнхий хороо бол шинэ байгууллага. Энэ байгууллагаас их юм шалтгаална. Тэгээд эхнээс нь зөв явуулчихвал их зөв зүйтэй сайхан байгууллага болоод явчих байх. Энэ чинь шүүгчдийг л шүүнэ гэсэн үг шүү дээ. Энэ байгууллагын гишүүд, дарга нь бас хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс баймаар байна. Тэгээд би ажлын хэсэгт юу хэлэх гэж байна вэ гэхээр, Хууль зүйн байнгын хороонд, тэр тавьж байгаа шаардлагуудыг зарим нэг дээр нь харж үзээч ээ. Тухайлбал Улс төрийн намын албан тушаалтай байсан гэдэг нь зөв байх. Улс төрийн алба тушаал хашиж байсан гэдэг дээрээ харж үз ээ. Бид нар чинь хүний нөөцийн хувьд ямар билээ? Тухайлбал Үндсэн хуулийн цэцийн дарга байсан Амарсанаа докторыг тэнд байж байхад хэн ч юу ч хэлэхгүй байх. Тэр хүний гаргаж байгаа шийдвэрийг бүгд хүлээн зөвшөөрөх байх, тэр талаас нь анхаараач ээ. Тэгэхгүй бол үе үеийн манай Их Хурлын дарга байсан, Монгол Улсын Ерөнхийлөгч байсан, маш олон удаа сонгогдсон Лүндээжанцан гишүүн сууж байна. Энэ хүмүүс бас тэнд байж байвал зүгээр юм байгаа.

Ер нь хууль тогтоох байгууллагад 4 жил ажиллана гэдэг чинь нэгдүгээрт ард түмнийхээ шүүлтүүрээр орчихсон байгаа.

Хоёрдугаарт, бараг хир баргийн дээд сургууль төгсчихсөн гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ үе үеийн иймэрхүү ажил хийж байсан, олон сонгогдсон энэ гишүүд маань, үе үеийн Ерөнхийлөгч хийж байсан улсууд, Их Хурлын дарга хийж байсан улсууд тэр хаа мөнгөтэй, эдийн засгийн боломжтой тэр газар уруу яваад байх юмаа. Оюутолгой, Эрдэнэт гэх мэтчилэн. Тэгэхээр үүнийг болиулаад, яг байх ёстой газрууд нь энэ юм биш үү? Энэ дээр анхаарч ажиллаарай, тийм боломжийг нь бас нээж өгөөрэй гэж ажлын хэсэг, Хууль зүйн байнгын хороо, гишүүдэд хэлмээр байна. Тэгэхгүй бол бас нэг тийшээ туйлшраад ингээд тэр боломж, нөөц бололцоогоо ашиглах энэ юмыг байхгүй болгочихдог. Энэ бол ахмадын зөвлөл тийм л байгууллага байж, тэнд хүмүүс цуглуулж байж, тэгж байж шударга ёс, шүүхийг, шүүгчдийг шүүсэн, эндээс гаргаж байгаа шийдвэрүүд нь хүлээн зөвшөөрөгдөхөөр тийм үр дүнтэй ийм байх болов уу гэж бодож байна шүү гэдгийг анхаараарай.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Одоо ордонд байгаа гишүүд болон албан хаагчид гарч, орж сэлгүүцэхгүй шүү. Хатуу хөл хорионы дэглэм баримтлаарай.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ үг, үсгэн дээр нэг жаахан асуудал байх шиг байна, энэ ажлын хэсэг энэ дээр анхаараарай.

Сахилгын зөрчил гарсан гэж үзсэн хүн гээд ингээд албан тушаалтан гээд явчхаж. Энэ шүүгч сахилгын зөрчил гаргасан гэж үзвэл энэ тухай иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд, холбогдох шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр гээд ингээд жаахан засаад явахгүй бол үг, үсэг чинь ерөөсөө ойлгомжгүй байна шүү. Энэ дээр анхаараарай.

Энэ дээр эхлээд шүүгч хэрвээ сахилгын зөрчил гаргасан гэж үзвэл гээд, энэ дээр нь жаахан тодруулаарай. Найруулгын юм байх шиг байна шүү.

Г.Занданшатар: Шүүгч сахилгын зөрчил гаргасан гэж үзвэл гэхгүй бол сахилгын зөрчил гаргасан гэж үзсэн хүн, албан тушаалтан гэхээр бусад юмыг хамаарах гээд байна гээд салаа утгатай ойлгож магадгүй гэсэн ийм найруулгын чанартай санал хэлж байна. Үүнийг анхаарах чиглэл өгье.

Тэгээд санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 73.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

77.Төслийн 108 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“108 дугаар зүйл.Сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, гомдол хянан шийдвэрлэх

108.1.Илтгэгч гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана:

108.1.1.энэ хуулийн 57 дугаар зүйлд заасан зөрчилд хамаарахгүй бол;

108.1.2.өргөдөл, мэдээлэлд заасан үйл баримт, шүүгчийн үйл ажиллагааны талаар, эсхүл уг өргөдөл, мэдээллийн дагуу сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон Сахилгын хорооны гишүүний захирамж, Сахилгын хорооны магадлал, тогтоол, хянан үзэх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр байгаа;

108.1.3.өргөдөл, мэдээлэл гаргасан этгээд тодорхойгүй.

108.2.Илтгэгч гишүүн энэ хуулийн 108.1-д зааснаас бусад тохиолдолд өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэх тухай захирамж гаргана.

108.3.Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг гаргаснаас хойш даруй өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ. Уг захирамжийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл гаргагч Сахилгын хороонд гомдол гаргаж болно. Энэ хугацааны дотор гомдол гаргаагүй бол захирамж хүчин төгөлдөр болно.

108.4.Илтгэгч гишүүний энэ хуулийн 108.2, 109.11-д зааснаас бусад захирамжид гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон хоёр гишүүний бүрэлдэхүүн /цаашид “гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн” гэх/-тэйгээр хэлэлцэж шийдвэрлэнэ. Уг бүрэлдэхүүнд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

108.5.Илтгэгч гишүүн нь шүүгч гишүүн бол гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн нь шүүгч биш байна. Илтгэгч гишүүн нь шүүгч биш бол бүрэлдэхүүний нэг нь шүүгч, нөгөө нь шүүгч биш гишүүн байна.

108.6.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад

хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 108.5-д заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүнийг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

108.7.Гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн дараах тогтоолын аль нэгийг гаргана:

108.7.1.захирамжийг хэвээр үлдээх, эсхүл захирамжийн үндэслэлийг өөрчлөн захирамжийг хэвээр үлдээх;

108.7.2.сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг хүчингүй болгож, сахилгын хэрэг үүсгэх.

108.8.Энэ хуулийн 108.7-д заасан тогтоолыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн санал нэгтгэйгээр гаргана. Санал нэгдээгүй бол захирамжийг хэвээр үлдээнэ.

108.9.Энэ хуулийн 108.8-д заасан тогтоол нь эцсийн шийдвэр байна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Ер нь тэгэхдээ бүхэлд нь найруулга дээр сая гишүүдийн гаргаад байгаа саналуудыг бас харгалзан үзэхээр зүйлүүд ажиглагдаж байна.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, 70.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

78.Төслийн 109 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“109 дүгээр зүйл.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

109.1.Сахилгын хэргийг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор, сахилгын хэргийг дахин шалгуулахаар буцааснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ хугацааг шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

109.2.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг үүсгэсний дараа доор дурдсан шалгах ажиллагаа явуулна:

109.2.1.сахилгын хэрэг үүсгэсэн захирамж, тогтоол гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор уг захирамж, тогтоолыг өргөдөл, мэдээллийн хуулбарын хамт холбогдох шүүгчид гардуулж, эсхүл энэ хуулийн 115.6, 115.7-д заасан журмаар хүргүүлж, энэ тухай баримтжуулах;

109.2.2.сахилгын хэргийн оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухайгаа баримтжуулах;

109.2.3.сахилгын хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

109.2.4.сахилгын хэргийн оролцогчийг дуудан ирүүлэх;
109.2.5.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;

109.2.6.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хугацааг энэ хуульд заасны дагуу сунгах;

109.2.7.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасны дагуу түдгэлзүүлэх, сэргээх;

109.2.8.энэ хуульд заасан бусад ажиллагаа.

109.3.Холбогдох шүүгч энэ хуулийн 108.2-т заасан сахилгын хэрэг үүсгэсэн тухай захирамж, тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээллийн талаар бичгээр хариу тайлбар, нотлох баримт, нотлох баримт гаргах хүсэлт гаргаж болно.

109.4.Нэг шүүгчид холбогдуулан гаргасан хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, эсхүл хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан нэг агуулга бүхий өргөдөл, мэдээлэлтэй хэд хэдэн сахилгын хэргийг нэгтгэн шалгаж, хянан шийдвэрлэж болно. Нэгтгэн гаргасан, эсхүл хэд хэдэн өргөдөл, мэдээлэл гаргасан болон хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан өргөдөл, мэдээллийн шаардлагатай нэг болон хэд хэдэн хэргийг тусгаарлаж болно.

109.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шаардсан нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээд илтгэгч гишүүнд гаргаж өгөх үүрэгтэй.

109.6.Илтгэгч гишүүн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1-д заасан үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ. Түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

109.7.Энэ хуулийн 109.6-д зааснаас бусад үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

109.8.Сахилгын хэрэг шалгах ажиллагаа сахилгын хэргийн оролцогчоос бусад этгээдэд хаалттай байна.

109.9.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ хуулийн 108.1, 108.2, 109.11-д зааснаас бусад асуудлаар гаргасан захирамжийг Сахилгын хорооны гишүүн ажлын гурван өдрийн дотор бичгээр гаргаж, сахилгын хэргийн оролцогчид даруй хүргүүлэх бөгөөд сахилгын хэргийн оролцогч уг захирамжийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор Сахилгын хороонд гомдол гаргах эрхтэй. Энэхүү захирамж илт үндэслэлгүй бол түүнийг гаргасан Сахилгын хорооны гишүүн хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.

109.10.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл өргөдөл, мэдээлэл гаргагч энэ хуульд заасны дагуу илтгэгч гишүүний захирамжид гомдол гаргах хугацааг

хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт илтгэгч гишүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг илтгэгч гишүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, захирамж гаргана.

109.11.Сахилгын хэрэг үүсгэх тухай захирамж, тогтоол гаргаснаас хойш илтгэгч гишүүн 30 хоногийн дотор дараах дүгнэлт, саналын аль нэгийг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргана:

109.11.1.сахилгын зөрчил гаргасныг нотлох дүгнэлт;

109.11.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал.

109.12.Илтгэгч гишүүн энэ хуулийн 109.11-д заасан хугацааг зайлшгүй шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 71.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

79.Төслийн Арван зургадугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 110, 111 дүгээр зүйл нэмэх:

“110 дугаар зүйл.Нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа

110.1.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй.

110.2.Сахилгын хороо сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах эрхтэй бөгөөд холбогдох этгээд гаргаж өгөх үүрэгтэй.

110.3.Холбогдох шүүгч хариу тайлбарын үндэслэлийн талаар нотлох баримтаа гаргаж өгөх ба гаргаж өгөх боломжгүй, түүнчлэн мэдэгдээгүй нотлох баримтын эх сурвалжийг заах үүрэгтэй.

110.4.Сахилгын хэргийн оролцогч өргөдөл, мэдээлэлтэй холбоотой нотлох баримттай хуралдаан товлороос өмнө танилцах эрхтэй.

110.5.Сахилгын хэргийн оролцогч, өргөдөл, мэдээлэл гаргагч, илтгэгч гишүүн хуурамч, хуульд заасан арга хэрэгслээр олж аваагүй нотлох баримт гаргахыг хориглоно. Энэ хэсэгт заасныг зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

110.6.Сахилгын хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.

110.7.Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл Сахилгын хорооны санаачилгаар

эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно.

110.8.Нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор, тухайн сахилгын хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв талаас нь үнэлнэ.

110.9.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, эсхүл Сахилгын хорооны шийдвэрээр нэгэнт тогтоогдсон болон нийтэд илэрхий үйл баримт сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.

110.10.Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хууль бус аргаар олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд Сахилгын хорооны шийдвэрийн үндэслэл болохгүй.

110.11.Сахилгын хэргийн оролцогчийн гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн, сахилгын хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэсэн байна.

110.12.Энэ хуулийн 110.11-д заасан этгээд өөрийн тайлбарт холбогдох өөрт байгаа болон гаргах боломжтой нотлох баримтыг өгнө.

110.13.Гэрчээр дуудагдсан этгээд Сахилгын хороонд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй.

110.14.Гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, эсхүл зориуд худал мэдүүлэг өгсөн бол хуульд заасан хариуцлага оногдуулна.

110.15.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

110.16.Дараах хүнийг гэрчээр дуудах болон мэдүүлэг авч болохгүй:

110.16.1.үүргээ гүйцэтгэх замаар хэргийн нөхцөл байдлыг мэдэх болсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч;

110.16.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.

111 дүгээр зүйл.Бичмэл нотлох баримт

111.1.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.

111.2.Бичмэл нотлох баримтыг Сахилгын хороонд эх хувиар нь, хэрэв тухайн баримтын эх хувийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Сахилгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн баримтын эх хувийг шаардан авах эрхтэй.

111.3.Төрийн байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 65.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

80.Төсөлд доор дурдсан агуулгатай 112, 113 дугаар зүйл нэмэх:

“112 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт

112.1.Тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд илтгэгч гишүүн өөрийн санаачилгаар, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр шинжээч томилж болно.

112.2.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

113 дугаар зүйл.Тэмдэглэл

113.1.Сахилгын хорооны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх тохиолдолд хуралдааны тэмдэглэл үйлдэнэ.

113.2.Хуралдааны тэмдэглэлийг ажлын алба хөтөлж, хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа гишүүн албажуулна.

113.3.Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, эхэлсэн, дууссан цаг, ажиллагаанд оролцсон болон байлцсан хүн нэг бүрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ.

113.4.Тэмдэглэлийг уг ажиллагаа явуулахад оролцсон болон байлцсан хүнд танилцуулах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг тайлбарлана.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт

Энэ асуудлыг асуугаад байсан Жамбалын Ганбаатар гишүүн сөрөг гарч байна шүү, хаана байна. Ажлын хэсэг, Хууль зүйн байнгын хороо, Лүндээжанцан дарга аа, та хэд энэ дээр нэг юм анхаараад судлаатахаач. Сахилгын хорооны шүүгч биш гишүүнд холбогдох байгууллагуудаас тухайлбал Авлигатай тэмцэх газраас ч юм уу, Улсын Их Хурал томилохдоо харгалзан үзэж болох эсэхийг, хоёрдугаарт нь, прокурорын мөрдөнг дагалдах хуулиар сэргээж болох эсэхийг, түүнийгээ бол энэ Сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй адил журмаар Улсын Их Хурлаас сонгон шалгаруулалтаар, тусгай журмаар сэргээж байгуулж болох эсэх асуудлууд, ингэж зохицсоныг үйлчилбэл Энхбаяр гишүүн ээ, нөгөө хүний эрхийн талаасаа ч гэсэн ингээд яриад байгаа асуудлууд байна шүү дээ. Процессын хуулиудаа зохицуулах асуудлууд дээр, тэгвэл Прокурорын мөрдөнг энэ Сахилгын хороо шиг сонгон шалгаруулаад байгуулж болох нөгөө хяналт тэнцлийг хангахын тулд шүүх, энэ Сахилгын хорооны бүрэлдэхүүнд холбогдох мөрдөх байгууллагаас сонгон шалгаруулах замаар бас Улсын Их Хурал оруулж болох ч байдаг юм уу, яригдаад байгаа хувилбарууд байгаа.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 79.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

81.Төслийн 110 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 114 дүгээр зүйл болгох:

“114 дүгээр зүйл.Сахилгын хорооны хуралдаанд бэлтгэх ажиллагаа

114.1.Илтгэгч гишүүн нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гаргаснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 115.1-д заасан хуралдааныг товлон зарлаж, хуралдуулна.

114.2.Хуралдаан болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг сахилгын хэргийн оролцогчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

114.3.Ажлын алба Сахилгын хорооны хуралдааны товыг бүрэлдэхүүний гишүүдэд мэдэгдэж, хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 109.11-д заасан захирамжийг холбогдох баримтын хамт хүргүүлнэ.

114.4.Сахилгын хэргийн оролцогчид Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг мэдэгдэж, энэ тухай баримт үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Сахилгын хэргийн оролцогч Сахилгын хорооны хуралдааны товыг лавлах үүрэгтэй.

114.5.Сахилгын хорооны хуралдаанд сахилгын хэргийн оролцогч оролцож болно. Сахилгын хэргийн оролцогч хуралдаан болохоос өмнө хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирэх боломжгүй тухай хүсэлтээ бичгээр болон цахимаар ирүүлсэн бол хуралдааныг хойшлуулж болох бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх хугацаа сахилгын хэрэг үүсгэснээс хойш 90 хоногоос хэтрэхгүй.

114.6.Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг өргөдөл, мэдээлэл гаргагчид мэдэгдэж энэ тухай баримт үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Өргөдөл, мэдээлэл гаргагч нь гэрчээр дуудагдсанаас бусад тохиолдолд хуралдаанд ажиглагчаар оролцож болно.

114.7.Бүрэлдэхүүнд орсон гишүүнийг энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр татгалзан гаргах тухай сахилгын хэргийн оролцогчоос хүсэлт гаргавал тухайн гишүүнийг байлцуулахгүйгээр бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ. Бүрэлдэхүүний санал тэнцсэн тохиолдолд тухайн гишүүнийг татгалзан гаргаж, хуралдааныг хойшлуулах тухай тогтоол гаргана.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 67.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

82.Төслийн 111 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 115

дугаар зүйл болгох:

“115 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдаан

115.1.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүн орно.

115.2.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүний хоёр нь шүүгч биш гишүүн, нэг нь шүүгч гишүүн байх бөгөөд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

115.3.Сахилгын хорооны хуралдааныг энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу бүрэлдэхүүний аль нэг гишүүн даргална.

115.4.Сахилгын хорооны хуралдааныг доор дурдсан дарааллаар явуулна:

115.4.1.даргалагч хуралдааныг нээж, хянан шийдвэрлэх гэж байгаа сахилгын хэргийн талаар танилцуулах;

115.4.2.хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй оролцогчид хуралдааны товыг урьдчилан мэдэгдсэн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг хуралдаан даргалагчид танилцуулах;

115.4.3.сахилгын хэргийн оролцогчтой танилцаж, төлөөлөх бүрэн эрхийг шалгаж, эрх, үүргийг тайлбарлах;

115.4.4.даргалагч бүрэлдэхүүнийг танилцуулан, татгалзан гаргах эрхийг сахилгын хэргийн оролцогчид тайлбарлан өгөх;

115.4.5.сахилгын хэргийн оролцогчийн зүгээс шинээр нотлох баримт гаргаж өгөх эсэхийг асуух;

115.4.6.сахилгын хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;

115.4.7.илтгэгч гишүүн гомдол, хүсэлт, сахилгын зөрчил гарсныг нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг танилцуулах;

115.4.8.сахилгын хэргийн оролцогчийн тайлбарыг сонсох;

115.4.9.гэрчийн мэдүүлэг сонсох, нотлох баримтыг шинжлэн судлах;

115.4.10.хуралдаанд оролцогч болон илтгэгч гишүүнээс асуулт асууж, хариулт авах;

115.4.11.сахилгын хэргийн оролцогч болон илтгэгч гишүүнээс нэмэлт тайлбарыг сонссоны дараа хуралдаан завсарлаж, бүрэлдэхүүн шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох.

115.5.Зөвлөлдөх үед гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Сахилгын хорооны гишүүн санал өгөхөөс татгалзах, түдгэлзэх эрхгүй бөгөөд нэрийн эхний үсгийн цагаан толгойн дарааллаар саналаа хэлнэ. Зөвлөлдөх тасалгаанд гаргасан гишүүний санал нууц байна.

115.6.Сахилгын хорооны хуралдааныг нээлттэй явуулна. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл гишүүний санаачилгаар хуралдааныг бүрэн, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болно.

115.7.Сахилгын хорооны хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны ажилтан хөтөлж, хуралдаан даргалагч болон ажилтан ажлын долоон өдрийн дотор тэмдэглэлд гарын үсэг зурж, албажуулна.

115.8.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 115.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд нэгээс илүүгүй гишүүнийг оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт.

Энэ дугаарлалтаа анхаараарай. 102-ыг чинь 116 болчхоор 113 гээд дуусаж байсан шүү дээ. 3 заалт нэмэгдэхээр.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 76.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

83.Төслийн 112 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 116 дугаар зүйл болгох:

“116 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдааны шийдвэр

116.1.Сахилгын хорооны хуралдаанаар сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

116.1.1.нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

116.1.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хүлээн авч, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

116.1.3.нотлох дүгнэлтийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээн авч, шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах;

116.1.4.шүүгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

116.1.5.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, эсхүл нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд буцаах.

116.2.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 116.1.1, 116.1.2, 116.1.3-т заасны дагуу сахилгын хэргийг шийдвэрлэж, магадлал гаргана.

116.3.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 116.1.4, 116.1.5-д заасан

болон хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлаар тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.

116.4.Тогтоол, магадлал уншиж сонсгосноор хүчинтэй болох бөгөөд даргалагч, гишүүд гарын үсэг зурж, тамга дарж албажуулна. Бүрэлдэхүүнд орсон гишүүд тогтоол, магадлалд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

116.5.Сахилгын хорооны хуралдаанаас гаргах тогтоол, магадлал нь дараах агуулга бүхий удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байна:

116.5.1.удиртгал хэсэгт тогтоол, магадлалыг хэзээ, хаана гаргасан, бүрэлдэхүүнд орсон гишүүдийг нэрлэн заах;

116.5.2.тодорхойлох хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, түүний үндэслэл болон сахилгын хэргийн оролцогчийн тайлбарын агуулгыг тусгах;

116.5.3.үндэслэх хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналын талаар хууль зүйн үндэслэл, нотлогдсон байдлын талаар заах;

116.5.4.тогтоох хэсэгт сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд үндэслэсэн хуулийн холбогдох заалт, шийтгэлийн төрөл, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хэрхэн шийдвэрлэсэн болон гомдол гаргах талаар тодорхой тусгах;

116.5.5.тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байх.

116.6.Сахилгын хорооны тогтоол, магадлалыг гаргаснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

116.7.Энэ хуулийн 116.6-д заасны дагуу хүргүүлснээр магадлалыг гардан авсанд тооцох бөгөөд энэ нь гомдол гаргах хугацааг тоолох үндэслэл болно.

116.8.Энэ хуулийн 116.7-д заасны дагуу Сахилгын хорооны магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч гомдол, илтгэгч гишүүн эсэргүүцэл Сахилгын хороонд гаргаж болно.

116.9.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 116.8-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт магадлал гаргасан бүрэлдэхүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг уг бүрэлдэхүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 79.1 хувийн

саналаар энэ санал дэмжигдлээ.

Сахилгын хорооноос гаргах тогтоол, магадлал нь сахилгын шийтгэл оногдуулахаар бол нэг, хэрэгсэхгүй болгож байгаа бол нэг байхгүй бол энэ дээр чинь заавал сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, үндэслэлийг бичих юм шиг ингэж ойлгогдох гээд байна шүү дээ. Хэрэгсэхгүй болгосон тохиолдолд энэ үндэслэл, шийтгэл оногдуулсан тохиолдолд тэр үндэслэл гэж салгахгүй бол хууль зүйн техникийн хувьд энэ.

84.Төслийн 112 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 117 дугаар зүйл болгох:

“117 дугаар зүйл.Сахилгын хорооны хянан үзэх хуралдаан

117.1.Энэ хуулийн 116.8-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

117.1.1.сахилгын хэргийн оролцогчийн, эсхүл илтгэгч гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

117.1.2.магадлалын огноо, дугаар;

117.1.3.магадлалыг эс зөвшөөрсөн үндэслэл;

117.1.4.гомдол, эсэргүүцлийн шаардлага.

117.2.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх бөгөөд уг бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

117.2.1.бүрэлдэхүүний хоёр нь шүүгч гишүүн, нэг нь шүүгч биш гишүүн байх;

117.2.2.Сахилгын хорооны тухайн магадлал гаргасан бүрэлдэхүүнийг оролцуулахгүй;

117.2.3.илтгэгч гишүүнийг оролцуулахгүй.

117.3.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 117.2.1, 117.2.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол Сахилгын хорооны бусад гишүүнээс энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар хянан үзэх хуралдааны бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

117.4.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлд Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй.

117.5.Энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу томилогдсон хуралдаан даргалагч Сахилгын хорооны магадлалд гомдол, эсэргүүцэл гарсан талаар илтгэгч гишүүн, сахилгын хэргийн оролцогчид мэдэгдэж, танилцах боломжоор хангана.

117.6.Сахилгын хэргийн оролцогч гомдлоосоо татгалзсан бол гомдол гаргаагүйд тооцно.

117.7.Илтгэгч гишүүн эсэргүүцлээсээ татгалзах эрхгүй.

117.8.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор Сахилгын хорооны хянан үзэх хуралдаанаар шийдвэрлэж, дараах агуулга бүхий хяналтын тогтоолыг бүрэлдэхүүний гишүүдийн олонхын саналаар гаргана:

117.8.1.гомдол, эсэргүүцлийг хангахгүй орхиж, магадлалыг хэвээр үлдээх;

117.8.2.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалд өөрчлөлт оруулах;

117.8.3.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалыг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах;

117.8.4.гомдол, эсэргүүцлийн зарим хэсгийг хангаж, магадлалын зарим хэсгийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах.

117.9.Хянан үзэх хуралдааны товыг мэдэгдэж, хуралдаанд оролцох эрхийг хангана. Хуралдааны товыг мэдэгдсэн боловч хуралдаанд ирээгүй нь гомдлыг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

117.10.Хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцэл, магадлалын агуулгыг танилцуулсны дараа сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч гишүүний тайлбарыг сонсоно.

117.11.Бүрэлдэхүүн сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч гишүүний тайлбарыг сонссоны дараа асуулт тавих, нэмэлт тайлбарыг сонсож, хуралдаан завсарлан зөвлөлдөх тасалгаанд орж, хяналтын тогтоол гаргана.

117.12.Хяналтын тогтоол нь уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хуулийн 118.1-д заасны дагуу гомдол гаргаснаас бусад тохиолдолд эцсийн шийдвэр байна.

117.13.Хяналтын тогтоолд магадлал, гомдол, эсэргүүцлийн агуулга, тогтоолын үндэслэл, гаргасан шийдвэрийг бичнэ.

117.14.Хяналтын тогтоолыг уншиж сонсгосноос хойш 14 хоногийн дотор тогтоолын агуулгыг бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Тогтоолыг сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчид энэ хуулийн 116.6, 116.7-д зааснаар хүргүүлнэ.

117.15.Энэ хуулийн 114 дүгээр зүйл, 115.3, 115.4,115.5, 115.6, 115.7, 116.4, 116.5-д заасан журам хянан үзэх хуралдаанд нэгэн адил хамаарна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Ж.Бат-Эрдэнэ: 117.6 дээр сахилгын хэргийн оролцогч гомдлоосоо татгалзсан бол гомдол гаргаагүйд тооцно гэж байгаа юм. Сахилгын хорооны оролцогч гэдэгт нөгөө гомдол гаргасан хүнийг хэлээд байх шиг байна. Гэтэл 107 дээр гомдол гаргасан хүнээ энд тодорхойлоогүй байгаа юм, ажлын хэсэг энэ дээр анхаарахгүй бол. Гомдол гаргасан хүнээ яг энэ оролцогч гэдэг дотор тэр гомдол гаргасан хүн орж ирж байх шиг байна, дээрээс нь гэрч нь орж ирж байх шиг байна. Тэгэхээр энэ эхлээд 107 дотроо зөрчил гаргасанд, гомдол гаргасан хүнээ яг оролцогч гэдгээр нь тодруулж өгөх хэрэгтэй. Үүнийг ажлын хэсэгт Улсын Их Хурлын даргаас удирдамж өгөөч гэж нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ оролцогч хэрвээ гомдлоо татчихсан тохиолдолд, дахиад тэр хугацаанд гомдол өгчхөөд, дахиад лобби явдаг юм уу, хоорондоо уулзалддаг юм уу, ярьдаг юм уу? Тэгээд гомдлоо татах, эсхүл би худлаа ярьсан байна, гүтгэсэн байна ч гэдэг юм уу, иймэрхүү ийм лоббины юм энд явах боломж бололцоог нээж өгөөд байгаа юм уу даа гэсэн ийм юм харагдаад байх юм. Тэгэхээр энэ дээр үг, үсэг юман дээр бас яг утга учир маань энэ дээр тэр утгаараа гарч байна уу, үгүй юу гэдгийг анхаарч өгөөч гэсэн ийм санал байгаад байна.

Г.Занданшатар: Энхбаяр гишүүн ээ, Гомдол гаргах гээд дараа нь санал хураалт байгаа шүү дээ. Саяныхыг сонсов уу.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ дараагийнх нь уу, дараагийн гомдол гэж үү? Хяналтын шатны явцынх уу. Тэгвэл оролцогч гэдгийг бас бүр тодорхойлж өгөх хэрэгтэй болчихоод байна. Байгаа юу?

Г.Занданшатар: Дараа нь хяналтын тогтоолд гомдол гаргах дараа нь нэг бүлэг байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Нэг чиглэл өгөөд үзээд, тэр ялгааг нь сайн гаргаж өгмөөр байна. Яг тэр анхны гомдол гаргасан хүний гомдол явж байна уу, эсхүл тэр хяналтын шатны гомдол явж байна уу, энэ дээр ойлгогдохгүй байна шүү, үүнийгээ бас үзэж харахгүй бол болохгүй байна.

Г.Занданшатар: Хяналтад гомдол гаргах гээд дараа нь 118 дугаар зүйл билүү?

Ж.Бат-Эрдэнэ: Тэгээд хоорондоо холилдоод яваад байж магадгүй шүү. Би сая нэлээн ухаж харлаа, олохгүй байна.

Г.Занданшатар: Гомдол эсэргүүцэл гэж байгаа. Эд нарыгаа эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай.

Ж.Бат-Эрдэнэ: Эцсийн хэлэлцүүлэг дээр эргэж харахгүй бол.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 73.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

85.Төсөлд доор дурдсан агуулгатай 118 дугаар зүйл нэмэх:

“118 дугаар зүйл.Хяналтын тогтоолд гомдол гаргах

118.1.Хяналтын тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 119.1-д заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болно.

118.2.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

118.2.1.холбогдох шүүгч болон илтгэгч гишүүний нэр, албан тушаал, оршин суугаа газрын хаяг, утас, цахим шуудангийн хаяг;

118.2.2.Сахилгын хорооны хяналтын тогтоолын огноо, дугаар;

118.2.3.Сахилгын хорооны хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэл.

118.3.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцэлд дараах баримт бичгийг хавсаргана:

118.3.1.хяналтын тогтоолын эх хувь, эсхүл түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

118.3.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэлийг нотлох баримт;

118.3.3.итгэмжлэл.

118.4.Хяналтын тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцлийг хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн хүлээн авч, сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч шүүгчид танилцуулан тайлбар гаргуулан сахилгын хэрэгт хавсаргана.

118.5.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

118.6.Хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн нь энэ хуулийн 118.1, 118.2, 118.3-д заасан шаардлагад нийцээгүй гомдол, эсэргүүцлийг буцаах тухай захирамж гаргаж, энэ талаар хариу мэдэгдэнэ.”

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ 118.1 дээр хяналтын тогтоолд гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болно гээд байгаа юм. Тэгэхээр өчигдөр би бас ярьж байсан юм. Эрх ашгийн зөрчил энд харагдаад байгаа юм. Сахилгын хороо гэдэг энэ том байгууллагаа бий болгочоод, шүүгчдийнхээ ёс зүй болон мэргэжлийн болон алдаа дутагдал юмнуудыг харж байдаг ийм сахилгын хороо гарчхаад, эндээс гаргасан шийдвэрээ

Дээд шүүхдээ өгчхөөр яах вэ гэдэг асуудал.

Дээрээс нь Дээд шүүхийн шүүгч хэрвээ энэ сахилгын хороогоор орж ирсэн тохиолдолд яах вэ? Дахиад Дээд шүүх дээрээ очдог, тэнд чинь жинхэнэ эрх ашгийн зөрчил, нэг нь нэгийгээ одоо тэр сахилгын хорооноос гарсан хяналтын дүгнэлтийг бас батлаад явах нь юу л бол. Тэгээд сахилгын хороо нэгэнт бий болгочоод, буцаад өөрсдөө өөрсдөөр нь шийдүүлээд, эрх ашгийн зөрчлийг бий болгох ийм нөхцөлийг бид нар бий болгочоод байгаа юм биш үү.

Ажлын хэсгийн дарга өчигдөр бас энэ талд санал нэгтэй байх шиг л байна билээ. Энэ бол буруу юмаа гэж. Жишээ нь миний хувьд энэ заалт дээр эсрэг саналтай байна. Эндээс удирдамж өгмөөр юм уу, Их Хурлын даргаас чиглэл өгмөөр юм уу? Ноцтой асуудал шүү дээ.

Г.Занданшатар: Үндсэн хуулийн 54.1, тэгээд Үндсэн хуулийн 16.14, тэр шүүхэд гомдол гаргах эрхтэй гэсэн тийм хүний заяамал эрх нь.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхдээ энэ чинь захиргааны асуудал шүү дээ. Захиргааны асуудал талдаа нэг талаас шүүх гэж үзэж байгаа ч гэсэн захиргааны асуудал байхгүй юу? Тэгэхээр үүнийгээ Шүүхийн ерөнхий зөвлөл уруу оруулбал яасан юм бэ? Та энэ дээр эргэж харах удирдамж өгөөч.

Г.Занданшатар: Үндсэн хуульд санаа агуулсан байх гэж би энэ ажлын саналыг үзэж байна. Тэгээд үүнийгээ эцсийн хэлэлцүүлэг дээр Үндсэн хуульд нийцүүлэх ёстой.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Бат-Эрдэнэ гишүүн их чухал асуудал хөндөж байгаа юм. Энэ нэлээн их яригдсан. Нэлээн олон талаас Байнгын хороон дээр энэ асуудал дээр бараг 2 цаг байр суурийн мэтгэлцээн хийсэн юм. Тэгээд Үндсэн хуульд заачихсан шүүхэд гомдол гаргах иргэний эрх байгаад байгаа юм, тэр үндсэн эрх. Түүнийг нь бүр хязгаарлалцахаар энэ сахилгын хорооны шийдвэрүүдийг эцсийн шийдвэр байна гэхээр нэг талаасаа Цэц дээр асуудал болох уу, үгүй юу гэдэг нь юнс яригдсан.

Нөгөө талаасаа энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга бол Сахилгын хороо өөрөө огцруулах шийдвэр гаргана, түдгэлзүүлэх шийдвэрийг гаргана. Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах шийдвэрийг гаргана. Энэ Дээд шүүх дээр ерөөсөө маш тодорхой үндэслэлээр л гомдол гаргая. Өөрөөр хэлбэл Сахилгын хэрэг хянан шийдвэрлэсэн хуралдааны товыг хэрвээ тэр шүүгчид мэдэгдээгүй бол. Хянан шийдвэрлэхэд нь өөрөөс нь тайлбар аваагүй бол. Энэ үндэслэлээр л Дээд шүүхээс хянуулахаас биш надад ерөөсөө шийтгэл ногдуулах, ногдуулахгүй байсан энэ шийтгэл нь зөв, буруу, их, бага гэдэг асуудлаар Дээд шүүхэд гомдол гаргахгүй. Энэ талаар ногдуулсан Сахилгын хорооны шийдвэр эцсийн байна гэсэн ийм агуулга байгаа юм.

Тийм учраас нэг талаасаа шүүхэд гомдол гаргах эрхийг хангасан уу гэвэл хангасан. Нөгөө талаасаа тухайн шүүгчийн шийтгэлд ногдуулсан Сахилгын хорооны шийдвэр бол эцсийн байх тэр Үндсэн хуулийн аль аль шаардлагыг хангасан ийм хууль зүйн шийдэлд хүрсэн юм.

Г.Занданшатар: Тэгэхээр хууль зүйн гаргалгаа шийдлийг ийм агуулгаар явахгүй бол дараа нь зөрчилтэй гэж тооцогдол бас асуудал гарна. Тэгэхээр энэ бол хамгийн зөв гаргалгаа нь. Үндсэн хуулийн 49.6-г ч гэсэн хангачихсан.

Үндсэн хуулийн 49.6, 54.1, тэгээд 16.14 гээд хууль, тогтоомж, олон улсын гэрээ конвенцид заасан эрхээ зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж хүний үндсэн эрхэд тусгачихсан байдаг юм. 16 дугаар зүйлд. Түүнийхээ гаргалгааг сайн үзэх хэрэгтэй.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энхбаяр ажлын хэсгийн ахлагч сая тайлбарлачихлаа. Энэ Сахилгын хорооны шийтгэлийг агуулгаар нь Дээд шүүх хянахгүй гэж ажлын хэсэг дээр бид нар томъёолол хийж оруулсан юм. Агуулга хянахгүй. Гагцхүү энэ хуульд заасан процесс, ном журмын дагуу явагдсан байна уу, процессын алдаа гаргасан байна уу гэдгийг хянахаар саналаа оруулсан юм. Тэгээд энэ Дээд шүүхийн хяналтад байх нь зөв өө. Үүнийг гишүүдийг дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 65.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн шаардлага, Үндсэн хуулийн агуулга, үзэл санаатай нийцүүлж, сая Бат-Эрдэнэ гишүүний гаргаад байгаа саналыг харгалзаж, эцсийн хэлэлцүүлэг дээр зөрчилгүй болгох талаас нь сайн анхаарах хэрэгтэй юм байна даа.

86.Төсөлд доор дурдсан агуулгатай 119 дүгээр зүйл нэмэх:

“119 дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан

119.1.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг зөвхөн дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

119.1.1.Сахилгын хорооны хянан үзэх хуралдааны товыг энэ хуулийн 116.3, 116.4, 116.6-д заасны дагуу мэдэгдээгүйн улмаас хуралдаанд зохих ёсоор оролцож чадаагүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон;

119.1.2.Энэ хуулийн 106.1-д заасан эрхийг эдлүүлээгүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон.

119.2.Хяналтын тогтоолд сахилгын хэргийн оролцогчоос гомдол, илтгэгч гишүүнээс эсэргүүцэл гаргасан тохиолдолд тухайн тогтоолын биелэлт түдгэлзэнэ.

119.3.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

119.4.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

119.5.Энэ хуулийн 119.4-т заасан бүрэлдэхүүнийг энэ хуулийн 19.2.5-д заасан журмын дагуу томилох бөгөөд тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс тогтоосон дарааллаар томилсон шүүгч даргална.

119.6.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны товыг хэргийн оролцогч, илтгэгч гишүүнд долоогоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж баримтыг сахилгын хэрэгт хавсаргана. Уг мэдэгдлийг хүлээн авсан этгээд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

119.7.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 119.1-д заасан үндэслэл байгаа эсэхийг гомдол, эсэргүүцлийн шаардлага болон татгалзлын үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх замаар тогтооно.

119.8.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийг хянан хэлэлцэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

119.8.1.хяналтын тогтоолыг хэвээр үлдээх;

119.8.2.хяналтын тогтоолыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгох;

119.8.3.сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаан, эсхүл хянан үзэх хуралдаанд буцаах.

119.9.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

119.10.Энэ хуулийн 119.9-д заасан тогтоолд доор дурдсан зүйлийг тусгана:

119.10.1.маргаж байгаа хяналтын тогтоолын тухай мэдээлэл, түүнийг гаргасан газар;

119.10.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийн агуулга;

119.10.3.шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл;

119.10.4.хяналтын тогтоолыг хэвээр үлдээсэн, эсхүл бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 119.8.3-т заасны дагуу буцаасан тухай заалт.

119.11.Энэ хуулийн 119.9-т заасны дагуу гарсан Улсын дээд шүүхийн

хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоол гармагц хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд эцсийн шийдвэр байна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт:

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Одонтуяа гишүүн үг хэлнэ.

С.Одонтуяа: Энэ 86 дугаар санал Үндсэн хуульд нийцэхгүй байгаа тул дэмжих боломжгүй. Ямар үндэслэлээр нийцэхгүй байгаа вэ гэхээр, Үндсэн хуулийн 50.1, 50.1.2, 50.1.3, 50.1.4, 50.1.5. Өөрөөр хэлбэл энэ 119.3-т Сахилгын хороо ер нь бол шүүх биш. Тэгэхээр шүүхийн сахилгын хэргийг Улсын дээд шүүх шууд хяналтын журмаар шийдвэрлэ гээд тусгачихсан байгаа. Тэгэхээр энэ өөрөө 50.1, 50.1.2-ыг зөрчиж байгаа. Өөрөөр хэлбэл бид Үндсэн хуулиндээ шүүхийг зөвхөн Үндсэн хууль бусад хуулийн дагуу байгуулна гээд заачихсан байгаа. Тэгэхээр үүнтэй бол нийцэхгүй байгаа.

Мөн 119.11-д Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоол эцсийн шийдвэр байна гэсэн. Гэтэл бид нар чинь 16 дугаар зүйлийн 14-т Үндсэн хуульд шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг зөрчөөд, бид нар иргэн шүүхийн шийдвэрийг давж заалдах энэ эрхгүй, эрхийг нь нээж өгөхгүй байгаа. Тэгэхээр иргэнд Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх байгаа шүү дээ. Шүүхийн шийдвэрийг давж заалдана гэсэн. Тэгэхээр энэ эрхийг нь нээхгүй бол энэ нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болох магадлалтай шүү гэдгийг би хэлээд, энэ саналыг дэмжихгүй байгаа.

Өөрөөр хэлбэл 119.3, 119.11 чинь Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн байгаа. Тэгээд ер нь Сахилгын хорооны заалт энд хэтэрхий дэлгэрэнгүй ороод, энэ нь өөрөө бараг бие даасан шүүх ч юм шиг ингээд ороод ирсэн. Бид нар чинь бие даасан шүүх ямар байх вэ гэдгийг бүх хуулиараа заагаад өгчихсөн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нь шүүхээсээ илүү давуу эрхтэй байх юм уу? Ямар болох юм, энэ заалт бол үндсээрээ Үндсэн хууль зөрчиж байгаа гэж үзэж байна.

Г.Занданшатар: Энэ чинь харин ч Дээд шүүхийн хяналтыг бий болгож байгаа. Үг хэлж дууслаа.

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 70.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

87.Төслийн 113 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 120 дугаар зүйл болгох:

“120 дугаар зүйл.Шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл, тайлан болон шийдвэрийн ил тод байдал

120.1.Ажлын алба шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл хөтөлж, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг гаргана.

120.2.Энэ хуулийн 120.1-д заасан бүртгэл, тайланд хамаарах мэдээлэл хөтлөх журамтай байх бөгөөд тайланг цахим хуудаст байршуулна.

120.3.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.

120.4.Сахилгын хорооны магадлал, хяналтын тогтоол, Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоолыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21 хоногийн дотор цахим хуудаст байршуулна.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Санал хураалт.

Дэгийн хууль орж ирнэ. Энхбаяр гишүүн ээ, Хууль зүйн байнгын хороо, Өчигдөр бас шүүхийн эдийн засгийн баталгааны асуудал яригдаад байсан. Үндсэн хуулийн 48.3-т шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Төрөөс шүүхийн эдийн засгийн баталгааг хангана гэсэн агуулгад нийцүүлээд дэгийн хуульд орж ирэх төсөв дотор нь заавал тэр цалингийн нэмэгдэл хувилбараар биш бас өчигдөр дэгс мэдээллүүд яригдаад байсан. Шүүгчийн цалин бол 2 сая 700 мянгаас эхэлж байгаа юу? 36 жил ажилласан шүүгч бол нэмэгдлүүдтэйгээ 4.3 сая л авах юм билээ.Тэгэхээр энэ Сахилгын хороо шаардлагууд их өндөрсөж байгаа учраас, хариуцлага өндөрсөж байгаа учраас нөгөө талдаа шүүгчийн эдийн засгийн баталгааг, шүүхийн эдийн засгийн баталгааг хангана гэсэн агуулгын хүрээнд зохицуулалтыг өөр хувилбараар хийж болно л доо.

Түүнээс тэтгэврийн эрх зүйг тэр чигээр нь өөрчлөөд буруу арга замаар, тэгээд 2 хувиар гэж. Инфляцийн түвшинтэй уялдуулж тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлнэ гэсэн ийм зарчим баримталдагтай адил байж жишээлбэл болох юм. Тэгэхгүй бол 5 жилийн дараагаас 2 хувь гээд ингээд тэгш бус систем нийгмийн Хөдөлмөрийн хуулийн агуулгатай зөрчилдөхөөр энэ чинь болохгүй болчихоод байгаа юм.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

88.Төслийн 114 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“114.1.Энэ хуулийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Үүнийг уг нь эцсийн хэлэлцүүлэг дээр дагаж мөрдөх хугацаагаа тохирвол илүү оновчтой байдаг юм даа. Энэ чинь дагаж баахан журам батална.

Жамбалын Ганбаатар гишүүнээр тасаллаа.

Ж.Ганбаатар: Ингээд хоёр өдөр энэ хуулийг хэлэлцэж байна. Өчигдөр би 30 минут л байгаагүй л дээ. Тэгээд энэ шүүх гаргасан шийдвэртээ хяналт тавихтай холбоотой асуудлаар Энхбаяр гишүүн ээ, энэ асуудлууд дээр юм гарч ирсэнгүй. Би тэгээд дуустал нь бас гараад ирэх юм болов уу гэж бодсон. Шүүх гаргасан шийдвэртээ хяналт тавих асуудлыг бараг хөндөөгүй юм болов уу гэж ойлгогдлоо. Өчнөөн л юмнууд шийддэг. Тэгээд шийдэж байгаа зүйлүүд нь яг одоо ажил хэрэг болж байна уу гэдгийг шүүх эргэж хардаг. Тэр талаас нь ямар нэгэн зохицуулалт ороогүй юм байна гэж харлаа шүү гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, нэг зүйл хэлэхэд. Би одоо 5 жил Их Хуралд сууж байна. Энэ хуулийн төсөл, зарчмын зөрүүтэй санал хоёр ингээд бараг зарчмын зөрүүтэй санал нь зузаан. Төсөл хийж байгаа хүмүүс эсхүл их муу ажилласан байна. Эсхүл ажлын хэсэг маш сайны сайн ажилласан байна гэсэн ийм хоёр томъёолол харагдаж байна. Тэгэхээр энэ хуулийн төсөл өргөн барьж байгаа энэ Засгийн газраас өргөн барьж байгаа энэ зүйл, заалт болгон дээр нь, надад ингээд формат нь адилхан мөртлөө зарчмын зөрүүтэй санал нь зөрчлийнхөө хуудаснаас их хуудастай. Тэгэхээр өргөн барихдаа их сайн өргөн барих хэрэгтэй гэдгийг хэлж байгаа шүү дээ. Тэгээд Их Хурлын асуудал шүү дээ гэдэг байдлаар дутуу хардаг, дутуу өргөн барьдаг асуудал хавтгай болж байгаа юм шиг харагдаж байгаа шүү. Тэртэй тэргүй Их Хурал өөрөө л хариуцлагаа хүлээх юм гэсэн байдлаар. Уг нь хууль болгон дээр ажлын хэсэг гардаггүй шүү дээ, гарах ёсгүй. Одоо бараг Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэж байгаа хууль болгон дээр ажлын хэсэг гарч байгаа. Гишүүд тодорхой хэмжээгээр санал хэлж байгаа, үүнийг анхаарах ёстой. Бараг хоёр гишүүн хэлэнгүүт л тэр дагуу л ажлын хэсэг гаргаж байгаа. Тэгэхээр хууль өргөн барьж байгаа хүмүүс ялангуяа Засгаас өргөн барьж байгаа хуулиуд бол ийм олон зарчмын зөрүүтэй санал гаргана гэдэг бас асуудал байна. Цаашдаа анхаараарай гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Баасандорж дарга аа, Сайнзориг дарга аа, ер нь орж ирж байгаа хуулийн төслүүд ингээд ийм л хэмжээний зарчмын зөрүүтэй санал гарч байна гэдэг бол нэг бол боловсруулах шатанд санал авагдаагүй, нэг бол хууль зүйн техникийн хувьд муу боловсруулагдсан гэдэг агуулга шүү дээ. Тэгэхдээ энэ өмнөх Засгийн газрын үед өргөн баригдсан хууль. Тэгээд хэлэлцүүлгийн явцад хоёр, гурван хуулийг нийлүүлсэн хувилбар. Ер нь нийлүүлээд өргөн барьчихсан юм. Ер нь яваандаа тэр зарчим яараад юм уу, 5 тусдаа байх хуулийг Шүүхийн ерөнхий зөвлөлийг тусдаа хуулиар зохицуулах ёстой. Сахилгын хороог тусдаа хуулиар зохицуулах ёстой. Шүүхийн тогтолцоо, шүүхийн процесс, шүүхийн үйл ажиллагаа дэс дараалж уялдах ёстой байсан байх. Энэ бол өргөн баригдаад шийдэгдээд явж байгаа асуудал юм.

Ингээд санал хураалт явъя. 3 сарын 1-нээс амжиж байгаа юу? 3 сарын 15-наас хаврын чуулган эхэлнэ шүү дээ. Эцсийн хэлэлцүүлэг дээр үүнийгээ нарийвчлан үзээрэй. Хуучин төсөл дээрээ 2020 оны 5 сарын 2-ноос гэж байсан.

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 76.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо найруулгын саналаар санал хураалт явуулна. Сая зарим саналууд унасан, түүнийгээ бас харгалзаж үзээрэй. Дугаарлалт өөрчлөгдөж магадгүй.

2. Найруулгын санал

1. Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “хуулиар” гэсний өмнө “тухайлсан” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шүүгчдийн зөвлөгөөнийг” гэсний дараа “/цаашид /“Зөвлөгөөн” гэх/ гэж, 26 дугаар зүйлийн “Нийт шүүгчдийн” гэсний өмнө “Улсын дээд шүүхийн” гэж тус тус, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “түдгэлзүүлэх” гэсний өмнө “шүүгчийн бүрэн эрхийг” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.9 дэх заалтын “дарга” гэсний дараа “/цаашид “Гүйцэтгэх нарийн

бичгийн дарга” гэх/” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт явуулахын өмнө 26 дугаар зүйлийн нийт шүүгчдийн өмнө Дээд шүүхийн гээд нэмэхээр Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн гэх болоод байна шүү дээ. Тэр чинь хуучин нийт шүүгчдийн чуулган биш Дээд шүүхийнхээ нийт шүүгчид юм уу, за.

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 55 гишүүн дэмжиж, 80.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26 дугаар зүйл чинь угаасаа Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан гэсэн гарчигтай юм байна шүү. Энэ чинь угаасаа Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн гэж байна шүү дээ. Тэгээд дахиад нэмчих юм бол наадах чинь Улсын дээд шүүхийн, Улсын дээд шүүхийн гээд хоёр орох агуулгатай болох юм биш үү. 26.2-ыг нь хэлсэн бол 26 дугаар зүйлийн 2 гэж заах ёстой.

2.Төслийн “шүүгчдийн зөвлөл” гэснийг “нийт шүүгчийн чуулган” гэж тохиолдол бүрд өөрчлөх, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “түүний” гэснийг “шүүгчийг” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “байгуулагдсан” гэснийг “байгуулсан” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “холбогдох” гэснийг “тухайлсан” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “мэдээлж байна” гэснийг “мэдээлнэ” гэж, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “шийдвэрлэгдсэн” гэснийг “шийдвэрлэсэн” гэж, 15.5 дахь хэсгийн “харгалзах” гэснийг “харгалзан үзэх” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “шаардан гаргуулах” гэснийг “гаргуулан авах” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “бичих” гэснийг “боловсруулах” гэж, “тогтооно” гэснийг “батална” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэснийг “сайн дураараа” гэж, Долдугаар бүлгийн гарчиг, 34 дүгээр зүйлийн гарчгийн, 37.2 дахь хэсгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 39 дүгээр зүйлийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 43 дугаар зүйлийн 43.7 дахь хэсгийн “хууль зүйн” гэснийг “хуулийн” гэж, 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын “бие махбодь гэмтсэн буюу эрүүл мэндэд нь хохирол учирснаас нас барсан” гэснийг “эрүүл мэндэд нь хохирол учирснаас амь насаа алдсан” гэж, 49.5 дахь хэсгийн “нас барвал” гэснийг “амь насаа алдвал” гэж, 51 дүгээр 51.3 дахь хэсгийн “буруутайд тооцогдсон” гэснийг “буруутай” гэж, “ямар нэгэн” гэснийг “аливаа” гэж, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “хойших” гэснийг “хойш” гэж, 73 дугаар зүйлийн 73.1.17 дахь заалтын “иргэдийн” гэснийг “хүн, хуулийн этгээдээс” гэж, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалтын “орчин үеийн” гэснийг “дэвшилтэт” гэж, 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтын “байрлуулах” гэснийг “байршуулах” гэж, 77.2.3 дахь заалтын “хуудсыг” гэснийг “хуудасны мэдээллийг” гэж, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “байх бөгөөд” гэснийг “байна.” гэж, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийн “хуралдаанаас тогтоол гаргана” гэснийг “хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна” гэж, 85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “104.1.1-104.1.5-д” гэснийг “106.1.1-106.1.4-т” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт. Лүндээжанцан дарга аа, энэ найруулгын юман дотор агуулгын юм явж магадгүй шүү. Хянаж үзэхгүй бол. Бас ингээд хураачихдаг тохиолдол байгаа шүү.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 72.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “бүх” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “холбогдох” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “заавал” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “/цаашид “Нийт шүүгчдийн хуралдаан” гэх/” гэснийг, 26.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг, 26.4 дэх хэсгийн “хэлэлцсэн” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.2.2 дахь заалтын “бие махбодь гэмтсэн буюу” гэснийг, 49.2.3 дахь заалтын “бие махбодь,” гэснийг, 49.4 дэх хэсгийн “гэмтсэн болон” гэснийг, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийн “/цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/,” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 72.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 73.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Найруулгын санал дээр Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан гэгчхээд цаашид нийт шүүгчдийн хуралдаан гэнэ гэж хашилтад хийж заачхаад, тэгээд цаашид нийт шүүгчдийн хуралдаан гээд явахаар түүнийг нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн гэж өөрчилнө гэж ингэж хоёр өөрчлөлтийг бараг нэмэгдэхүүний байр солигдоход ялгаагүй юмыг засаад байх юм.

Одоо Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Хоёр.Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.2 дахь хэсэг нэмэх:

“4.2.Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хянан хэлэлцэхгүй.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж

Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хянан хэлэлцэхгүй гэж. Тэгэхээр үүгээр би юу хэлэх гэсэн бэ гэхээр, ер нь Засгийн газрын гишүүн юм уу, эсхүл албан тушаалтан сонирхлын зөрчилтэй ийм шийдвэр

гарах юм бол тэртэй тэргүй авлига албан тушаалын гэмт хэрэг болоод явчихна. Харин Засгийн газар улс төрийн бодлогын шийдвэр, улс төрийн шийдвэрийг жишээ нь хүүхдийн мөнгө өгөх ч юм уу, эсхүл сая хийгдсэн цахилгааны үнийг тэглэх тухай ийм шийдвэр гаргаж байгаа. Энэ бол улс төрийн шийдвэр. Үүний үр дүнд нийт ард түмэн энэ улс төрийн шийдвэрийн үр дүнд тодорхой бодлогын дагуу үр дүнг хүртдэг. Тэгэхээр энэ практикаас харахад Засгийн газрын хамтын шийдвэрийг шүүх хэлэлцээд, түүнийх нь дагуу зарим нэгэн хүмүүсийг хорьж байгаа ийм туршлага бий.

Тийм учраас миний энэ гаргасан санал бол хууль буцаж хэрэглэхгүй гэдэг зарчмын дагуу урьд нь гаргасан шийдвэртэй холбоотой огт асуудал хөндөгдөхгүй. Буцаж хэрэглэхгүй учраас. Тэгэхээр ирээдүйд гарах эрх зүйн акт дээр энэ Засгийн газрын хамтын шийдвэрийг шүүх хэлэлцэх нь буруу юм. Тийм учраас үүнийг Үндсэн хуульд заасных нь дагуу Засгийн газар хэрвээ буруу шийдвэр гаргах юм бол Цэц авч хэлэлцдэг, аль эсхүл Их Хурал үүнийг нь хянадаг ийм л тогтолцоогоор байг гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр Монгол Улсад өнөөдөр ажил хийдэг хүн дунд шатанд ерөөсөө байхгүй боллоо. Өөрөөр хэлбэл Засгийн газрын гаргасан шийдвэрийн дагуу зарим хүмүүсийг нь аваачаад хорьчхоор хүмүүс айгаад ажил хийдэггүй ийм нөхцөл байдал уруу орж байна. Дээрээс нь аль нэгэн улс төрийн нам ялж гарч ирдэг. Тэгээд буцаагаад Засгийн газрын аливаа нэгэн шийдвэрийг авч очоод нөгөө эсрэг намынхаа хүмүүсийг ялладаг ийм зүйл маань цаашдаа Монголын хөгжилд маш том чөдөр тушаа болох юм байна.

Тийм учраас хамгийн нэгдүгээрт нэг зүйлийг ойлгоорой. Энэ Их Хурлын протоколд би албан ёсоор тусгахыг хичээж байгаа. Тэгэхээр энэ хууль бол буцаж үйлчлэхгүй. Ирээдүйд гарах Засгийн газрын актын хэм хэмжээг тогтоох тухай асуудал юм. Тийм учраас манай Их Хурлын гишүүд ялангуяа өнөөдөр МАН олонх болж байгаа, Засгийн газарт олонх болчихсон, 100 хувь Засгийн газартаа хяналт тавиад ажиллаж байгаа. Энэ тохиолдолд ирээдүйд гарах энэ актын төлөө .../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн ээ, энэ дээр 3 асуудал байгаа учраас Үндсэн хууль, хууль тогтоомжид нийцүүлэн гүйцээн боловсруулах чиглэл өгөөд санал хураалт явахгүй явж болж байна. Яагаад гэхээр, бичилт нь нэгдүгээрт болохгүй байна. Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэдэг чинь шүүх Үндсэн хууль зөрчих гээд байгаа юм шиг. Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг угаасаа шүүх шийдэхгүй, үүнийг Үндсэн хуулийн цэц шийднэ. Харин үүнийг Үндсэн хуулийн 45.2, Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэр гаргах бөгөөд, энэ нь хуульд нийцэхгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно гэсэн нэг ийм агуулгатай заалт. Тэр Үндсэн хуулийн 45.2-т нийцүүлээд өөрчлөөд явах нэг хувилбар бий.

Хоёрдугаарт, Засгийн газрын шийдвэр хүний эрх зөрчих юм бол 16.14 чинь бас тэр талаараа гомдол гаргах эрхтэй уялдах болно. Тэгэхээр үүнийг харгалзаж санал хураахгүй бол энэ өөрөө бас.

Ингээд гүйцээж хуульд нийцүүлж боловсруулах чиглэл өглөө.45.2-той нийцүүлээд. Энэ бол бас байж болох. Ер нь шүүх тогтолцоо хэвтээ болж байгаа учраас... Пүрэвдорж гишүүн ээ, үүнийг ингээд санал хураахгүй хойшлууллаа.

2.Төслийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.9.Нийт шүүгчийн дийлэнх олонх оролцсоноор чуулганыг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг чуулганд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг

Санал хураалт. Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулж байна.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 70.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Мөнхцэцэг гишүүний санал яагаад болохгүй байсан юм бол. 570 хүний 66.6 хувь гэдэг чинь 300 хүн л оролцох асуудал шүү дээ.

3.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “доошгүй” гэснийг “дээшгүй” гэж өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар
Нямбаатар гишүүн үг хэлнэ.

Х.Нямбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч маань Монгол Улсын Үндсэн хуульд заасан албан тушаалтан. Одоо энэ төслийн 27 дугаар зүйлд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг дор дурдсан байдлаар томьёолсон байгаа. Тухайлбал Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааныг зарлах, бэлтгэлийг хангах, даргалах, Улсын дээд шүүхийг гадаад, дотоодод төлөөлөх гэх мэт энэ эрхүүдийг заасан. Одоо ажлын хэсгээс ямар байдлаар оруулж ирээд байгаа вэ гэхээр Улсын дээд шүүхийг аль нэг танхимд шууд харьяалуулна гэдэг ийм агуулгаар оруулж ирж байгаа. Тэгэхээр би ямар санал гаргасан бэ гэхээр Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч бол ерөнхий шүүгч гэдэг тэр агуулгаар ажиллах ёстой. Энэ удаагийн Шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэрэг маргааныг эцэслэн шийддэг үе шатыг нэгдүгээрт байхгүй болгочихсон.

Хоёрт, Улсын дээд шүүхийн шүүгч маань одоогийн энэ томьёоллоор явах юм бол зөвхөн аль нэг танхимдаа харьяалагдана. Өөрөөр хэлбэл аль нэг танхимын тэргүүнд захирагдаж, танхимын үйл ажиллагаатай уялдаж явах ийм агуулгаар орж ирээд байгаа юм.

Тэгэхээр бид нар ерөнхий гэдэг тэр агуулгаа барьж ерөнхий шүүгч нь кабинетын чөлөөт уулзалтын зарчмаар аль нэг танхимд өөрөө харьяалагдаж, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож явах нь ерөнхий шүүгч гэдэг тэр агуулгаа илүү тодотгож өгнө гэж харж байгаа. Тийм учраас эрхэм гишүүд ээ, та бүхэн миний гаргасан саналыг дэмжээд, энэ кнопоо дарахгүй байвал энэ асуудал босч ирэх юм.

Тэгээд бид нар Хуралдаан даргалагчаас тодорхой чиглэл аваад гүйцээн боловсруулах явцад бусад зүйл, заалтуудтай уялдуулах талд эргээд ажиллах ийм боломж байгаа. Түүнээс одоо ажлын хэсгийнхний зарим хүмүүсийн үзэж байгаагаар ерөөсөө аль нэг танхимд л харьяалагдана. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч гэдэг бол бэлгэдлийн ийм шинж чанартай байна гэдэг ийм агуулгатай орж ирээд байгаа юм. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлал, өнөөдөр энэ батлагдан гарах гэж байгаа Шүүхийн тухай хуулийнхаа үзэл баримтлалыг харвал бид нар Ерөнхий шүүгчид бас зарим эрхүүдийг өгөх нь зүйтэй байгаа гэдгийг хэлье.

Тэгээд гишүүд та бүхэн миний саналыг дэмжиж байгаа тохиолдолд кнопоо дарахгүй байж энэ саналыг босгож өгөөч гэдгийг хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн

Б.Энхбаяр: Энэ хуулийн гол концепци бол нэгдүгээрт шүүх эрх мэдлийг улс төрийн нөлөөллөөс салгах, хоёрдугаарт шүүхийн дотоодод байгаа дарга хэв шинжээс нь салгах гэсэн ийм үндсэн концепцтой шүү дээ. Өөрөөр хэлбэл хонгилыг нураах. Хонгил яаж яваад байгаа вэ гэхээр томилогдсон албан тушаалтан буюу Ерөнхийлөгч түүний дор Монгол Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч гэсэн пирамид тогтолцоогоор явж байгаа. Энэ тогтолцоог нь нураах гэхээр, үүнийг нь буцааж амилуулна гээд. Нэг гараараа хонгил нураах гэж байгаа юм шиг, нөгөө гараараа бол гаргаж байгаа санал нь хонгилыг нураалгахгүй гэсэн санал гаргаж байгаа юм. Дуртай хэрэг дээрээ орж шийдэж байсан тохиолдол байгаа шүү дээ. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч байсан Зориг гэдэг хүн бол талийгаач Зоригийн хэргийг өөрөө орж удирдаад л шийдчихсэн.

Ерөнхий шүүгч гэдэг чинь дуртай танхимдаа ордог, дуртай хэргээ шийддэг ийм хаан биш шүү дээ. Адилхан шүүгч шүү дээ. Үүнийг буцаагаад хаан болгож гэж санал гаргаад байгааг ойлгохгүй байгаа. Тийм учраас Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжиж, тийм гэсэн санал дарж өгөөч ээ гэж гишүүдээсээ хүсье.

Г.Занданшатар: Сүхбаатар гишүүн бас үг хэлье гэсэн. Одоо үг тасалсан. Түрүүн хоёр гишүүнээр тасалсан.

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 66.2 хувийн саналаар энэ Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.6.5.4 дэх заалт нэмэх:

“25.6.5.4.Улсын дээд шүүх нь авлига, албан тушаалын, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хүн, амьтан, байгаль орчны эсрэг гэмт хэргийг хяналтын журмаар шийдвэрлэх;”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 72.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.6.5.4 дэх заалт нэмэх:

“25.6.5.4.хуулийн нэгдмэл хэрэглээг тогтооход зарчмын ач холбогдолтой бол.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 73.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.1.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа

Адьяа гишүүн үг хэлнэ.

Ш.Адьяа:Энэ зарчмын зөрүүтэй санал гаргаад Хууль зүйн байнгын хороонд дэмжигдээгүй юм. Тэгэхээр энэ томилгоотой холбоотой асуудал. Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой асуудал байгаа. Энд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс өргөн мэдүүлсэн шүүгчийг 14 хоногийн дотор Ерөнхийлөгч томилох ийм үүрэг чиглэлийг Улсын Их Хурлын энэ хуулиар өгч байгаа.

Тэгэхээр энэ томилогдох, томилох, төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчим гэдэг ийм юм энэ дээр алдагдаад байгаа тухай би яриад байгаа юм. Тэгэхээр зарим гишүүд хар хүний өмнөөс шар хүн. Бараг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга ч гэж ингэж яриад байгаа. Ийм ойлголт биш ээ. Саяхан бид нар орон нутгийн Засаг захиргаа түүний удирдлагын тухай хуулийг баталсан. Энэ дээр Монгол Улсын Ерөнхий сайд тухайн шатны Засаг даргыг томилохдоо буцааж болдог, өөр хүнийг томилж болдог ийм хуулийг баталсан. Гэтэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайдад хамаардаг хууль гэж байж болохгүй.

Ийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн томилох бүрэн эрхэд халдсан

ийм зохицуулалт байна гэж 14 хоног гэдгийг нь ер нь Ерөнхийлөгч томилно гэсэн ийм ерөнхий зүйлийг энд оруулж өгөөрэй гэсэн юм. Яагаад гэхээр энэ анхан шүүгчийн сонгон шалгаруулалт бүх арга хэлбэрт Ерөнхийлөгч ямар ч хамааралгүйгээр энэ томилгоог явуулж байгаа юм. Тэгэхээр ёсчилно гэдэг юмыг Энхбаяр дарга яриад байгаа юм. Тэгэхээр ёсчилно гэвэл үүнийг Үндсэн хуулиас нь авч хаях хэрэгтэй шүү дээ. Ийм учраас энэ саналыг дэмжиж өгөөрэй. Одоо юм бүхэн өнөөдөр хойд захын хар гэр гэдэг шиг Ерөнхийлөгч уруу өнөөдөр бүх юмыг муу муухай бүх энэ нийгмийн муухай бүхнийг хамруулж байгаа шүү дээ. Тийм учраас энэ Ерөнхийлөгч томилогдох, томилогдохгүйн тухай асуудал биш ээ. Томилогдохгүй бол дараагийн Ерөнхийлөгч бас л ийм асуудал ярина шүү дээ. 6 жилийн асуудал биш, 60 жилийн асуудлыг бид ярьж энд хандах ёстой.

Тийм учраас та бүхэн миний саналыг дэмжиж, үгүй гэдэг кнопыг дарахыг хүсэж, та нөхдөдөө уриалж байна.

Г.Занданшатар: Үг хэлж дууслаа.

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.2.6 дахь заалт нэмэх:

“37.2.6.Улсын Их Хурал 90 хоногийн дотор танилцах сонсгол зохион байгуулсны дараа Ерөнхий зөвлөлийн дарга шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид албан бичгээр танилцуулна.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 70.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Төслийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.6.Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн тухайн шүүхийн Ерөнхий шүүгч гурван жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Танхимын тэргүүнийг нэг удаа улируулан томилж болно.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар
Хишгээгийн Нямбаатар гишүүн үг хэлнэ.

Х.Нямбаатар: Баярлалаа. Бид нар тал талаасаа өөр өөрсдийнхөө үзэл бодлыг уралдуулж байгаа шүү дээ. Тэгээд камер дээр би хонгил угсрах гээд байгаа бололтой тийм юм ярьж болохгүй Энхбаяр аа. Энэ Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч гэж Үндсэн хуульд заасан албан тушаалтан өөрт нь тодорхой эрхүүдийг нь энэ 27 дугаар зүйлээр өгье гэж ярьсан.Танхимын тэргүүнээ томилж чадахгүй, өөрөө танхимынхаа дотор нь захирагдаж явдаг ерөнхий шүүгч гэж ямар логик байх юм бэ? Гишүүд өөрсдөө та нар бодоцгоо. Дээд шүүхийн ерөнхий

шүүгч томилогдлоо.Томилогдмогцоо өөрөө аль нэг танхимдаа харьяалагдана. Тухайн танхимынхаа тэргүүнд захирагдаж явна. Тэгээд танхимынхаа тэргүүнийг томилж чадахгүй тийм Ерөнхий шүүгч гэдэг ийм ойлголт энд байж болохгүй.

Гишүүд энэ Шүүхийн тухай хуулийг маш удаан тал талаас нь нухацтай хэлэлцэж байгаа. Энэ 4 дүгээр сард хуучин Засгийн газар өргөн барьсан төсөлд агуулгын хувьд шинэ Засгийн газар байгуулагдаад энэ шүүхийн томилгоо, Шүүхийн ерөнхий зөвлөл захиргааны байгууллагыг анх барьсан төслөөс нь 180 градусаар өөр болгосон. Энэ бол бидний санал байсан. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан зүйл байсан. Шүүгч нарыг чөлөөлдөг, огцруулдаг энэ эрхийг мөн Үндсэн хуулийн шинэ байгууллага шүүхийн сахилгын хороонд давхар харьяалуулсан. Ингээд томилох, чөлөөлөх эрх мэдлүүд тус тусдаа ангид болж ирж байгаа юм.

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг яагаад ийм өнөөдрийнх шиг ийм эрх зүйн байдалтай болгохоор ямар үр дагавар гарах вэ гэдэг асуудлыг би эргэж ярих гээд байгаа юм. Энэ юу вэ гэвэл, өнөөдөр танхимын зохион байгуулалтаар Улсын дээд шүүх үйл ажиллагаагаа явуулаад нэлээд удсан ийм зүгширсэн байдалтай байгаа. Энэ танхимын тэргүүнээ Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь томилдог ийм л байх учиртай юм. Одоо тэгэхээр өмнөх 4 дүгээр санал унасантай холбоотойгоор би энэ саналаа татаж авч байна. Яагаад гэвэл тэр санал дэмжигдсэн учраас энэ саналыг босгох ямар ч шаардлагагүй болж байгаа юм. Тэгэхээр бие бие уруугаа камер хараад, дэлгэц хараад улс төр хийж болно, гэхдээ цаана нь гарах эцсийн үр дагаврыг бодоорой. **Энэ дараа нь Цэц дээр унах асуудал шүү гэдгийг би протоколд тэмдэглүүлж үлдээе.**

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Баярлалаа. Энэ дээр ийм байна. Тийм байх ёстой, ийм байх ёстой гээд л сургаал айлдаад байх юм. Хэн нь хэндээ заагаад байгаа юм бэ? Тэгээд Засгийн газрын гишүүн байж болно, Улсын Их Хурлын гишүүн байж болно. Давхар дээлтэй байж болно. Тэгээд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, сая Үндсэн хууль гээд өөрөө яриад байх шиг байна, энэ Хууль зүйн сайд. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан шүү дээ. 12 дугаар дүгнэлт. Авлига, албан тушаалын хэргийг дахиж мөрдөхөөргүйгээр тийм байдалтай оруулчихаад, тэгээд таны хууль зүйн мэдлэг чадвар ямар байна вэ? Тэгээд Байнгын хорооны хурал дээр гишүүдийг янз бүрээр хэлээд байдаг. Хамгийн суурь зарчим байгаа шүү дээ. Шүүхээс хэн нэгнийг гэм буруутай гэж хэлээгүй бол хэнийг ч гэм буруутай гэж хэлэх ёсгүй шүү дээ.

Тэгэхэд одоо Хууль зүйн сайд нь ийм анхан шатны юмаа мэдэхгүй янз бүрийн Байнгын хороо, янз бүрийн хурал дээр гишүүдийг ялтай гэм буруутай юм шиг ингээд яллаад байдаг. Шүүхийн өмнөөс шүүх болчихсон. Энэ энийгээ болиорой та.

Г.Занданшатар: Ганбат гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлнэ шүү.

Д.Ганбат: Тэгээд ямар хууль зүйн сургууль, ямар мэдлэг боловсролтой ийм хүн болчихоод ийм юм яриад байна вэ? Бас зарим юман дээр чинь эргэлзээд байна шүү.

Г.Занданшатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэхгүй бол тасаллаа. Хууль зүйн сайдыг шүүгээд байх юм, энэ чинь их өөр санал хураалт явж байхад.

Саналаа татаж авлаа. Энэ цэцийн асуудлын талаар Хууль зүйн сайдад анхааруулах юм хэлж байна.

10.Төслийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.4 дэх хэсэг нэмэх:

“43.4.Шүүгчид Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуульд зааснаас бусад цол, одон, тэмдэг, шагнал олгохыг хориглоно.”

Санал гаргасан:Ажлын хэсэг
Норовын Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүд энэ дээр нэг анхаарал хандуулаад өгөөрэй. Ажлын хэсэг дээр яриад, бас шүүгчидтэйгээ ярилцаад, манай шүүгчдийг цол, одон тэмдэг гээд янз бүрийн юмаар шагнадаг, шагнуулдаг асуудал чинь нөгөө шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх ийм юм болох вий гэдэг болгоомжлолоор ярьсан чинь манай шүүгчид бас нээрээ ч бид нарт төвөг учирч мэдэх зүйлийн нэг мөн юм гэж.

Өмнө нь би бодит байдлыг хэлэхэд одоо тэгэхгүй байх гэж бодож байгаа юм, манай энэ хууль батлагдвал. Монгол Улсын өмнөх Ерөнхийлөгч нөхөр бол шүүгчийг шагнаж байгаад хэрэг шийдүүлдэг. Хэрэг шийдүүлчхээд шүүгчийг шагнадаг. Гавьяатынх нь цолыг тэнд дүүжилж байгаад хүмүүсийг хөдөлгөдөг нэг иймэрхүү л муухай систем байсан юм. Бас тэр маань дахиад сэдэрчих юм биш байгаа гэж бодож, тэгээд шүүгчид маань ч гэсэн өөрснөө ер нь энэ хэрэггүй юм биш үү гэж.

Гуравт нь, бид нар Монгол Улс хаашаа явах ёстой юм бэ гэдгийг бодоорой. Бид нар ядаж шүүгчдийгээ нэг ийм одон тэмдэг, медаль элдэв юмны хойноос хардаггүй, яг л тэр асуудлаа шударгаар төв шийддэг тийм байхад нь энэ бас их саад тотгор болно гэж бодож ажлын хэсэг дээр яриад оруулсан юм. Тэгээд манай Байнгын хороо дэмжсэнгүй. Та бүхэн тэгээд мэргэн ухаандаа тунгааж бодоорой. Хэдүүлээ циркийн амьтан шиг хэн нэгний гар хөлийг харж амьдармааргүй байна. Тэр дотроо шударга ёсыг тогтоох ёстой шүүгчид. Тэр төрөөс авдаг бусад хангамжийг нь хангалттай өгөх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Энэ миний байр суурь шүүг.

Г.Занданшатар: Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 66.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

11.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.6.Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 65 нас байна. Улсын дээд шүүхийн шүүгч бүх насаараа томилогдох бөгөөд өөрөө хүссэн

тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан

Дэлгэрсайхан гишүүн, Чинзориг гишүүд нараар үг тасаллаа. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Энэ 49.6-д ажлын хэсэг дээр санал гаргасан юм. Тэгээд миний гаргасан саналыг Чинзориг гишүүн бас дэмжиж байгаа юм билээ. Ер нь Засгийн газрын анхны оруулж ирсэн төслөөрөө шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг 65 гэж заасан байгаа. Тэгээд Улсын дээд шүүхийнхийг бүх насаар нь гэж би санал гаргасан. Бүх насаар нь гэдгийг орхиод Засгийн газрын анхны оруулж ирсэн төслөөр нь 65 хүртэл байна гэдгийг зарчмын зөрүүтэй санал дээр манай гишүүд дэмжиж өгөөч ээ гэж санал гаргаж байгаа юм. Яагаад вэ гэхээр нэгдүгээрт, шүүх бол өөрөө их онцлогтой байгууллага. Бүхий л хүмүүсийн аж ахуйн нэгж, ард иргэдийн хувь заяаны асуудлыг шийддэг. Ялангуяа дэлхий нийтийн жишиг ч гэсэн тэр хүн нас ахих тусмаа хор нь гарсан, бас цаашилбал амьдралынхаа туршлагаар зөв шийдвэр гаргах магадлал нь өндөр байдаг. Энэ утгаар нь тэтгэврийн насыг Засгийн газрын анх оруулж ирсэн төслийн 65 гэдгээр нь санал хураалгах ийм саналтай байгаа юм. Тэгээд энэ дээр манай гишүүд дэмжиж өгөөрэй гэдгийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ийм агуулгатай санал ч бас хураагдсан л даа, хоёр ч хураагдсан. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Би энэ 49.6 дээр санал хэлэх гээд байгаа юм. Өчигдөр ч уг нь санал хэлсэн юм. Төрийн албаны тухай хуулиар чинь төрийн албан хаагчийн насны дээд хязгаар 65 байна гээд Төрийн албаны хуультай. Шүүгч чинь төрийн тусгай албан хаагч. Тэгэхээр төр бол энэ төрийн албан хаагчиддаа ижил тэгш хандах ёстой л доо. Тийм учраас насны дээд хязгаар нь 65 байна гэдгээр уг нь авчихбал тэр Төрийн албаны тухай хуультайгаа нийцээд их оновчтой болох юм.

Дэлгэрсайхан гишүүний гаргасан Улсын дээд шүүхийн гишүүн бүх насаараа байна гэдэг тэр арай бас болохгүй болов уу. Энэ 65 байна гэдэг нь зөв юм шиг байгаа юм.

Хоёрдугаарт нь, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ эцэслэн сайжруулж оруулж ир гэсэн чиглэл өгөхгүй бол өчигдөр чинь тэтгэврийн настай холбоотой хоёр санал хураагдаад хоёр өөр ойлголт явчихсан. Насны дээд хязгаар нь 60 байна гээд нэг орчихсон, 55 насанд хүрсэн 25 жил ажилласан шүүгч тэтгэвэр тогтоолгоно гээд нэг орчихсон. Нэг заалт нь шүүгчээр 30 жил, түүнээс дээш ажилласан бол 55 настай тэтгэвэрт гарч болно гээд. Ингээд нэг бол 25 жил ажилласан бол тэтгэвэрт гарч болохоор, нэг бол 30 жил ажилласан бол 55 насанд хүрсэн бол тэтгэвэрт гарч болохоор ингээд тэтгэврийн нас чинь маш олон ойлгомжгүй зүйлээр явчихсан юмаа дарга аа. Тэгэхээр энэ тэтгэврийн настай холбоотой асуудлыг эцсийн хэлэлцүүлэг дээрээ нэгтгэн сайжруулан засаж оруулж ирээд чиглэл өгөхгүй бол энэ чинь маш олон тоонууд яваад учраа олдохоо байлаа.

Шүүгчдийн цалинтай холбоотой асуудлыг би хоёр хувиар нэмнэ гэдэг дордуулсан зүйл болчих гээд байгаа юм. Засгийн газраас жил тутам инфляцийн

түвшингээ дордуулахгүй гээд сүүлийн 3 жилд гэхэд 8 хувиар цалин нэмж ирсэн. Тэгэхээр шүүгчдийн цалинг 2 хувиар нэмнэ гэдэг чинь төрийн бусад албан хаагчдаас дордуулсан заалт болчхоод байгаа учраас би 2 хувь гэдгийг дэмжихгүй байгаа юм.

Энхбаяр гишүүний яриад байгаа зэрэг дэвийг шүүгчдэд олгохгүй гэж байгаа бол шүүгчдэд энэ хуулиар чинь онцгой нөхцөлийн нэмэгдэл олгохоор болж байгаа шүү дээ. Тийм учраас энэ зэрэг дэвийн нэмэгдлийг онцгой нөхцөлийн нэмэгдэлд нь оруулж тооцоод, онцгой нөхцөлийн нэмэгдлийг арай ахиу өндөр тогтоогоод өгчих юм бол шүүгчдийн цалин буурахгүй байх, тогтвортой өндөр цалин хангамжтай байх ийм нөхцөл бүрдэх юм гэсэн би ийм зарчмын байр суурь хэлээд байгаа юм. Үүнийг ажлын хэсэг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарч, зөвлөлдөнө биз гэсэн ийм саналтай байна.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил.

Ц.Мөнх-Оргил: Гишүүд ээ, Дэлгэрсайхан гишүүний саналыг дэмжиж өгөөч ээ гэж та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. Төрийн албаны тухай хуультайгаа зөрчилдөнө нэгдүгээрт. Хоёрдугаарт бид одоо яг өнөөдөр Улсын Их Хурлаараа Хөдөлмөрийн тухай хуулиа хэлэлцэж байна. Энэ хуулиараа Төрийн албаны хуультайгаа нийцүүлэх үүрэгтэй, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 65 нас гэдэг бол шүүгч нарт тэтгэвэртээ гарахад боломжийн нас. Энэ туршлагатай, мэдлэг боловсролоо цуглуулчихсан ид ажлаа хийх бололцоотой нас. Түүнээс 60 гэдэг бол шүүгч нарыг нөхцөл байдлыг дордуулж байгаа юм. Би бол шүүгч нарыг шүүмжилж байгаа, хэвлэл мэдээллээр ч гэсэн шүүмжилж байгаа. Гэхдээ шүүгчийн ажил бол хэцүү, амаргүй ажил гэдгийг бид нар хүлээн зөвшөөрч Төрийн албан хаагч гэдэг утгаар нь хүндэтгэлтэй хандах ёстой болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 40 гишүүн дэмжиж, 58.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Дэлгэрсайхан гишүүний санал дэмжигдээгүй, Байнгын хорооны санал дэмжигдсэнтэй холбогдуулаад 41.1 дээр Энхбаяр гишүүн ээ ийм санал хураагдсан юм.

31 дэх санал хураалт дээр. 41.1.шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн эсхүл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.

41.2.9.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн гэхээр 65 гэдэг агуулгатай. Тэгтэл Норовын Алтанхуяг гишүүний өчигдөр гаргасан санал дэмжигдчихсэн. Тэгэхээр энэ хоёрыг хуульд нийцүүлж нэг мөр тэгшлэхгүй бол хуульд зөвшөөрснөөр, захиргааны байгууллага зөвшөөрснөөр хийх гээд энд хоёр санал хураалтын зөрчил үүсэж байгааг эцсийн хэлэлцүүлэг дээрээ Байнгын хороон дээр янзалж тэгшлэх хэрэгтэй байна. Яагаад гэвэл 41.1 бол шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол чөлөөлөгдөж болно гэж байна. Өөрөө чөлөөлөгдөхгүй бол байгаад байж болно гэсэн агуулга байгаа юм.

Ингээд дараагийн санал хураалтыг явуулъя.

12 дахь саналыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж саналаа татаж авч байна гэж ойлгож байна.

Парламентын хяналт шалгалтын тухай хуулиар нийтийн сонсголд оруулж болно. Тэгэхдээ импичмент хийх бол Үндсэн хууль зөрчинө. Үндсэн хуулийн 49.6, 54.1 хоёрт тодорхой заасан байгаа.

Пүрэвдорж гишүүн саналаа татаж авлаа.

13.Төслийн 73 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 73.1.27 дахь заалт нэмэх:

“73.1.27.шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг орон сууцаар хангах хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 72.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

14.Төслийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“78.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, анхан болон давж заалдах шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг тухайн шатны шүүхийн шүүгчдээс сонгоно.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан
Дэлгэрсайхан гишүүн үг хэлье.

Б.Дэлгэрсайхан: Энэ 78.2 дээр ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, анхан шатны давж заалдах шатны шүүхээс тусбүр хоёр шүүгчийг гэдэг энэ бол хуралдаанаасаа 5 гишүүнийг сонгоно гээд ингээд оруулчихсан байсан юм. Яагаад үүнийг шат шатнаас сонгох нь давуу юм бэ гэхээр нийтдээ анхан шатны шүүгч бол 390-ээд, давж заалдах шатны шүүхийн шүүгч нар нь 110-аад, дээд шатны шүүхийн шүүгч нь 23 орчим ийм тоотой байгаа юм байна, өнөөдрийн байдлаар.

Тэгэхээр шат шатнаас нь сонгохгүй болохоор наадах чинь харилцан адилгүй, одооноос жишээлбэл дарга нар нь тэр хүнийг сонгох, энэ хүнийг сонго гэдэг юм уу, багцлахаараа тиймэрхүү юм уруугаа хэлбийгээд явчих юм биш биз дээ. Тэгэхээр яг Дээд шүүхийнх нь Дээд шүүхийн шүүгч нар дундаасаа, давж заалдах шатны шүүхийнх нь өөрсдийнхөө давж заалдах шатны шүүгч нар дундаасаа гэдэг ийм байдлаар санал гаргасан юм. Тийм учраас үүнийг дэмжиж өгөөч ээ.

Тэгээд дээрээс нь Их Хурлын даргад нэг юм асуухад. Энэ санал хураалгаж байгаа юмыг зарим гишүүд ойлгохгүй байх шиг байна. Байнгын хорооны

саналаар гээд санал хураагдсаны дараа Байнгын хорооны саналыг дэмжиж байна гээд гарчхаад байх юм. Тэгэхээр энэ гишүүд, үгүй, тийм гэдгээ буруу, зөрүү ойлгож дараад байх шиг байх юм. Үүнийг одоо яах ёстой юм бэ?

Г.Занданшатар: Гишүүд буруу ойлгоогүй байх аа. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье. Дэлгэрсайхан гишүүн ээ, та энэ саналаа татаад авчихбал зүгээр байна. Яагаад вэ гэхээр, яг ийм ижил агуулгатай санал хураалт 57 дугаар санал хураалтаар давах шатны шүүхээс тусбүр хоёрыг гээд санал хураалт явуулчихсан.

78.2-т, Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тусбүр хоёр шүүгчийг нийт шүүгчдийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно гээд нэг агуулга дотор орчихсон. Таных яг анхан болон давж заалдах шатны ...

Б.Дэлгэрсайхан: Их Хурлын дарга аа, би тоо яриад байгаа юм бишээ. Ойлгож байна. Гэхдээ томилогдож байгаа, сонгогдох хүмүүс нь шат шатнаасаа сонгогдвол гэдэг ийм л санал гаргаж байгаа юм. Тэгэхгүй болохоор зэрэг аль шатанд ямар шүүгч сонгогдох гэж байгааг бусад нь танихгүй мэдэхгүй учраас энэ бол өрөөсгөл сонголт болчих вий гэдэг ийм л юм ярьж байгаа юм.

Г.Занданшатар: Зөв, зөв. Тухайн шатны шүүгчдээсээ гэж байгаа юм байна тийм ээ.

Б.Дэлгэрсайхан: Тийм, яг зөв. Анхан шатны 390 шүүгч өөрсдийнхөө шатнаасаа гарах хоёр шүүгчийг сонгох гэдэг ийм санал гаргасан юм.

Г.Занданшатар: Тэгээд нийт шүүгчдийн чуулганаа дахиад л хуваах болох асуудал байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Дэлгэрсайхан гишүүний гаргаж байгаа санал нь өөрөө Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5-тай нийцэхгүй байгаа юм. Яагаад вэ гэхээр, Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн 5-ыг шүүгчид дотроосоо сонгоно гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл нийт шүүгчдийнхээ чуулганаас сонгох ёстой. Яагаад гэвэл, энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд бол Дээд шүүхээс төлөөлж байгаа шүүгч бол Дээд шүүхийнхээ эрх ашгийг хамгаалах гэж байгаа хүн биш. Энэ таван шүүгч чинь бүгдээрээ Монгол Улсын нийт шүүгчдийн бие даасан байдал шүүхийн, шүүгчийн хараат бус байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй. Тэгээд ерөөсөө энэ шүүх эрх мэдлийнхээ бие даасан байдлыг яаж хангах вэ гэдэг энэ нийт шүүгчдийн хуралдаанд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлнэ. Тэгж байж нууц санал хураалтад орж сонгогдоно гэдэг учраас.

Дэлгэрсайхан гишүүн болохоор Дээд шүүхийнхийг ерөөсөө Дээд шүүхээс нь сонгоё. Тэр давахыг нь давахынхан хуралдаад сонгочих гэхээр ийм 3 шүүгчдийн ийм чуулган болох юм шиг болчих гээд байгаа юм. Тийм учраас Үндсэн хуулийнхаа энэ баталсан концепцотой нийцэхгүй байгаа юм. Тэгээд л хүлээж аваагүй юм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт. Байнгын хороо энэ саналыг дэмжээгүй, Байнгын хорооны саналаар гэдэг маань Байнгын хорооны дэмжээгүйг дэмжье гэдэг саналаар санал хураалт явуулж байна.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 72.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

15.Төслийн 79 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 79.11 дэх хэсэг нэмэх:

“79.11.Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлийн дарга ахална.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа

Цэндийн Мөнх-Оргил гишүүн үг хэлнэ. Ширнэнбаньдийн Адьяа гишүүн үг хэлнэ. Энэ хоёр гишүүнээр тасаллаа.

Ц.Мөнх-Оргил: Дарга аа, би энэ саналыг дэмжихгүй байгаа юм. Өмнөх санал дээр ийм санал нэмж хэлэх гэсэн юм. ***Протоколд оруулах гэсэн юм. Бид нар шүүгчдийн нийт чуулганаар Ерөнхий зөвлөлийн Сахилгын хорооны гишүүдийг шүүгчдээсээ сонгоно шүү дээ. Тэгээд Байнгын хороон дээр болон Ажлын хэсэг дээр нэг зарчим тохирсон юм. Тоонд нь тулгаж сонгохгүй, 3-4 хүн илүү сонгож запас үлдээнэ. Яагаад гэвэл гэнэтийн орон тоо гарах юм уу, ерөнхий зөвлөлийн Сахилгын хорооноосоо гарах юм бол байн байн жилдээ хэдэн ч удаа онолын хувьд нийт шүүгчдийн чуулган хуралдуулаад байх шаардлага үүсэж магадгүй. Тийм учраас бусад улс орнуудад ч байдаг, ер нь зардал мөнгөө хэмнэх үүднээс илүү гишүүдийг сонгож, запас байлгаж байгаад 4 жилдээ нэг удаа хуралдах тэр боломжийг нь бүрдүүлье*** гэсэн санал оруулсан юм. Үүнийг протоколд оруулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Мөнх-Оргил гишүүний санал протоколд туслаа. Ширнэнбаньдийн Адьяа гишүүн.

Ш.Адьяа: Түрүүн би чуулган дээр энэ саналтай холбогдуулаад үгээ хэлчихсэн юм. Тэгэхээр энэ шүүх хараат бус байх гэдэг энэ зарчимд тулгуурлаж л ийм санал хэлээд байгаа юм шүү дээ. Улсын Их Хурал өнөөдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн Сахилгын хороо гэдэг энэ хоёр байгууллагыг өөрийнхөө энэ хуулиар өөрийнхөө мэдэлд хөрөнгө санхүү, боловсон хүчний хувьд томилдог ийм эрхийг авч байгаа. Тэгэхээр энэ томилгооны асуудлыг Улсын Их Хурлын нэг гишүүн ахалж, зохион байгуулна гэдгийг зөвшөөрөх боломжгүй байна гэдгийг л хэлээд байгаа юм.

Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд төрийн албыг сонгон шалгаруулдаг, томилдог, Улсын Их Хурлын харьяаны бүтцийн байгууллага байхад яагаад заавал Улсын Их Хурлын нэг гишүүн ахлаад, энэ Үндсэн хуулийн бүтцийн байгууллагын боловсон хүчнийг томилох гээд байгаа юм бэ гэдэгтэй санал нийлэхгүй байгаа юм. Энэ бол үнэхээр Үндсэн хуультай зөрчилдсөн, Үндсэн

хуулийн суурь үзэл баримтлалыг зөрчсөн ийм асуудал болно.

Төрийн албаны зөвлөл энэ хүмүүсийг сонгон шалгаруулчихаар яагаад болохгүй байгаа юм бэ? Олонх, цөөнхийн төлөөлөл, мэргэжлийн холбоод, хуульчдын холбоо, Ерөнхийлөгчийн институцийн төлөөлөл оролцоод, үүнийг сонгон шалгаруулсны дараа гаргаж ирсэн хүмүүсийг нь Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж томилъё гэсэн ийм л саналыг оруулаад байгаа шүү дээ. Энэ яагаад болохгүй байгаа юм бэ? Төрийн албаны зөвлөлдөө бид итгэхгүй байгаа юм уу? Өнөөдөр Улсын Их Хурлын бүтцийн байгууллага шүү дээ, заавал яагаад Их Хурлын гишүүн үүнийг ахалж, заавал үүнийг ингэж томилох гэж байгаа юм, цаашдаа жинхэнэ эрх ашиг сонирхлын зөрчил болно. Өнөөдөр тэр бүлэглэлүүд гэдэг хүмүүс чинь хүнээ тавих энэ боломж үүгээр нээгдэж байна гэж үзэж байгаа учраас үүнийг би эсэргүүцэж үг хэлж, зарчмын зөрүүтэй санал оруулаад байгаа юм. Та бүхэн өнөөдөр энд нэгийг бодож, энэ санал хураалтыг өгөөрэй. Үнэхээр бид нар тэр хонгилыг нураая, шударга ёсыг бэхжүүлъя, хууль шүүхийн өмнө тэгш байя. Шударга шүүхээр шүүлгээ, шүүх хараат бус, бие даасан байна гэдэг энэ зарчмыг биелүүлж байгаа юм бол тэр Төрийн албаны зөвлөлөөр нь энэ хүмүүсийг сонгон шалгаруул л даа. Улсын Их Хурал томилгооны сонсголд энэ хүмүүст ямар хүн орж ирснийг нь сонсгоод, хасаж, цаашдаа дараагийн хүнийг оруулж болно шүү дээ. Яагаад заавал Улсын Их Хурлын гишүүн үүнийг томилох гээд байгаа юм бэ? Яагаад заавал Улсын Их Хурлын даргын захирамжаар энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн Сахилгын хорооны гишүүдийг томилох юм бэ гэдэг дээр би ийм зарчмын зөрүүтэй саналыг оруулаад яриад байгаа. Энэ дээр та нар бас өнөөдөр үнэхээр хонгилыг .../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт.

Санал хураалтад 68 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 72.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

16.Төслийн 100 дугаар зүйлийн 100.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“100.5.Улсын Их Хурал Сахилгын хорооны шүүгч биш гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Төрийн албан зөвлөлийн дарга ахална.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа

Санал хураалт.

Энэ санал хураалт дээр техникийн саатал гарсан байна. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Түрүүчийн санал хураалтын дүн, сүүлийн 41 дээрээ гараад ирлээ. Техникийн саатал гарсан учраас дахин санал хураалт явуулж өгнө үү. Хүчингүй болгох санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүний саналаар энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Найруулгын 3 дугаар саналтай адилхан гарчихлаа гээд байна.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 76.1 хувийн саналаар Пүрэвдорж гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Өмнөх саналыг хүчингүйд тооцсон учраас дахин санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 53 гишүүн дэмжиж, 79.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Найруулгын 3 дугаар саналыг дахиж явуулъя. Саяныхтай ижил нөхцөл үүссэн гэж гишүүд хэлсэн.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “бүх” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “холбогдох” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “заавал” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “/цаашид “Нийт шүүгчдийн хуралдаан” гэх/” гэснийг, 26.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг, 26.4 дэх хэсгийн “хэлэлцсэн” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.2.2 дахь заалтын “бие махбодь гэмтсэн буюу” гэснийг, 49.2.3 дахь заалтын “бие махбодь,” гэснийг, 49.4 дэх хэсгийн “гэмтсэн болон” гэснийг, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийн “/цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/,” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Энэ найруулгын саналыг дэмжье гэсэн томьёоллоор дахин санал хураалт явуулъя.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 55 гишүүн дэмжиж, 82.1 хувийн саналаар найруулгын 3 дугаар санал, саяны уншсан энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

1.1.анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

1.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

2/40.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 6 дахь хэсэг:

“3.Хяналтын шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргана.

5.Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.

6.Гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч, өмгөөлөгч, прокурор оролцохгүй.”

3/40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх нь анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэхийг хянаана.”

4/40.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх бөгөөд шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тогтоосон журмын дагуу томилно.”

5/40.8 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцлийг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3.Хяналтын шатны шүүхийн тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Хяналтын шатны шүүхийн тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, гомдол, эсэргүүцэл болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

4.Хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд уг тогтоолд гомдол гаргахгүй.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 71.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “22.1.3” гэснийг “22.3” гэж өөрчилж, “3.4 дүгээр” гэсний өмнө “2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Тэргүүний шийдвэрээр” гэснийг “шийдвэрээр” гэж, “Ерөнхий шүүгчийн” гэснийг “шүүгчдийн зөвлөгөөний” гэж,” гэж нэмж, “40.10 дугаар зүйлийн 3, 4 дахь хэсгийн “хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн” гэснийг “нийт шүүгчдийн” гэж, 40.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бичгээр” гэснийг “ажлын албаны даргаар дамжуулан бичгээр” гэснийг “40.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн нь” гэснийг “Танхимын зөвлөгөөнөөс” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 74.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.10, 40.11, 40.12 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, 70.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/122 дугаар зүйлийн 122.3 дахь хэсэг:

“122.3.Хяналтын журмаар гомдол гаргасан бол хэргийг хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарах, эсхүл хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэ хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар урьд нь авсан шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ хүчинтэй хэвээр байна.”

2/173 дугаар зүйлийн 173.5, 173.6, 173.7, 173.8 дахь хэсэг:

“173.5.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.

173.6.Энэ хуулийн 173.5-д заасны дагуу гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаана.

173.7.Энэ хуулийн 173.5, 173.6-д заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.”

173.8.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохгүй.”

3/176 дугаар зүйлийн 176.4, 176.5 дахь хэсэг:

176.4.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

176.5.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид хүргүүлнэ.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 74.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “бичмэл ба” гэсний дараа “цахим баримт,” гэж, 110 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 110.3 дахь хэсэг, 110.4 дэх хэсгийн “Бичмэл” гэсний дараа, мөн зүйлийн 110.1, 110.3 дахь хэсгийн “бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, 120 дугаар зүйлийн 120.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “,эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гаргасан бол” гэж тус тус нэмсүгэй.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 71.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.”

1/51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг:

“51.1.Анхан шат, хяналтын шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогч оролцож байгаа бол давж заалдах шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ.”

2/172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсэг:

“172.2.Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана:

172.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

172.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

172.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг:

“173.4.Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуулийн 167.5, 173.3-т заасныг хангаагүй бол анхан шатны шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.”

4/174 дүгээр зүйлийн 174.1 дэх хэсэг:

“174.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/176 дугаар зүйлийн 176.1, 176.3 дахь хэсэг:

“176.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 114.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

176.3.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн

шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, 70.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энхбаяр гишүүн ээ, энэ Иргэний хуульд прокурор гуравдагч этгээдээр нэхэмжлэл гаргасан бол нэхэмжлэл хэрэг үүсгэх эсэх дээр тийм агуулгатай байгаа байх. Тэгээд төрийн нэрийн өмнөөс шууд гомдол гаргах эрхийг нь прокурорт өгч байгаа юм байна, тийм ээ. Тэгэхдээ одоо шүүх хуралдаанд гуравдагч этгээдээр оролцож байгаа шүү дээ. Үүнийг нягталж үзээрэй. Энэ бусад хуультайгаа зөрчилдөж байж магадгүй шүү.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх “хуваарилна” гэснийг “хуваарилах бөгөөд уг журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байна” гэж, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн “шийдвэр, магадлалыг” гэснийг “шийдвэрийг” гэж, 172 дугаар зүйлийн 172.3 дахь хэсгийн “тооцож, улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох тухай шүүгч захирамж гаргана.” гэснийг “тооцно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.” гэж, 176 дугаар зүйлийн 176.4 дэх хэсгийн дугаарыг “176.6” гэж тус тус өөрчилсүгэй.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Т.Аюурсайхан: Санал хураалтад 67 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 71.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийн “буюу хяналтын” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн, 122 дугаар зүйлийн 122.2 дахь хэсгийн “болон хяналтын” гэснийг тус тус хассугай.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 67.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийн “79.2 дахь хэсгийг” гэснийг “79.2 дахь хэсэг, 176², 177¹, 178¹ дүгээр зүйлийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 67 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 74.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зүйл,” гэснийг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3, 4 дэх заалт болгох:

2/123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэг:

“123.2.Дараах үндэслэлээр Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргана:

123.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

123.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

123.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/124 дүгээр зүйлийн 124.3, 124.4, 124.5 дахь хэсэг:

“124.3.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.

124.4.Энэ хуулийн 124.3-т заасны дагуу гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаана.

124.5.Энэ хуулийн 124.3, 124.4-т заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.”

4/125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэг:

“125.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэг:

“127.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 105.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх

хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий дараах хэсэг нэмсүгэй:

1/124 дүгээр зүйлийн 124.6 дахь хэсэг:

“124.6.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохгүй.”

2/127 дугаар зүйлийн 127.4, 127.5, 127.6 дахь хэсэг:

“127.4.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

127.5.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

127.6.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хүргүүлнэ.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “75 дугаар” гэсний өмнө “16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Ерөнхий шүүгч” гэснийг “Шүүгчдийн зөвлөгөөн” гэж,” “даргалагч” гэсний өмнө “шүүх хуралдаан” гэж,” тус тус нэмэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 68.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “, эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар

хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарсан” гэж нэмсүгэй.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 74.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн “гэснийг” гэсний дараа “, 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг” гэж нэмэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 75.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 128, 129 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болгосугай.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 74.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн хуульд орохоос өмнө техникийн саатлаас болж хураагдсан 4 дүгээр саналыг дахиж хурааа. Техникийн саатлаар зарим гишүүдийн төхөөрөмж ажиллаагүй байна.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “, эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарсан” гэж нэмсүгэй.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “орон тооны” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийн “байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэснийг “байгууллага” гэж өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэсний өмнө “нэмэлт,” гэж нэмэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн ““мөн 25-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан даатгуулагч” гэсний дараа “, эсхүл 25-аас доошгүй жил Монгол Улсын шүүхийн шүүгчээр ажилласан шүүгч”” гэсний дараа “мөн зүйлд “Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсгийн “түдгэлзэнэ” гэснийг “түдгэлзэж болно” гэж өөрчлөх.

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Зөрчлийн тухай хууль нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хүлээхээргүй” гэснийг “хүлээлгэхээргүй” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав.Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх саналын томьёолол.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дэх заалтын “орон тооны” гэснийг хасаж, “ТӨ-VA-ийн тусгай албан тушаалд “Монголбанкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,”” гэснийг “ТӨ-VIA-ийн тусгай албан тушаалд “Монголбанкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,”” гэж өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав нэг. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх саналын томьёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хавсралтыг хасах:

“1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын нэг дэх заалт, мөн тогтоолын хавсралтын гарчгийн “Үндэсний статистикийн хороо,” гэсний дараа “Шүүхийн сахилгын хороо,” гэж, мөн хавсралтын “Үндэсний статистикийн хороо” гэсэн хэсгийн дараа “Шүүхийн сахилгын хороо” гэсэн 13 дахь хэсэг, түүнд “Тэргүүн түшмэл” гэсэн ангиллын “АА-1” гэсэн зэрэглэлд “Ажлын албаны дарга” гэж, “Эрхэлсэн түшмэл” гэсэн ангиллын

“АА-4” гэсэн зэрэглэлд “Хэлтсийн дарга” гэж, “АА-5” гэсэн зэрэглэлд “Ахлах референт” гэж, “Ахлах түшмэл” гэсэн ангиллын “АА-6” гэсэн зэрэглэлд “Референт” гэж, “АА-7” гэсэн зэрэглэлд “Ахлах шинжээч” гэж, “АА-8” гэсэн зэрэглэлд “Шинжээч” гэж, “Дэс түшмэл” гэсэн ангиллын “АА-9” гэсэн зэрэглэлд “Ахлах мэргэжилтэн” гэж, “АА-10” гэсэн зэрэглэлд “Мэргэжилтэн” гэж, “АА-11” гэсэн зэрэглэлд “Ахлах зохион байгуулагч” гэж тус тус хамааруулан нэмсүгэй.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван хоёр.Монгол Улсын шүүхийн тухай тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 20.9-д заасан ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор зохион байгуулж Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг сонгоно.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “хороо, Шүүхийн мэргэшлийн” гэснийг хасах.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж, 74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Улсын Их Хурал Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг батлахаас өмнө Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлсэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 37.2 дахь хэсгийн зохицуулалт хамаарахгүй.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 51 гишүүн дэмжиж, 77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 47.2 дахь хэсгийн дагуу шүүгчид олгох “онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн” нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.”

Энэ дээр Улсын Их Хурлын даргаас чиглэл өгөөд, эцсийн найруулга дээр ажлын хэсэг анхаарч байгаа учраас санал хураахгүйгээр чиглэлийг нэгтгэж найруулах чиглэлийг өгч байна.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“12 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 49.7 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 52 гишүүн дэмжиж, 78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 13, 14 дүгээр зүйл нэмэх:

“13 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагуу байгуулагдах Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны 2021 оны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж, 75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 8.14 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 75.2 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

Санал хураалт.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжиж, 72.7 хувийн

саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“12 дугаар зүйл.2013 онд Шүүх байгуулах тухай хууль баталсантай холбогдуулан шүүчээс чөлөөлөөд дахин томилоогүй шүүгч нарыг Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид дахин өргөн барьж шийдвэрлүүлнэ.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар

Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй санал.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 66 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, 71.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Чуулган 14 цагаас “Бүх шатны боловсролын байгууллагын чанар, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж байгаа арга хэмжээний талаар” Монгол Улсын Шадар сайдын мэдээллийг сонсоно.

Үдээс өмнөх чуулган үүгээр завсарлаж байна.

ЗАВСАРЛАГА

